<b>PLSA</b>	Participatory Living Standards Assessment
<b>PTRC</b>	Population Teaching and Research Center
<b>SES</b>	School of Economic Studies
<b>TACIS</b>	Technical Assistance for Common wealth of Independent States
<b>UNDP</b>	United Nations Development Program
<b>UNESCO</b>	United Nations
<b>UNFPA</b>	United Nations Population Fund
<b>WB</b>	World Bank
<b>WHO</b>	World Health Organization

## ГАРЧИГ

Өмнөх үг .....	iv
Ном зүйг ашиглах заавар .....	vii
Товчилсон үгс .....	xxiv
Ном зүй	
1. ЭДИЙН ЗАСАГ .....	7
001. Түмнээ ядууруулна гэж амлаагүй биз дээ .....	9
002. Ядуурал өлсгөлөнг арилгах нь .....	9
003. Азийн хөгжлийн хандлага 2004 .....	9
004. Ядуурал ба хөгжлийн үзүүлэлтүүдийн өгөгдлийн сан (Орч) .....	10
005. Азийн хөгжлийн ерөнхий хандлага 1998: Монгол (Орч) .....	10
006. Улс орны стратеги ба хөтөлбөрийн шинэчлэл 2002-2004 (Орч) .....	11
007. Орон сууцны санхүүжилтийн төслөөр Монголд олгохоор төлөвлөж буй зээлийн талаар захирлуудын зөвлөлд Ерөнхийлөгчийн тавьсан илтгэл, зөвлөмж (Орч) .....	11
008. Хөдөөгийн санхүүжилтийн төслөөр Монголд олгохоор төлөвлөж буй зээлийн талаар захирлуудын зөвлөлд Ерөнхийлөгчийн тавьсан илтгэл, зөвлөмж (Орч) .....	12
009. Монголын ядуурлын хамтын ажиллагааны гэрээний эхний жилийн тоймын тайлан (Орч) .....	13
010. Аймгийн төвийн орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний цогц хөгжлийн төслөөр Монголд олгохоор төлөвлөж буй зээлийн талаар захирлуудын зөвлөлд Ерөнхийлөгчийн тавьсан илтгэл, зөвлөмж (Орч) .....	13
011. Монгол дахь хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналтын тайлан (Орч) .....	14
012. JFPR: MON 36023 Монголын хотуудын гэр хороолол дахь ядуучуудын амьдрах орчинг сайжруулах санал дэвшүүлсэн төслийн баталгаажсан тусламж (Орч) .....	14
013. Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги (Орч) .....	15
014. Монгол Улсын инфляцийн динамик загвар: үнэлгээ, прогноз, нөлөөлөгч хүчин зүйлүүдийн шинжилгээ .....	16
015. Монгол: Шилжилтийн эдийн засаг дахь ядуурлын үнэлгээ .....	16
016. Шилжилтийн үеийн Монгол Улсын албан бус секторын хэмжээ, үүсэл шалтгаан ба шинж чанар (Орч) .....	17
017. Ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжил дэх мал аж ахуй (Орч) .....	18
018. Монголын эдийн засаг, зүүн хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагаа. Зүүн хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагааны хүчин зүйлс (Орч) .....	19

019. Монголд мал аж ахуйн эрсдлийн менежментийн стратегийг боловсруулах- тогтвортой амьжиргааны хэтийн төлвийг хэрэглэх (Орч) .....	19
020. Хотын ядуурлын дүр төрх (Орч) .....	20
021. Монголын төрд арван хүнийг ажилгүй болгож, нэг хүнийг ажилтай байлгах бодлого байж таарахгүй (Орч) .....	20
022. ХХI зууны босгон дээрх Монгол Улсын шинэчлэл, цаашдын хөгжлийн хандлагууд .....	20
023. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрт хийсэн бие даасан үнэлгээ ба 2000 оноос цааших хэтийн хувилбарууд .....	21
024. Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал .....	22
025. Ядуурлыг бууруулах стратегиуд ба хүрээлэн буй орчин: 40 орны завсрын ба эцсийн ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ .....	22
026. Монголын хөдөө аж ахуйн салбарын хумигдах үйл явц ба хотоос хөдөө рүү хүн амын шилжих хөдөлгөөн (Орч) .....	23
027. Монголын ядуурлыг бууруулах нь (Орч) .....	24
028. Маржинализаци (Ялгаварлал) ба Ядуурлын асуудлууд (Орч) .....	24
029. Ядуурал гэдэг зөвхөн эд материалын дутагдал биш (Орч) .....	25
030. Шилжилтийн эдийн засагтай орнуудад ядуурлыг хэмжих нь: Монгол (Орч) .....	25
031. Тэгш бус байдлыг хэмжих нь (Орч) .....	26
032. Монгол Улс (Орч) .....	26
033. Эмэгтэйчүүд ба ядуурал .....	27
034. Ядуурлыг тодорхойлох (Орч) .....	27
035. Монгол Улс: эмзэг бүлгийнхний ядуурлыг бууруулах төсөл (Орч) .....	28
036. Монгол Улс: шилжилтийн эдийн засаг дахь ядуурал, судалгааны тайлан (Орч) ..	28
037. Улс орны ядуурлын төлөв байдлын судалгаа (Орч) .....	29
038. Монголын ядуурлыг бууруулах дунд хугацааны стратегийн баримт бичгийг бэлтгэх туршлага (Орч) .....	29
039. Монгол Улс: Хотын захиргааны санхүүгийн тэмдэглэл (Орч) .....	30
040. Монгол: Ядуурлыг бууруулах үйл ажиллагааны тайлан (Орч) .....	30
041. Бүс нутаг дахь ДНБ-ий хуваарилалт ба Монгол дахь ядуурлын асуудал (Орч) ....	31
042. Хэрэглээний зардал ба эмэгтэйчүүдийн ядуурал: нотолгоог дахин авч үзвэл (Орч) .....	31
043. Монгол Улс: Шилжилтийн эдийн засгийн стратеги (Орч) .....	32
044. Малчин өрхийн мал ахуйн хөгжлөөс мал аж ахуйн хөгжил хамаарна .....	33
045. Ядуурлыг бууруулах макро эдийн засгийн онол, НҮБ-ийн Ази-Номхон далайн бүс нутгийн хөтөлбөрийн эхний ололтууд (Орч) .....	33
046. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (Орч) .....	34
047. Ядуурал, ядуурлыг бууруулах үндэсний бодлого, үйл ажиллагаа .....	34
048. Салбаруудын стратеги ба төслийн саналууд 2001-2004 (Орч) .....	35
049. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр .....	35
050. Рио де Жанейрогийн 1992 оны дэлхийн чуулга уулзалтаас хойш тогтвортой хөгжлийн салбарт Монгол Улсын олсон ололт амжилтын тухай үндэсний илтгэл .....	36

051. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг ...	36
052. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн дунд хугацааны стратеги, 2001-2010 (Орч) ..	37
053. Монголын хүний хөгжлийн илтгэл 1997 .....	38
054. Монголын хүний хөгжлийн илтгэл 2000 .....	38
055. “Хөгжлийн стратегид ядуурлыг бууруулах асуудлыг тусгах нь” сэдэвт үндэсний семинарын тайлан. 1-р дэвтэр .....	39
056. “Хөгжлийн стратегид ядуурлыг бууруулах асуудлыг тусгах нь” сэдэвт үндэсний семинарын тайлан. 2-р дэвтэр .....	39
057. Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн .....	40
058. Сайн засаглал, ядуурал ба ажилгүйдэл .....	41
059. Засгийн газрын дунд хугацааны стратеги болон эдийн засгийн өөрчлөлт, бүтцийн шинэчлэлтийг гүнзгийрүүлэх бодлогууд (Орч) .....	41
060. Олон улсын донор орнуудын хамтын ажиллагаа ба хөгжлийн албан ёсны тусламжийн шаардлага .....	42
061. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг .....	42
062. Монголд хөгжлийн албан ёсны тусламжийг үр дүнтэй ашиглах зөвлөмж .....	43
063. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил 2002 онд .....	43
064. Нийгмийн асуудлууд ба нийгмийн хамгааллын сүлжээ. Монголын эдийн засгийн хөгжлийн хамтарсан судалгаа: зах зээлийн эдийн засагт шилжих гол асуудлууд (Орч) .....	44
065. Ажилгүйдэл, инфляцийн хамаарал .....	45
066. Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн-2001.....	45
067. Ядуурлын оролцооны аргын үнэлгээ, онол ба практикийн танилцуулга (Орч) ...	46
068. Монгол дахь тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд 2000: Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд дээрх судалгааны тайлан (Орч).....	46
069. Монгол дахь хоёр дахь хамтын ажиллагааны хүрээ 2002-2006 (Орч) .....	47
070. Ядуурлыг бууруулах стратегиуд: Ядуурлын мөн чанарын олон хэмжээст байдлыг шийдвэрлэх нь (Орч) .....	48
071. Монгол Улсын зах зээлийн эдийн засаг дахь шилжилт ба ядуурал (Орч) ...	49
072. Хүний ядуурлыг шийдвэрлэж байгаа нь: Ядуурлын Илтгэл 2000 (Орч) .....	49
073. Малжуулалтаар малчин өрхүүдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг баталгаажуулах стратегийн үр дүнг үнэлэх нь .....	50
074. Дэлхийн хүн амын байдал 2002 онд: Хүн ам ба Ядуурал .....	51
075. “Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийн хөгжил” сэдэвт монголын ядуурлыг бууруулах стратегийн асуудлаарх Дэлхийн Банк, Олон Улсын Валютын сангийн хамтарсан зөвлөгөөн (Орч) .....	51
076. Монгол дахь ажилгүйдлийн төлөв байдал, хандлага .....	52
077. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийн үнэлгээ (Орч) .....	53
078. Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг: албан хаагчдын хамтарсан үнэлгээ (Орч) .....	53
079. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн стратеги .....	54
080. Шилжилтийн эдийн засагтай, бага орлоготой, сийрэг суурьшсан орнуудад ядуурлыг бууруулахад тулгарч буй бэрхшээлүүд: Монголын жишээ (Орч) .....	54

081. Монгол Улс (Орч) .....	55
082. Цагаан морин жилээс хар морин жилд: Монгол Улс 12 жилийн шилжилтийн дараа (Орч) .....	55
083. Монгол дахь бичил санхүүгийн дэд салбарын судалгаа .....	56
084. Ядуурал (Орч) .....	56
085. Хүн ам ба ядуурал .....	57
086. АХБ ба Зүүн Хойд Ази (Орч) .....	57
087. Монголын эдийн засаг ба хөдөө аж ахуйн өнөөгийн нөхцөл байдал .....	58
088. Монгол дахь НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, Ядуурлын судалгаа ба ажил эрхлэлтийг дэмжих төсөл MON/01/U01, Сургалтын эрхийн бичгийн хөтөлбөрийн шилжилтийн үеийн үнэлгээ ба хөдөлмөр эрхлэлтийн төв албанд өгөх санал, зөвлөмж (Орч) .....	58
089. Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлын үнэлгээ (Орч) .....	59
090. Монгол дахь ядуурал .....	60
091. Монголын ядуурлын төлөв байдал (Орч) .....	60
092. Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын орчин үеийн хандлага .....	61
093. Ядуурал юунаас болж байна вэ? .....	61
094. Хүн амын амьжиргааны түвшин ба ядуурлын статистик .....	62
095. Монгол Улс (Орч) .....	63
096. Цаг ашиглалтын туршилтын судалгаа 2000 .....	63
097. Монголын ядуурлын статистик (Орч) .....	64
098. Монголын амьжиргааны түвшний оролцооны аргын судалгаа 2000 (Орч) ...	64
099. Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998 .....	65
100. Монголд үйл ажиллагаа явуулдаг бусад доноруудын үйл ажиллагааны дүр төрх ба үнэлгээ (Орч) .....	66
101. 2003 оны ахиц дэвшлийн тайлан (Орч) .....	66
102. Микростарт Монгол төслийн эцсийн үнэлгээний тайлан (Орч) .....	67
103. Орон сууцны хувьчлалын ядуурал, тэгш бус байдалд үзүүлсэн нөлөөллийн судалгаа ...	67
104. Хүнсний аюулгүй байдал .....	68
105. Ядуурлыг бууруулах стратегид хөдөөгийн ядуурлын асуудлуудыг бүтээлчээр тусгах шаардлага ба зарим арга зүй (Орч) .....	68
106. Монголын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд ...	69
107. Эдийн засгийн өсөлт, ядуурал ба орлого хуваарилалт .....	69
108. Монгол дахь ядуурлын хэмжилтийн гажиг (Орч) .....	70
109. Монголын ядуурал: 1995, 1998 онуудын Амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнг харьцуулах нь (Орч) .....	71
110. Бодлогыг хяналттай холбох нь (Орч) .....	71
111. Монголын эдийн засгийн хөгжил ба дунд хугацааны стратегийн өнөөгийн төлөв байдал, Зүүн хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагааны хүчин зүйлс (Орч) .....	72
112. Монгол дахь ядуурлын дүр төрх, хүрээ тэлэлт .....	72
113. Монголын эдийн засгийн хөгжил ба ядуурал .....	73

114.	Монголын хүн амын ядуурал ба амьжиргааны байдал .....	73
115.	Монголын хөдөөгийн ядуурал .....	74
116.	Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 1994-2000 .....	75
117.	Монголын ядуурлын дүр төрхийн тойм (Орч) .....	75
118.	Зүүн Ази: Шилжилтийн үеийн Монгол Улс (Орч) .....	76
119.	Ядуурлыг бууруулахад аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг оролцоо .....	75
2.	НИЙГЭМ .....	79
120.	Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үеийн төрөлтийн төлөв байдлын өөрчлөлт: Монголын жишээ (Орч) .....	81
121.	Монгол Улсын стратеги төлөвлөгөө: 2000-2004 (Орч) .....	81
122.	Монгол: Далд аюул (Орч) .....	82
123.	ДЭМБ-ийн улс орны хамтын ажиллагааны стратеги: Монгол Улс (Орч) ....	82
124.	Глобаль эрүүл мэндийн шинэчлэл дэх тэгш байдал: социализмын дараах үеийн Монгол Улсын жишээ (Орч) .....	83
125.	Нүүдлийн малчдад зориулсан боловсролын хангамж (Орч) .....	83
126.	Ядуурлыг бууруулах тухай чуулган, засгийн газрын бус байгууллагуудын симпозиумын тайлан (Орч) .....	84
127.	Залуучуудын асуудлаар МУ-ын ЗГ болон НҮБ-ын системийн хоорондох ойлголцлын санамж бичиг 1998.05-2001.05 (Орч) .....	85
128.	Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал .....	86
129.	Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг .....	86
130.	Хүүхдийн хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр 2002-2010 (Орч) .....	87
131.	Монголын хүний хөгжлийн илтгэл 2003 .....	87
132.	Монгол улсын жендэрийн үнэлгээ (Орч) .....	88
133.	Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000 ...	89
134.	Нийгмийн хөгжлийн асуудалд .....	90
135.	Хүнсний аюулгүй байдал ба хүнс тэжээлийн хангамжид холбоотой НҮБ-ийн Агентлагууд болон тэдгээрийн үйл ажиллагааны тодорхойлолт 1998-1999 (Орч) .....	90
136.	Жендэрийн товч хэрэглэгдэхүүнүүд (Орч) .....	91
137.	Монгол Улсын нийгмийн секторт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагуудын түүвэр судалгааны тайлан, Менежментийн академийн зөвлөгөө өгөх бизнес төв, Тогтвортой хөгжлийн жендэр төв, “zbn” зөвлөгөө өгөх нэгжтэй хамтарсан судалгаа (Орч) .....	92
138.	1999 оны жилийн тайлан: Монгол Улс дахь НҮБ-ын систем I хэсэг (Орч) .....	93
139.	Монголын хөдөө дэх жендерийн дүр зураг: Бодлогод тусгах тоо баримт, мэдээллүүд .....	93
140.	Монгол Улс (Орч) .....	94
141.	Монгол Улс: эмзэг бүлгийнхний ядуурлыг бууруулах төслийн хэрэгжилтийн үнэлгээ (Орч) .....	94
142.	Шилжилтийн нөхцөл дэх жендерийн асуудалд .....	95
143.	Шилжилт, ядуурал ба Монгол Улс дахь нийгмийн тусламж (Орч) .....	96

144.	Монгол дахь ядуурлыг бууруулахад нийгмийн секторыг шинэчлэх нь (Орч) .....	96
145.	Монгол Улс (Орч) .....	97
146.	Монгол дахь хүний нөөцийн хөгжил ба сургалт: үзэл бодол ба санал (Орч) .....	97
147.	Монгол Улсын жендерийн байдлын үнэлгээ (Орч) .....	98
148.	Монголын хүйсийн байдал: 2000 оны тооллогод үндэслэсэн судалгаа (Орч) .....	99
149.	Монгол Улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр .....	100
150.	Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах замаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах нь (Орч) .....	101
151.	Нийгмийн хамгаалал .....	101
152.	Монгол Улс: Рашаант баг, Булган, Говь-Алтай, Өвөрхангай (Орч) .....	102
153.	Монгол Улсын НХХЯ, ЭМЯ-наас хийсэн ажилчдын Нөхөн үйлдвэрлэлийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдсон судалгааны нөхцөл байдлын илтгэл (Орч) .....	102
154.	Орон нутагт ядуурал, ажилгүйдэл буурч, сургууль завсардалт нэмэгджээ ...	103
3.	ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ .....	105
155.	Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай Илтгэл-2002 ...	107
156.	Нийгмийн эмзэг бүлгийн эрхийн төлөв байдал .....	107
157.	Монгол дахь хүний эрхийг бэхжүүлэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (Орч) .....	108
158.	Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль .....	108
159.	Нийгмийн даатгалын тухай хууль .....	109
160.	Боловсролын тухай хууль .....	109
161.	Эрүүл мэндийн тухай хууль .....	110
162.	Нийгмийн халамжийн тухай хууль .....	110
163.	Хөдөлмөрийн тухай хууль .....	111
164.	Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль .....	111
165.	Монголтой хийх хөгжлийн хамтын ажиллагааны стратеги, 2002-2006 (Орч) ...	112
4.	УЛС ТӨР .....	113
166.	Монгол Улсын дотоод бодлогод хандивлагчдын хамтын нийгэмлэгийн нөлөөлөл ...	115
167.	Засаглал ба ядуурал .....	115
168.	Сайн засаглал, түүний ядууралд үзүүлж буй нөлөө: Монгол дахь улсын секторын шинэчлэл (Орч) .....	116
169.	Засаглалын оролцоо ба ядуурлыг бууруулах (Орч) .....	116
170.	Монголын шилжилт ба ардчилал (Орч) .....	117
5.	БАЙГАЛЬ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН .....	119
171.	Монгол Улсын байгаль орчин: Азийн Хөгжлийн Банкны үйл ажиллагааны оролцоо (Орч) .....	121
172.	Монгол дахь гамшгийн хохирлыг бууруулах санхүүгийн нөөц ба түүний хуваарилалт (Орч) .....	121
173.	Зүүн Хойд Ази дахь бага оврын эрчим хүчний хөгжил: Монголын нарны эрчим хүч ашиглалтын туршлага, хэтийн төлөв, нийгмийн ач холбогдол (Орч) ....	122
174.	Зуд 2000: Учирч буй экологи, нийгэм, эдийн засгийн гамшиг. Яаралтай шаардагдах зүйлсийг үнэлсэн илтгэл (Орч) .....	123
175.	Монголын мал аж ахуйн салбар нь эдийн засаг болон хүмүүст чухал ач холбогдолтой боловч байгалийн үзэгдэлд эмзэг (Орч) .....	123
	Хавсралт .....	125



1

ЭДИЙН ЗАСАГ

**001**

**Авирмэд, С. (2001.03.29). “Түмнээ ядууруулна гэж амлаагүй биз дээ”  
Монголын мэдээ, №061 (556).**

*Нийтлэл, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, үнийн өсөлт

*JEL:* I30, E31

Ядуурлыг тодорхойлдог дэлхий нийтийн үзүүлэлт, жишгийг дурдаад Монгол дахь ядуурал яагаад нэмэгдсэн талаар өөрийн хийсэн судалгааны үр дүнг орон сууц, үйлчилгээний үнийн өсөлтөөр харьцуулан авч үзжээ.

*Энэ нийтлэл нь Монгол дахь ядуурлыг бууруулахад судлаачийн өөрийн санал, дүгнэлт, зөвлөмжийг багтааснаараа онцлог юм.*

**002**

**Адъяасүрэн, Ц., Баажийхүү, Д., Гантigmaа, Д., Солонго, А., Дэмбэрэл, А. (2003).  
Ядуурал өлсгөлөнг арилгах нь. Монгол, Улаанбаатар.**

*Номын бэлэг, 7 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* хэрэглээ, нөөц, орлого, хотжилт, хэрэглээний сагс

*JEL:* E21, D31

Сурах бичгийн зориулалттай. Хүн амын амжиргааны доод түвшин гэж юу болох, ядуурлыг хэрхэн тодорхойлдог, ядуурлын шинж байдлыг тодорхойлох ямар үзүүлэлтүүд байдгийг тайлбарлажээ. Ядуурлыг бууруулах зорилгоор Монголд хийгдэж байгаа ажлууд, олон улсын тусламжийн талаар дурьдсан байна.

*Сурах бичгийн зориулалттай учир цндсэн ойлголт, тодорхойлолтуудыг тайлбарлах байдлаар бичигдсэн. Ядуурлын асуудлыг сонирхон, эхлэн судалж буй хүмүүст тохиромжтой, илүү ач холбогдолтой болно.*

**003**

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2004). Mongolia:  
Asian Development Outlook 2004 (Азийн хөгжлийн хандлага 2004). (х 60-63).**

*Номын бэлэг, 4 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Өсөлт, хөгжил, ядуурал

*JEL:* I30, O10

Энэ бүлэгт, Монголын эдийн засгийн өнөөгийн байдлыг шинжлэн дүгнээд, 2004-2005 оны эдийн засгийн төлөв байдал, хандлагад прогноз хийсэн байна. Монгол Улсын эдийн засаг сэргэж, орлогын бус ядуурлыг бууруулах талаар ахиц дэвшил гарч байвч, хөдөө болон хотын гэр хороололд оршин суугчид түүний үр шимийг төдийлөн тэгш хүртэж чадахгүй байна. Монголын эдийн засгийн өсөлт 2004, 2005 онуудад тус бүр 6 хувь байхаар хүлээгдэж байна гэжээ.

Энэ нь Монголын эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдийн өнгөрсөн оны төдийгүй ирэх 2004, 2005 онд хцлээгдэж буй утгуудыг агуулснаараа ядуурлын цаашдын хандлагыг судлахад хэрэглэгдэх боломжтой.

#### 004

**Азийн хөгжлийн банк (Asian Development Bank). (2004). Poverty and development indicators database (Ядуурал ба хөгжлийн үзүүлэлтүүдийн өгөгдлийн сан).**

[http://www.adb.org/Documents/Slideshows/Fighting\\_Poverty/Fighting\\_Poverty.pdf](http://www.adb.org/Documents/Slideshows/Fighting_Poverty/Fighting_Poverty.pdf)

Тайлан, 15 хуудас, англи

*Түлхүүр үгс:* ядуурал, ядуурлын түвшин,

*JEL:* I32, C82

Ядуурал ба хөгжлийн үзүүлэлтүүдийн өгөгдлийн сан хэмээх энэ тайлангийн зорилго нь АХБ-ны “Ази, номхон далайн орнуудын ядууралтай тэмцэх” зорилгод хүрэх стратегийн дэмжлэгтэй байгуулагдсан АХБ-ны буурай хөгжилтэй гишүүн орнуудын эдийн засгийн хөгжил болон ядуурал, ядууралтай холбоотой үзүүлэлтүүдийн сангаас шаардлагатай мэдээллээр хэрэглэгчдийг хангахад нь туслах явдал юм. Өгөгдлийн сан нь орон тус бүрийн 121 үзүүлэлтүүдийн динамикийг агуулсан бөгөөд тэдгээрийг вэбээс үзэх боломжтой. Түүнчлэн ойлголт, тодорхойлолт, эх сурвалж, арга зүй болон чанарын өгөгдлүүдийн судалгааг агуулжээ. Өгөгдлийн сан нь улс орнуудыг хооронд нь харьцуулах, ядуурлын үзүүлэлтүүдээр бүс нутгийн үнэлгээ хийх боломжтой.

*Эрдэмтэн, судлаачид, багш, оюутнууд, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид өргөнөөр ашиглах боломжтой. Энэхүү өгөгдлийн сан нь их хэмжээний мэдээлэл агуулснаас гадна тэдгээрийг хэрхэн хайх, ашиглах тухай заавар зөвлөмжийг агуулснаараа ач холбогдолтой ажил болжээ.*

#### 005

**Азийн Хөгжлийн Банк. (Asian Development Bank). (1998). Asian development outlook 1998: Mongolia. (Азийн хөгжлийн ерөнхий хандлага 1998: Монгол).**

<http://www.adb.org/...>

Номын бэлэг, 4 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, шилжилтийн эдийн засаг

*JEL:* I30, P20

Урт хугацааны хөгжлийн хандлага болон ядуурлыг бууруулахад чиглэсэн асуудлуудад Засгийн газар анхаарлаа хандуулж эхэлж байна. Хүн амын 36 орчим хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна. Ядуу хүмүүсийн дийлэнх нь аймгийн төвүүдэд амьдарч байна. Улсын үйлдвэрийн газрууд хаагдаж, улсын төсвөөс татаас өгөхөө больсноор ядуурал өссөн. Засгийн газраас улсын секторт хөдөлмөр хэмнэсэн хөтөлбөр хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлыг улам доройтуулсан, гэвч ядуурал болон ажилгүйдэл гэсэн асуудлыг шийдвэрлэхийн тулд хурдан, тогтвортой өсөлт, аж үйлдвэрийн хүчин чадлыг дахин сэргээх шаардлагатай

байна. Одоогоор ядуурлыг бууруулах үүрэг бүхий агентлагууд нь өөрсдийн ажил, үйл ажиллагааг зохицуулах чадвар муутай байгаагаас ядуурлыг бууруулах үр нөлөөтэй, боловсронгуй стратеги боловсруулахад хүндрэлтэй байгааг дурьджээ.

*Монголд ядуурал бий болсон шалтгаан, тццнийг бууруулахад учирч буй хүндрэл бэрхшээлийг харуулсан мэдээллийн ач холбогдолтой ажил болжээ.*

## 006

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2001). Country strategy and program update 2002-2004 (Улс орны стратеги ба хөтөлбөрийн шинэчлэл 2002-2004).**

[http://www.adb.org/Documents/CSPs/MON/2002/CSP\\_MON\\_2001.pdf](http://www.adb.org/Documents/CSPs/MON/2002/CSP_MON_2001.pdf)

*Баримт бичиг, 48 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, орлого хуваарилалт, ажилгүйдэл, нийгмийн халамж

*JEL:* I30, O15, H55, E24

Уг хөтөлбөрийн зорилго нь хүн амын амьжиргааг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд төрөөс нийгмийн халамжийн үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлэх, орлого хуваарилалтыг сайжруулах явдал юм гэжээ. Ядуурлыг тууштай бууруулах нь төрийн үндсэн зорилгуудын нэг бөгөөд хөтөлбөр боловсруулалтын хүрээнд эдийн засгийн гол салбаруудын өсөлт нь ядуурлыг бууруулахад хэрхэн нөлөөлж буйг судалжээ. Сайн засаглал, хүний хөгжил болон эдийн засгийн өсөлтийг урамшуулахад чиглэсэн өөрчлөлт, шинэчлэлийг үргэлжлүүлэн хийснээр ядуурлыг бууруулна гэж онцлон тэмдэглэжээ.

*Энэ хөтөлбөр нь Монгол Улсын үйл ажиллагааны стратегийн хэрэгжилтийг авч үзэн цаашид цргэлжлцлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт өгсөнөөрөө бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдэд нэн ач холбогдолтой ажил болжээ.*

## 007

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2001). Report and recommendation of the president to the board of directors on a proposed loan to Mongolia for the housing finance (sector) project (Орон сууцны санхүүжилтийн төслөөр Монголд олгохоор төлөвлөж буй зээлийн талаар захирлуудын зөвлөлд Ерөнхийлөгчийн тавьсан илтгэл, зөвлөмж).**

[http://www.adb.org/Documents/RRPs/Mon/rrp\\_32017\\_mon.pdf](http://www.adb.org/Documents/RRPs/Mon/rrp_32017_mon.pdf)

*Тайлан ба зөвлөмж, 81 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Бага болон дунд орлоготой өрхүүд, ядуурал, нийгмийн эмзэг хэсэг, ажилгүйдэл, амьжиргааны түвшин

*JEL:* O15, I30, E24, I31

Энэ илтгэл нь Монгол дахь орон сууцны хомсдлыг багасгах, бага болон дунд орлоготой өрхүүд орон сууцны санхүүжилтийн зээлээ зах зээлийн зарчмаар олж авах боломжийг сайжруулах,

гэр хороололд амьдрагсдын ядуурлыг бууруулах, орон сууцны зээлд хамрагдах боломжийг олгосноор бага болон дунд орлоготой өрхүүдийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх зорилготой төслийг хэрэгжүүлэгчдэд өгөх зөвлөмж юм. Төслийн зорилтот хэсэг бол бага болон дунд орлоготой өрхүүд болно. Энэхүү төсөл нь Азийн Хөгжлийн Банкнаас Монголтой хамтран явуулж буй аливаа үйл ажиллагаа нь ядуурлыг бууруулахад чиглэнэ гэсэн үзэл баримтлалд нийцэж байгаа юм. Энэхүү баримт бичиг нь төслийн агуулга, зардлын тооцоо, эдийн засаг, нийгэм, ядууралд үзүүлэх нөлөөллүүдийг бүрэн судалж, судалгаанд үндэслэн санал зөвлөмжүүдийг гаргажээ.

*Энэ нь төсөл хэрэгжүүлэхэд гарын авлага болохуйц маш чухал баримт бичиг бөгөөд бодлого боловсруулагч болон хэрэгжүүлэгч нарт зориулагджээ. Төслийн хүлээгдэж буй үр дүнг болон үр ашгийг хүртэгчдийг тодорхой гаргаснаараа хэрэгжилтийг үнэлэхэд амар хялбар болгосон байна.*

## 008

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2001). Report and recommendation of the president to the board of directors on a proposed loan to Mongolia for the rural finance project (Хөдөөгийн санхүүжилтийн төслөөр Монголд олгохоор төлөвлөж буй зээлийн талаар захирлуудын зөвлөлд Ерөнхийлөгчийн тавьсан илтгэл, зөвлөмж).**

[http://www.adb.org/Documents/RRPs/MON/rrp\\_28201.pdf](http://www.adb.org/Documents/RRPs/MON/rrp_28201.pdf)

*Тайлан ба зөвлөмж, 82 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Хөдөөгийн ядуурал, ядуурлын шугам, нэн ядуу, ажилгүйдэл, орлогын эх үүсвэр  
*JEL:* I30, I31, E24

Уг илтгэлийн зорилго нь хөдөөгийн ядуус хадгаламж зээлийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих нөхцлөөр хангах зорилготой төслийн хэрэгжилтэд санал зөвлөмж өгөх явдал юм. Төслийн хүрээнд хөдөөгийн өрхүүдийг, ялангуяа ядуусыг хадгаламж зээлийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төслийн үндэслэл, шаардлага, зардлын шинжилгээ, байгаль орчны үнэлгээ, нийгэм болон ядууралд үзүүлэх нөлөөллүүдийг тооцож харуулжээ. Судалгаанд үндэслэн холбогдох зөвлөмжүүдийг санал болгосон байна.

*Энэ илтгэл нь хөдөөг санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд гарын авлага болох чухал баримт бичиг юм. Бодлого боловсруулагч болон хэрэгжүүлэгч нарт зориулагдсан. Төслийн хүлээгдэж буй үр дүнг болон үр ашгийг хүртэгчдийг тодорхой гаргаснаараа төслийн хэрэгжилтийг үнэлэхэд амар хялбар болгож байна.*

## 009

**Азийн хөгжлийн банк (Asian development bank). (2001). “Report of the first annual review of the Mongolia poverty partnership agreement”. (Монголын ядуурлын хамтын ажиллагааны гэрээний эхний жилийн тоймын тайлан). <http://www.adb.org/...>**

*Тайлан, 8 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлыг бууруулах бодлого  
*JEL:* I38, I32

Уг тайлан нь үндсэн таван хэсгээс бүрдэж байна. Нэгдүгээр хэсэгт, өмнөх үг, товч мэдээлэл, хоёрдугаарт, өнөөгийн хөгжил, гуравдугаарт, МЯХАГ-ний зорилтуудыг биелүүлэхэд чиглэгдсэн үйл явц, дөрөвдүгээрт, МЯХАГ-ийн үндсэн зорилго болон гүйцэтгэлийг хянах үзүүлэлтүүд гэсэн хэсгээс бүрдэнэ. Өнөөгийн хөгжил хэсэгт засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг дурьдаад энэ үйл ажиллагааны хөтөлбөр нь МЯХАГ-тэй нийцэж байна гэжээ. Мөн байгалийн гамшиг, шокод өртөх эмзэг байдал нэмэгдэж орлогоор хэмжсэн ядуурлын түвшин тогтворжиж, эрүүл мэнд, хоол хүнс, боловсролоор хэмжсэн ядуурал өсч, хот хөдөөгийн ялгаа нэмэгдэж байна гэжээ. Гуравдугаар хэсэгт уг гэрээг биелүүлэхэд засгийн газар, АХБ болон ОНБ-ууд ямар үйл ажиллагаа явуулж байгааг авч үзсэн. Жишээ нь ОНБ-ууд ядуурлыг бууруулах төслүүдийг гүйцэтгэх, засгийн газарт зөвлөгөө өгөхөд гол үүрэг гүйцэтгэж байна гэжээ. Засгийн газраас үндсэн зорилтуудыг дэмжиж байгаа ч зорилтууд нь биелэгдэх боломжтой эсэхийг хянах хэрэгтэй байна. Эцэст нь, уг тайланд дараагийн гурван жилийн хөтөлбөрийн хандлага чиглэлийг тодорхойлсон. АХБ нь засгийн газрын стратегийн бодлогыг дэмжиж ажиллах бөгөөд энэ хүрээнд хөдөө орон нутгийн ядуурал болон бүс нутгийн тэнцвэртэй хөгжилд илүү анхаарах болно гэсэн байна.

*МЯХАГ-ний явц болон хэрэгжилтийг тайлагнаж цаашдын үйл ажиллагааны зорилго чиглэлийг тодорхойлж өгснөөрөө олон нийтэд мэдээллийн ач холбогдол бүхий ажил болжээ.*

## 010

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2002, 7 сар). Report and recommendation of the president to the board of directors on a proposed loan to Mongolia for the integrated development of basic urban services in provincial towns project (Аймгийн төвийн орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний цогц хөгжлийн төслөөр Монголд олгохоор төлөвлөж буй зээлийн талаар захирлуудын зөвлөлд ерөнхийлөгчийн тавьсан илтгэл, зөвлөмж). [http://www.adb.org/Documents/RRPs/Mon/gpr\\_31243.pdf](http://www.adb.org/Documents/RRPs/Mon/gpr_31243.pdf)**

*Тайлан ба зөвлөмж, 57 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны түвшин, тэгш бус байдал, бага орлоготой хэсэг, нэн ядуу  
*JEL:* I30, I31, O15

Уг илтгэлийн зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих, хотын ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааны нөхцлийг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулах зорилготой төсөл хэрэгжүүлэх зөвлөмж өгөхөд оршино. Азийн хөгжлийн банкны оролцоо нь эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулан бүс нутгийн үр ашигтай хөгжлийг урамшуулах, амьжиргааны түвшинг сайжруулах, ядуурлыг бууруулах, цэвэр ус, халаалт

дулаан, эрүүл мэндийн үйлчилгээнд хийх хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах зэрэгт үндэслэнэ. Төслийн нийгэм, байгаль орчин ба ядууралд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон санхүүгийн болон эдийн засгийн шинжилгээг хийж, санал зөвлөмжүүдийг гаргажээ.

*Энэ илтгэл нь төслийг хэрэгжүүлэхэд гарын авлага болох маш чухал баримт бичиг юм. Бодлого боловсруулагч болон хэрэгжүүлэгч нарт зориулагдсан. Төслийн цр ашгийг хүртэгчид болон хчлээгдэж буй цр дунг тодорхой гаргасан нь хэрэгжилтийг үнэлэхэд амар хялбар болгож байна.*

## 011

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2002). Program performance audit report on the agriculture sector program in Mongolia (Монгол дахь хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналтын тайлан).**

<http://www.adb.org/Documents/PERs/PE586.pdf>

*Тайлан, 50 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны түвшин, хүнсний аюулгүй байдал

*JEL:* I30, I31, H56

Уг тайлан нь Монголд хэрэгжүүлсэн Хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилготой юм. Хөдөө аж ахуй салбарт өрсөлдөөнт зах зээлийн хэлбэрийг урамшуулах, ингэснээр нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судалжээ. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг урамшуулах ажлын хүрээнд нийгмийн асуудлуудыг авч үзсэн ба уг төслийн хүрээнд шийдвэрлэх боломжтой асуудлуудыг судалсан байна. Хөдөөгийн хөгжил нь ядуурал, хүнсний аюулгүй байдалтай салшгүй холбоотой болохыг тодорхойлсон ба төслийн хэрэгжилтийн үр дүнд хөдөөгийн ядуурлыг бууруулахад оруулсан хувь нэмрийг үнэлсэн байна.

*Энэ тайлан нь бодлого боловсруулагч, төслийг хэрэгжүүлэгч болон мэргэжилтэн судлаачид ашиглахад тохиромжтой. Төслийн хэрэгжилтийн яву, удирдлага зохион байгуулалт, хөтөлбөрийн цр дүн зэргийг зорилго зорилттой нь уялдуулан гаргаж иржээ. Нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлсэн нөлөөлцүүдийг үнэлсэн ба цаашид хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний зөвлөмж гаргаснаараа ач холбогдолтой юм.*

## 012

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2002). JFPR: MON 36023 Proposed Grant Assistance (Financed from the Japan Fund for Poverty Reduction) to Mongolia for the Improving the Living Environment of the Poor in Ger Areas of Mongolia's Cities Project (JFPR: MON 36023 Хотуудын гэр хороолол дахь ядуучуудын амьдрах орчинг сайжруулах явцад үзүүлэх тусламжийн төсөл (Ядуурлыг бууруулах Япон сангаас санхүүжүүлэгдсэн))**

[http://www.adb.org/Documents/JFPRs/MON/jfpr\\_mon\\_36023.pdf](http://www.adb.org/Documents/JFPRs/MON/jfpr_mon_36023.pdf)

*Төслийн баримт бичиг, 29 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, хотын ядуурал, ядуу өрх, бага орлоготой нийгмийн бүлэг

*JEL:* I30, R23

Монгол Улсын ЗГ, АХБ-аас Ядуурлыг Бууруулах Япон Сангаар дамжуулан хотуудын гэр

хороолууд дахь ядууралд өртсөн өрхүүдийн ядуурлыг бууруулах төсөл бэлтгэх зорилготой. Уг төсөл нь манай Улсын төвийн болон зүүн бүсийн 10 аймгийн төв, Улаанбаатар хотыг сонгон авч тэдгээрийн гэр хорооллын өрхүүдийн хувьд дээрх зорилтыг хангах үндсэн 4 боломжит ажлыг санхүүжүүлж хэрэгжүүлэх болсон байна. Уг төсөл хэрэгжснээр сонгож авсан 11 хотын 25 гэр хороололд харьяалагдах ойролцоогоор 90 мянган нэн ядуу, ядуу, бага орлоготой хүмүүс шууд болон шууд бус байдлаар үр ашгийг нь хүртэх боломжтой гэсэн урьдчилсан үнэлгээг гаргасан байна.

*Энэ төслийн гол зорилго нь хотын ядууралд илүү чиглэгдсэн бөгөөд тэр дундаа амьдрах орчин нөхцөл нэн тааруу гэр хорооллын хувьд ядуурлыг бууруулах тогтвортой, цр ашигтай бодлого, арга хэрэгсэл олох, шинэлэг зүйл эрж хайх явдал байв. Энэ нь ядуурлыг бууруулахад гадны санхүүжилттэй төслийн бүтэц, нөхцөл байдлыг үнэлэн үйл ажиллагаагаа хэрхэн тодорхойлж байгаа, төслийн удирдлагын бүтэц, төслийн ажиллах төлөвлөгөө зэрэг асуудлыг сонирхсон хүн бүрт мэдээлэл, гарын авлага болох боломжтой юм.*

### 013

#### **Азийн хөгжлийн банк (Asian Development Bank). (2000). Country Operational Strategy (Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги).**

*Тайлан, 28 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, орлого хуваарилалт

*JEL:* I30, O15

АХБ-наас Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратегийг 1994 онд бэлтгэсэн. Уг стратегийн зорилго нь өрсөлдөөнт үр ашигтай зах зээлийн эдийн засгийн орчныг бий болгох, зах зээлийн эдийн засагт зайлшгүй шаардлагатай хүний нөөц, ур чадварыг хөгжүүлэх, зах зээлийн эдийн засагт шаардлагатай дэд бүтцийг бий болгох замаар шилжилтийн үйл явцыг хурдасгах явдал гэжээ. Улс орны үйл ажиллагааны стратеги нь ядуурлын асуудалд шууд чиглэгдээгүй эдийн засгийн өсөлтийг дэмжсэнээр ядуурлыг бууруулахад хангалттай нөхцлийг бий болгох ёстой гэж үзсэн. Монгол Улс шинэчлэлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд Монголд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратегийн хэрэгжилтийн эхэн үед эдийн засгийн өсөлт эерэг, боломжийн өндөр түвшинд байсан. Гэхдээ эдийн засгийн өсөлт нь урьдчилан төлөвлөж байснаар ядуурлыг болон ажилгүйдлийг бууруулж чадаагүй. ДНБ-д хувийн секторын эзлэх хувь өссөн нь зөвхөн хувьчлалын бодлогын үр дүнтэй холбоотой юм. Нөгөө талаар, эдийн засгийн салбарт сайн засаглалын үндсэн элементүүдийг хүчтэй болгох бодлого нь шинэчлэлийн шаардлагаас хоцорсон байна. Шинэ стратегийн хүрээнд ядуурлыг бууруулахад түлхүү анхаарах бөгөөд АХБ-аас хэрэгжүүлж байгаа бүх хөтөлбөр төсөлд цаашид сайн засаглалын элементүүдийг заавал оролцуулах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн байна. Шинэ стратеги нь эдийн засгийн өсөлтийг дэмжих болон ядуурлыг бууруулахын тулд хувийн секторт гол анхаарлаа хандуулна гэжээ. Уг ажлын хүрээнд Монголын ядуурлын асуудлыг өргөн хүрээнд авч үзсэн байна. Ядуурлын шинж байдал, түүнийг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагаа, арга хэмжээ ялангуяа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзжээ.

*Судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан бөгөөд ядуурлын талаар өргөн*



хэмжээний мэдээлэл агуулснаараа ядуурлын талаарх асуудлыг сонирхож буй оюутан, судлаач нарт ач холбогдол бүхий ажил болжээ. Уг тайлан нь ядуурлыг бууруулахад сайн засаглал чухал гэдгийг тэмдэглэсэн бөгөөд 1994-2000 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны алдаа, оноог дүгнэж, цаашдын үйл ажиллагааныхаа зорилго, чиглэлээ тодорхойлсноороо онцлог юм.

#### 014

**Алтанцэцэг, Б. (2002). Монгол Улсын инфляцийн динамик загвар: үнэлгээ, прогноз, нөлөөлөгч хүчин зүйлүүдийн шинжилгээ. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, шалгуур үзүүлэлтүүд: илтгэлүүдийн эмхэтгэл (х 15-35). Монгол, Улаанбаатар.**

*Өгцүлэл, 21 хуудас, монгол*

*Түлхүүр цгс:* Инфляци, ядуурал, амьжиргааны түвшин  
*JEL:* I30, E31, I31

Уг судалгааны зорилго нь Монгол Улсын инфляцийн динамик загварыг байгуулж, 1993-2000 оны эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан үнэлгээ хийх, инфляцид нөлөөлөгч хүчин зүйл, үзүүлэлтүүдийг тодорхойлох явдал юм. Эдийн засгийн аюулгүй байдлыг тодорхойлогч үзүүлэлтүүдийн нэг болох инфляци нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлого төдийгүй ядуурлын эсрэг үр ашигтай бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна. Өндөр инфляцитай үед цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт үнийн өсөлтөөс хол хоцорч хүмүүсийн бодит орлого, улмаар амьжиргааны түвшин буурч байв. Уг ажлын хүрээнд инфляцийн загварыг тодорхойлон, боломжит прогноз хийсэн болно. Ажлын үр дүнд инфляцийг таамаглах гол үзүүлэлт нь M1 ба M2 мөнгө, валютын ханш бөгөөд харин богино хугацаанд ДНБ инфляцийн таамаглалыг сайжруулж байна гэж дүгнэжээ.

*Эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн нэг болох инфляцийг судлан динамик загвар гаргаснаараа нэн ач холбогдолтой болжээ. Илтгэлүүдийн эмхэтгэлийг албан ажлын хэрэгцээнд зориулан гаргасан. Судалгааг цаашид гүнзгийрүүлэн өргөжүүлэх боломжуудыг онолын болон өгөгдлийн хувьд тодорхойлсон байна.*

#### 015

**Ананд, П., Елбирт, К., Хоссайн, Ш., Козел, В., Суббарао, К. (1996). Монгол: Шилжилтийн эдийн засаг дахь ядуурлын үнэлгээ. Дэлхийн Банк.**

*Баримт бичиг, 89 хуудас, монгол*

*Түлхүүр цгс:* ядуурлын шугам, амьжиргааны түвшин, үйлчилгээний хүртээмж  
*JEL:* I30, I31

Ядуурлын эдийн засаг, хүн ам, бүс нутаг, нийгмийн шинж чанарыг гүнзгий ойлгох, нийгмийн хөгжлийн бодлогыг боловсруулах, ядуурлыг бууруулахад нөөц хөрөнгийг тодорхой зорилготой хуваарилах, хоёр болон олон талын хандивлагчид, Засгийн газрын бус байгууллагуудаас ядуурлыг бууруулахад үзүүлж байгаа тусламжийн хэлбэр, үр өгөөжийг үнэлжээ. Илтгэлд

тусгагдсан дүн шинжилгээг 1995 оны 6 сард хийгдсэн амьжиргааны түвшинг хэмжих судалгаанд түшиглэж хийжээ. Илтгэлд ядуурлын дүр төрх, амьжиргааны түвшнийг хэмжих арга, нийгмийн үйлчилгээний хүртээмж, ядуурлыг бууруулах хэтийн төлвийг авч үзжээ.

*Энэхүү илтгэл нь Монгол дахь ядуурлын байдалд хийсэн анхны иж бүрэн үнэлгээ болжээ. Хандивлагчид болон Засгийн газрын бус байгууллагуудаас ядуурлыг бууруулахад үзцүлж ирсэн тусламжийг үнэлснээр тэдгээрийн цаашдын цйл ажиллагаа, чиглэлийг боловсронгуй болгоход тус дөхөм болгож байна.*

## 016

**Андерсон, Ж.Х (James H.Anderson). (1998). The Size, Origins and Character of Mongolia's Informal Sector During the Transition (Шилжилтийн үеийн Монгол Улсын албан бус секторын хэмжээ, үүсэл шалтгаан ба шинж чанар). World Bank Policy Research Working Paper 1916,**

**<http://www.worldbank.org/html/dec/Publications/Workpapers/WPS1900series/wps1916/wps1916.pdf>**

*Нийтлэл, 67 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* албан бус сектор, ядуурал

*JEL:* O17, I30

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоо уруу шилжиж байгаа үед албан бус худалдаа, аж үйлдвэрлэлийн үйл ажиллагааны огцом өсөлт нь найзархаг, гэхдээ хүн ам сийрэг оршин амьдардаг Азийн энэ оронд гарч байгаа ил мэдрэгдэх нэгэн өөрчлөлт юм. Шилжилтийн үеийн албан бус секторын тухай мэдлэгээ гүнгийрүүлэх зорилгын үүднээс энэ судалгаанд олон төрлийн арга аргачлал, Улаанбаатар хотоос түүвэрлэсэн 770 албан бус секторын гишүүдтэй хийсэн олон ярилцлагын өгөгдөл, өрхийн түүвэр судалгаа болон албан ёсны хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээллийг нэгтгэж ашигласан. Янз бүрийн эх сурвалжийн өгөгдөл болон мэдээлүүдийг Монгол дахь албан бус секторын дээд хэмжээ, хандлагыг хамгийн эхний үнэлгээг гүйцэтгэхэд ашигласан ба үнэлгээнүүд нь бусад үнэлгээ тус бүртэйгээ гайхалтай нийцтэй байсан. Үүнээс шилжилтийн үеийн албан бус секторын огцом өсөлтийн шалтгаануудыг илрүүлж, үнэлсэн. Энэ судалгаа нь Монгол дахь албан бус секторын шинж байдлыг, албан бус гэсэн нь ямар агуулгатай, албан бус секторынхан өөрсдийн эрхэлдэг хөдөлмөрийн статусаа хэрхэн ойлгодог, орлогын түвшин, зохицуулалтын орчин, албан бус сектор дахь захиргааны хандлага, санал бодол, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал ба ядуурлын эсрэг тэмцэлд жижиг үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр гэсэн хүчин зүйлүүдээр, өргөн агуулгатайгаар дүрсэлж чадна гэж судлаач үзжээ.

*Албан бус сектор, түүнтэй холбоотой олон асуудлууд нь нийгмийн нэн хүндрэлтэй асуудал байдаг бөгөөд ядуурлын асуудлуудтай салшгүй холбогдож байдаг билээ. Энэ хандлагаас авч үзвэл энэхүү ажил нь ядуурлын асуудлыг өөр талаас нь тайлбарлах, бодит шалтгаануудыг нь илрүүлэх, албан бус сектортой ядуурал хэрхэн холбогдож байгааг тодорхойлсноор аль алийг нь зэрэг шийдвэрлэх үр ашигтай арга, хэрэгсэл бодлого байж*

болохыг тодорхойлоход чухал ач холбогдолтой болжээ. Сүцлийн цөийн судалгааны арга аргачлал, тоон мэдээллийг өргөнөөр ашигласан нь оюутан, судлаач эрдэмтэд зөвхөн судалгааны үр дүнгээс гадна ийм төрлийн судалгаа хийх хүчтэй, үр ашигтай судалгааны арга аргачлал, туршилага эзэмшихэд нь том тус дэм, үлгэр дуурайл болох юм.

## 017

**Ашли, С (Ashley, S.), Холден, С (Holden, S.), Базелей, П (Bazeley, P). (1999). Livestock in Poverty-Focused development, Outhouse publishing services (Ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжил дэх мал аж ахуй), UK.**

**<http://www.theidlgroupp.com/downloads/livestock.pdf>**

Судалгааны тайлан, 95 хуудас, англи, ISBN 0952806126

*Түлхүүр үгс:* мал аж ахуй, эдийн засгийн хөгжил, институци, донорын тусламж, тусламжийн үр өгөөж

*JEL:* Q10, O10

Их Британи улсын Олон улсын хөгжлийн байгууллагын байгалийн нөөцийн бодлого зөвлөгөөний тэнхмээс санхүүжүүлсэн уг ажлын гол зорилго нь ядуурлыг бууруулахад мал аж ахуйн гүйцэтгэх үүргийг судлах явдал юм. Дэлхийн ядуучуудын дийлэнх нь хөдөө орон нутагт амьдардаг учраас мал аж ахуйд хөрөнгө оруулалт хийж тус салбарыг хөгжүүлснээр ядуурлыг дорвитой бууруулах бололцоо бий. Тийм учраас мал аж ахуйг хөгжүүлж ядуурлыг бууруулах ажил олон улсын хөгжлийн туслалцааны нэг чухал чиглэл байх нь гарцаагүй. Уг судалгаанд мал аж ахуйн хөгжил хөдөөгийн ядуучуудын амьдралд үзүүлэх нөлөө, мал аж ахуйн салбарын өвөрмөц онцлог, хөгжиж буй орнуудын мал аж ахуйг хөгжүүлэх талаар олон улсын донор улсуудаас үзүүлсэн тусламжийн туршилага, тусламжийн үр дүн, цаашид уг салбарт хийгдэх доноруудын тусламжийг үр өгөөжтэй байлгахад анхаарах ёстой бодлогын зөвлөлгөөг тус тус агуулсан байна.

Уг судалгааны онцлог нь мал аж ахуй малчдын орлогод үзцүлэх нөлөөний хэд хэдэн үндсэн сувгуудыг, мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн онцлог, олон улсын донорууд мал аж ахуйг хөгжцүлэхийн тулд хэрэгжцүлсэн төслүүдийг харьцуулан судалсан байна. Судалгааны дүнгээс хөгжиж буй орнуудад үзцүлж буй тусламжийн үр өгөөжийг дээшлүцүлэхэд хөдөө аж ахуйн институцийг хөгжцүлэх төслүүд нь мал аж ахуйг хөгжцүлэх олон улсын техникийн туслалцаанаас илүү чухал байж магадгүй гэж үзэж байна. Тус бүтээл нийтдээ 95 хуудас, 5 бүлгээс бүрдэж, 600 гаруй өгцүлэл, төслийн тайлангууд, үр нөлөөний судалгаа, донор улсуудын төлөөлөгч нар, засгийн газрын бус нийгмийн байгууллагууд, судлаач нартай хийсэн ярилцалуудад үндэслэн хийгдсэн ажил бөгөөд эдийн засаг, нийгмийн хөгжил, мал аж ахуй, ядуурал, олон улсын тусламжийн үр өгөөжийг судалж буй эрдэмтэн, мэргэжилтнүүдэд чухал хэрэгцээтэй судалгаа мөн гэж үзэж байна.

018

**Баажийхүү, Д (Baajikhuu, D). (2003). Economy of Mongolia, economic cooperation in northeast Asia. Factors of economic cooperation in the northeast Asia (Монголын эдийн засаг, зүүн хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагаа. Зүүн хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагааны хүчин зүйлс) (х 115-126). Монгол, Улаанбаатар.**

*Судалгааны тайлан, 8 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурлыг бууруулах стратеги, хүний хөгжил, амьжиргааны түвшин

*JEL:* I30, O15, I31

Уг судалгаа нь Монголын эдийн засгийн хөгжил, зүүн хойд Азийн эдийн засагт үзүүлэх нөлөө, оролцоо ба цаашдын төлөв байдлыг тодорхойлох зорилготой. Монгол Улс нь зүүн хойд Азийн бүс нутгийн үйл ажиллагаанд маш бага оролцдог болохыг дурдаад Монгол улсын эдийн засгийн хөгжилд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлүүдийг салбар салбараар авч үзсэн ба ядуурал, амьжиргааны түвшний доройтлыг ажилгүйдэлтэй холбоотой гэж үзжээ. Монголын эдийн засгийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлон зүүн хойд Азийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх талаар санал дэвшүүлсэн байна.

*Зүүн хойд Азийн эдийн засгийг сонирхон судлах судлаачид болон оюутнууд ашиглахад тохиромжтой. Тоо, баримтуудад цндэслэн асуудал дэвшицлж, дүгнэлт хийх байдлаар бичигджээ. Судалгааны дүгнэлтүүдийн зарим нь тодорхой цндэслэлгүй хийгдсэн нь ажлын ач холбогдлыг бууруулж байна.*

019

**Баас, С (Baas, S). (2003). Designing a pastoral risk management strategy in Mongolia - applying a sustainable livelihoods perspective (Монголд мал аж ахуйн эрсдлийн менежментийн стратегийг боловсруулах-тогтвортой амьжиргааны хэтийн төлвийг хэрэглэх). [http://users.ox.ac.uk/~cnpoc/main\\_panels.html](http://users.ox.ac.uk/~cnpoc/main_panels.html)**

*Илтгэл, 2 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, хөдөө аж ахуй

*JEL:* I30, Q20

Монголын талаар маш товч танилцуулсан. Үүнд, хөдөөд ядуурал өндөр хувьтай байгаа бөгөөд 1990-2000 онд малчид нь хүн амын 17 хувь байснаа 35 хувь болж хоёр дахин ихэссэн байна гэж дурьджээ. 1999-2000 онд зуд болон гангийн гамшигаас нийт 7 сая мал үхсэн байна. Иймээс ядуурлыг бууруулахад эрсдлийн эмзэг байдал чухал асуудал болоод байна гэжээ. Мал аж ахуйн эрсдлийн менежмент нь малчдын амьжиргааны хөрөнгийг хамгаалах, өмч хөрөнгөө алдах явдлыг бууруулах зорилгоор эрсдлийг удирдах, зохицуулахыг оролддог. Эцэст нь Монголын сургамжийг товчхон авч үзээд Монголын хувьд мал аж ахуйн эрсдлийн менежментийг дангаар хэрэглэх нь хангалтгүй бөгөөд малчдад амьжиргааны өөр эх үүсвэрүүд хэрэгтэй гэж үзжээ.

*Малчдын амьжиргааны түвшин нь байгаль орчноос хамаардаг болохыг энгийн байдлаар харуулж, малчдад тулгарсан энэ эрсдлийг бууруулах үр нөлөөтэй арга хэмжээ авах хэрэгтэйг зөвлөснөөрөө ач холбогдолтой болжээ.*

**020**

**Бат, Ч (Bat, Ch.). Urban Poverty Profile (Хотын ядуурлын дүр төрх).**  
[http://infocity.org/F2F/poverty/papers2/UB\(Mongolia\)%20Poverty.pdf](http://infocity.org/F2F/poverty/papers2/UB(Mongolia)%20Poverty.pdf)

*Илтгэл, 4 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, хотын ядуурал  
*JEL:* I30

Энэ илтгэлд Улаанбаатар хотын ядуурал, ажил эрхлэлтийн байдал, тэдгээрт чиглэгдсэн арга хэмжээнүүдийг танилцуулсан байна. Улаанбаатар хотын ядуурал 35.1, ажилгүйдлийн түвшин 20 хувьтай байгаа бөгөөд агаарын бохирдол, хог хаягдлын менежмент муу, хот төлөвлөлт алдагдсантай холбоотой хөрсний доройтол зэрэг нь хотын хүрээлэн буй орчны гол бэрхшээлтэй асуудлууд юм. Ядуурлыг бууруулахад чиглэгдсэн стратегийг хэрэгжүүлж байгаа боловч хот руу чиглэсэн эрчимтэй шилжих хөдөлгөөн нь угийн хомс нөөцтэй нийгмийн халамжийн үйлчилгээнд чирэгдэл дарамт учруулж байна гэжээ.

*Энэхүү илтгэл нь Улаанбаатар хотын ядуурлыг бууруулахад чиглэгдсэн цйл ажиллагаануудыг танилцуулж, тэдгээрийн үр дүнг тооцон харуулсан байна.*

**021**

**Батбаяр, Ж. (2001.03.30). Монголын төрд арван хүнийг ажилгүй болгож, нэг хүнийг ажилтай байлгах бодлого байж таарахгүй. Зууны мэдээ, №74 (648).**

*Өгүүлэл, монгол*

*Түлхүүр үгс:* ажилгүйдэл, ядуурал  
*JEL:* E24, I30

Монгол дахь ядуурлын байдалд бодитой дүн шинжилгээ хийж, ядуурал буурахгүй байгаагийн гол шалтгаан нь Макро түвшинд эдийн засгийн өсөлтийг дорвитой нэмэгдүүлж чадахгүй байгаа явдал гэж үзжээ. Хөдөлмөрийн нэр хүндийг дээшлүүлэх, цалин хөлсийг нэмэх замаар ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах арга замуудын талаар ярилцлага хэлбэрээр бичигдсэн өгүүлэл юм.

*Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах боломжтойг харуулснаараа ач холбогдолтой.*

**022**

**Батбаяр, Ц (Редактор). (2000). XXI зууны босгон дээрх Монгол Улсын шинэчлэл, цаашдын хөгжлийн хандлагууд. 3-р бүлэг, 5-р зүйл. Монгол, Улаанбаатар.**

*Номын бэлэг, 6 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* тэгш бус байдал, ядуурлын түвшин  
*JEL:* O15, I30

Ажилгүйдэл, ядуурлын талаарх Монгол Улсын бодит дүр төрхийг харуулахыг зорьсон. 1990-ээд оны эхэн үеийн Монгол Улс дахь ядуурлын тархалт, байршлыг судалгаанд тулгуурлан гаргаж, хүн амын хэрэглээний түвшинг таван бүлэг тус бүрээр тодорхойлж хүн амын

бүлэглэлүүдийн орлого, амьжиргааны түвшний тэгш бус байдал нэмэгдэж, ядуурал даамжирсан нь хүн амын зүгээс нийгмийн үйлчилгээг тэгш бус хүртэхэд хүргэж байна гэж дүгнэжээ. Ажилгүйдэл, ядуурлын байдлыг 1995, 1998 онуудаар харьцуулан авч үзэж ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах талаар Төрөөс баримтлах эдийн засаг, нийгмийн бодлогыг хослуулан хэрэгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэсэн байна.

*Шилжилтийн эхэн үеийн Монголын нийгмийн байдлыг ядуурлын тархалт, байрилаар, хөдөлмөрийн нөөц, ажил эрхлэлтийн байдлаар төлөөлцүлэн авч үзээд эдгээр асуудлаар олон улсын түвшинд харьцуулалт хийж болохуйц бүртгэл мэдээллийн тогтолцоо бий болсныг харуулснаараа судлаачдад өргөн мэдээлэл өгөх ач холбогдолтой ажил болжээ.*

## 023

**Баткин, Э. Бумхорол, Ц, Минз, Р., Свифт, Ж. (1999). Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрт хийсэн бие даасан үнэлгээ ба 2000 оноос цааших хэтийн хувилбарууд. Монгол, Улаанбаатар: Монгол Улсын Засгийн Газар, НҮБХХ, Дэлхийн Банк.**

*Судалгааны тайлан, 98 хуудас, монгол*

**Batkin, A. Bumhorol, Ts. Mearns, R., Swift, J. (1999). Independent evaluation of the national poverty alleviation programme and options post-2000. Mongolia, Ulaanbaatar: Government of Mongolia, UNDP, World Bank.**

*Судалгааны тайлан, 76 хуудас, англи*

**Түлхүүр үгс:** Ядуурал, ядуурлын шугам, ЯБҮХ, өрхийн орлого, ЯБС, амьжиргааг тогтворжуулах *JEL:* I30, I31, I38

Уг ажлын зорилго нь Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөрийн хэрэгжилт, Ядуурлыг бууруулах сангийн зориулалт, ЯБҮХ-ийн удирдлагын бүтэц, чадавхийн байдалд үнэлгээ өгөх, үнэлгээний үр дүнд тулгуурлан 2000 оноос цааших хугацаанд ядуурлыг бууруулах арга хэмжээний стратегийн хувилбаруудыг агуулга, үйл ажиллагааны талаас нь боловсруулах явдал байсан. Судалгааны хүрээнд асуудал дэвшүүлэн тэдгээрт хариулах замаар үнэлгээ өгч хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцах боломж олгож, холбогдох яам, тамгын газрын ажилтнууд болон хандивлагчидтай уулзалт зохион байгуулсан зэрэг бодит ажлуудын тусламжтайгаар үнэлгээний ажлыг гүйцэтгэжээ. Мөн яамд, ЯБХГ, ЯБҮХ, ТББ болон хандивлагчдын төлөөлөгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулсны үндсэн дээр стратегийн хувилбаруудыг тодорхойлсон байна. Үнэлгээний багийн зүгээс ЯБҮХ нь нэн ядуу хүмүүсийн амьдралд эерэг нөлөө үзүүлсэн гэж дүгнэсний зэрэгцээ хөтөлбөрийн үр ашиг нь үүнээс илүү байж болох байсан гэж дүгнэжээ. Цаашдын арга хэмжээний стратегийн талаар үнэлгээний баг тэргүүлэх ач холбогдол бүхий 10 төслийн хувилбаруудыг санал болгосон байна.

*Бодлого боловсруулагч болон хэрэгжүүлэгч нарт зориулагджээ. 1994-2000 онд хэрэгжсэн Ядуурлыг бууруулах хөтөлбөрт хийсэн бие даасан үнэлгээ болон хөтөлбөр дууссанаас хойш ядуурлыг бууруулах чиглэлээр баримтлах хувилбаруудыг тусгасан. Он дарааллын бичиг, ядуурлыг бууруулах хөтөлбөрцүд, санхүүжилт, удирдлага, зохион байгуулалтын талаар нарийвчлан судалсны зэрэгцээ хөтөлбөрийн үр дүнг тоон мэдээлэл болон үнэлгээнд*

цндэслэн дүгнэсэн байна. Цаашдын хувилбаруудыг боловсруулахдаа тэргүүлэх төслүүдийг авч үзэн төслийн хэрэгжих хугацаа, цргэлжлэх байдал зэргийг тусгасан нь тодорхой мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна. Ядуурлыг бууруулах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгох, цаашдын бодлогын хэрэгжилтэд анхааралтай хандахад ач холбогдолтой материал болсон байна.

## 024

**Болд, Р., Ганбаатар, Б. (Редактор). (2002). Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал. Улаанбаатар: Ти энд Юү принтинг ХХК.**

*Эмхэтгэл, 264 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Хөгжил, Аюулгүй байдал

*JEL:* H56, O10

Энэхүү эмхэтгэл нь 2002 оны 6 сард зохион байгуулсан “Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал” сэдэвт Бага хурлын илтгэлүүдийг багтаасан байна. Хурлын үндсэн илтгэлд Монгол Улс хөгжиж байж л эдийн засгийн болон бусад аюулгүй байдлын хувьд баталгаатай болох бөгөөд хөгжлийн хувьд хоцрогдсон байх тусам, улс орноо буурай хөгжилтэй байлгах тусам бид Монгол Улсынхаа аюулгүй байдлын баталгааг алдагдуулж байна гэжээ. Илтгэлүүд нь эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн хөгжлийг гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж, гадаад худалдаа, төсвийн бодлого, дэд бүтэц, мөнгөний бодлого, өмч хувьчлалтай холбон тал бүрээс нь судалжээ. Түүнчлэн эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын талаар олон нийтийн дунд явуулсан социологийн судалгааны дүнг танилцуулсан байна.

*Энэ эмхэтгэлд нийтлэгдсэн илтгэлүүд нь улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангаснаар хүн амын сайн сайхан аж байдлыг хангах болно гэдгийг харуулжээ. Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, ядуурал, амьдралын түвшин харилцан хамааралтай болохыг тод томруун гаргаж өгсөнөөрөө ач холбогдолтой.*

## 025

**Бююэ, Я (Jan Voigt), Редди, Р.Ч (Reddy, R. Ch). (2001). Poverty Reduction Strategies and Environment: A Review of 40 Interim and Full PRSPs (Ядуурлыг бууруулах стратегиуд ба хүрээлэн буй орчин: 40 орны завсрын ба эцсийн ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ).**

[http://www.worldbank.org/wbi/sdstrategies/publications/environment\\_review.pdf](http://www.worldbank.org/wbi/sdstrategies/publications/environment_review.pdf)

*Өгцлэл, 32 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, стратегийн баримт бичиг

*JEL:* I30

Дэлхийн Банкны Үүрэг, зорилгын тунхаглалын нэг зорилт нь “...нөөцүүдийг хуваарилах, мэдлэгийг нээлттэй болгох, чадваржуулах, улсын болон хувийн секторт хамтын ажиллагааг идэвхжүүлэх замаар хүмүүст, тэдгээрийн хүрээлэн буй орчинг сайжруулах...” гэж заасан байдаг бөгөөд Дэлхийн Банк Хүрээлэн Буй Орчны Стратегийг “... хөгжлийн суурь элемент болгон

авч үзэн, ядуурлыг бууруулах стратегиуд ба үйл ажиллагаагаар хүрээлэн буй орчны дэвшлийг хөгжүүлэх ..." гэж тодорхойлсон. Ийм нөхцөл байдалд, судлаачид нь дэлхийн янз бүрийн тивийн нийт 40 улсын Завсрын ба эцсийн хэмжээний ЯБСББ-ийн хүрээлэн буй орчинтой холбоотой асуудлуудыг иж бүрнээр үнэлэх зорилго тавьж энэ ажлыг гүйцэтгэжээ. Уг шинжилгээ нь хүрээлэн буй орчны асуудлууд болон ЯБСББ-ийн хоорондын харилцан уялдааг үндсэн 4 асуудлаар хөндөж тавьсан бөгөөд 0-ээс 3 хүртэлх оноогоор дүгнэх 17 шалгуураар улсуудын ЯБСББ-г үнэлж, үр дүнг 4 түвшинд ангилжээ. Уг шинжилгээнд манай улсын баримт бичиг хамрагдсан ба манай ЯБСББ-г завсрын гэж тодорхойлоод хүрээлэн буй орчны оноо 0.8 гэж үнэлсэн ба уг үнэлгээг гаргаж авсан арга аргачлал, онцлог байдлыг тодруулан үзүүлжээ.

*Дэлхийн Банк хүний хүрээлэн буй орчны тухай ойлголтод юу юуг хамруулдаг, эдгээрийг хөгжлийн бодлого болон ядуурлыг бууруулах стратегийн зорилт, хэрэгжүүлэх цйл ажиллагаатай уялдуулан хүрээлэн буй орчны хөгжлийг дэмжих стратегийн тухай мэдээллийг энэ бүтээлээс мэдэх боломжтой юм. Хүрээлэн буй орчны асуудлыг ЯБСББ-т хэрхэн тусгах, түүний шалгуур үзүүлэлтүүд, үнэлгээний орчин үеийн арга аргачлал болон өөрийн улсын баримт бичигтэй танилцах боломжтойгоороо ач холбогдолтой.*

## 026

**Гриффин, К (Griffin, K). (2001). Agricultural Involution and Urban-To Rural Migration in Mongolia (Монголын хөдөө аж ахуйн салбарын хумигдах үйл явц ба хотоос хөдөө рүү хүн амын шилжих хөдөлгөөн). <http://www.economics.ucr.edu/papers/02-02.pdf>**

*Судалгааны тайлан, хуудас 24, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, хотоос хөдөө рүү шилжих хөдөлгөөн

*JEL:* O15, I32

Уг судалгааны ажил нь Монголын хүн амын шилжилт хөдөлгөөний байдлыг гаргахыг зорьсон байна. Шилжилтийн эхэн үед Монголд хүмүүс хотоосоо хөдөөд илүү төвлөрч, аж үйлдвэржилтийн эсрэг үйл явц өрнөж байсан. 1998 он хүртэл энэ үйл явц үргэлжилсэн бөгөөд 2000 оны зуднаас хойш эргээд хот руу шилжих хөдөлгөөн мэдэгдэхүйц өссөн. Хөдөө аж ахуйн секторт ядуурлыг бууруулахын тулд усжуулалт, тусламжийн тэжээлийн хүчин чадал зэрэгт нэлээд хэмжээний улсын хөрөнгө оруулалт хийх, нийгмийн барааг хувийн сектор оновчтой хангаж чадахгүй байсан учраас улсаас үүнийг хангах хэрэгтэй гэжээ. Нөгөө талаас малчид хоорондоо гэрээ байгуулж, баг болон нэгдэн ажиллахыг урамшуулах, гэрээ хийсэн этгээдүүд нь жилийн төлбөрөө хийх ёстой бөгөөд орон нутгийн засаг захиргаа энэ төлбөрөөр нийгмийн барааг хангаж өгөх шаардлагатайг тэмдэглэсэн байна.

*Хүн амын шилжилт хөдөлгөөн болон хөдөөгийн ядуурлыг сонирхон судлаж буй мэргэжилтэн, судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан. Монголын макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд тулгуурлан сонирхолтой судалгаа хийж, хөдөөгийн ядуурлыг бууруулах бодлогыг санал болгосноороо ач холбогдолтой ажил болжээ.*



027

**Гриффин, К (Griffin, K.). (Ed.). (2003) Poverty Reduction in Mongolia (Монголын ядуурлыг бууруулах нь). Австрали: Asia Pacific Press.**

*Ном, 161 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, орлого хуваарилалт, албан бус сектор

*JEL:* I30, O15

К. Гриффин нь “Монголын ядуурлыг бууруулах нь” номын редактор, Монголд хийгдсэн ядуурлын судалгааны багийн ахлагч юм. Энэхүү ном нь 7 бүлэгтэй, монголын ядуурлыг макро эдийн засаг, шилжих хөдөлгөөн, МАА, ажил эрхлэлт, хүрээлэн буй орчин, засаглал, хөгжлийн стратеги, зээл тусламж зэрэг олон хүчин зүйлтэй холбож судалсан байна. Номыг “Ядуурал, тэгш байдлын асуудлуудыг улсын хөгжлийн стратегитай холбох нь” сэдэвт судалгааны ажлын тайланд түшиглэн бичсэн байна. Уг ном бүхэлдээ дараах агуулгатай. Үүнд, нэг хүнд ногдох орлогын өсөлтийг хурдасгах, тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, өсөлт ба тэгш байдал нь өөр хоорондоо зөрчилдөх ёсгүй учир хөрөнгө дахин хуваарилах бодлогыг зөв хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ядуурлыг хурдан бууруулах аргын нэг болох бүтээмжит ажил эрхлэлтийг бий болгох, шилжилтийн үйл явцыг удирдах, шинэ байгууллауудыг бий болгох, эдийн засгийн шинэчлэл хийх, улсын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, эмзэг бүлгийг дэмжих чадвар бүхий төрийн хэрэгцээ зэрэг асуудлуудыг багтаажээ.

*Энэхүү ном нь ядууралтай холбоотой асуудлаар судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэн, судлаачид, оюутнууд болон бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдэд монголын ядуурлын талаар дорвитой гарын авлага болохуйц сайн бүтээл болсон юм. Монголын ядууралтай холбоотой асуудлуудаар боломжтой тоон өгөгдлүүдийг маш чадварлаг шинжилж, сонирхолтой дүгнэлтүүдийг зоригтой хийсэн байна. Энэ нь зөвхөн практик зөвлөмж өгөөд зогсохгүй, онолын сонирхолтой асуудлуудыг дэвшилцэн тавьснаараа ач холбогдолтой.*

028

**Гриффин, К (Griffin, K.). (2000). Problems of Poverty and Marginalization (Маржинализация (Ялгаварлал) ба ядуурлын асуудлууд.). Working Paper, 51, Political Economy Research Institute. <http://www.umass.edu/peri/WP51.pdf>**

*Өгцлэл, 29 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлын тодорхойлолт, хэмжилт

*JEL:* I30, I32

К. Гриффин нь энэхүү өгүүлэлдээ, ядуурлын тухай ойлголт, тодорхойлолтууд, тэдгээртэй уялдуулан ядуурлыг хэмжих аргуудыг судалж, давуу болон сул талуудыг гаргаж тавьсан байна. Тухайлбал, орлогын ядуурлыг хэмжихтэй холбогдсон нэг асуудал нь орлогыг хэрхэн тодорхойлох, хамрах хугацааны (жилийн, сарын) асуудал юм. Түүний үзэж буйгаар зарим нийгэмд орлогоор хэмжих нь зохимжгүй байх тохиолдол ч байна. Тухайлбал, нүүдлийн мал ахуй эрхэлдэг өрхүүдийн хувьд амьжиргааны түвшинг хэмжихэд орлого чухал бус харин хөрөнгө (жишээ нь, малын тоо) илүү зохистой болохыг монголын жишээн дээр оновчтой тайлбарласан байна.

Энэхүү өгцлэл нь ядуурлын талаар судалгаа хийдэг, эрдэмтэд, мэргэжилтнүүд, оюутнуудад энэ талын ойлголтоо гүнзгийрүүлэх, ядуурлын тодорхойлолтуудын зааг ялгаа, зориулалтыг ойлгоход тустай ажил юм.

## 029

**Гүнсэндорж, М. (2000.2.12). “Ядуурал гэдэг зөвхөн эд материалын дутагдал биш”.**  
**Үнэн, №029.**

*Өгцлэл, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, оюуны хоосрол  
*JEL:* I30

Энэ өгүүлэлд ядуурал гэдэг нь зөвхөн эд материалын дутагдал биш, харин шинжлэх ухааны мэдээллийн хомсдол, боловсролын хаалттай байдал гэдгийг дурдаад холбоо мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх шаардлагатайг харуулжээ. Ихэнх тохиолдолд ядуурлыг эд материал, орлогын дутагдал гэж ойлгодог түгээмэл уламжлалт ойлголт шүүмжлэлтэй хандаж оюуны ядуурлыг тодорхойлохыг зорилго болгожээ.

*Холбоо мэдээллийн түргэн хурдацтай өсөлтийн үед оюуны ядуурал нэмэгдэж байгааг баримтаар харуулахад мэдээлэл, боловсролын хаалттай байдлыг даван туулахад бүх нийтийн анхаарлыг хандуулж байгаагаараа ач холбогдолтой болжээ. Ядуурлын асуудлыг эхлэн судлаж байгаа хүмүүс ашиглахад тохиромжтой.*

## 030

**Даваасүрэн, Ч. (1999). Poverty measurement in transition countries: A case of Mongolia”. (Шилжилтийн эдийн засагтай орнуудад ядуурлыг хэмжих нь: Монгол).**  
**<http://www.unescap.org/stat/cos11/wgse11/wgse1107.pdf>**

*Илтгэл, 8 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлыг хэмжих нь  
*JEL:* I30, I32

ҮСГ анх 1991 онд ядуурлын шугамыг тодорхойлсон. 1995, 1998 онд амьжиргааны түвшний түүвэр судалгааг хийсэн. Уг өгүүллэгт хүнсний ядуурлын шугамыг тооцох аргачлалыг тодорхойлж ядуурлын янз бүрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг өгчээ. Эцэст нь, Монголын ядуурлын онцлог байдлыг харуулж, шилжилтийн эдийн засагтай орнууд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолттой холбоотойгоор ядуурлын үндсэн үзүүлэлтийг бий болгож олон нийтэд хүргэж байна гэжээ.

*Монголын ядуурлын талаар товч мэдээлэл болон Монголын ядуурлын шугамыг хэрхэн тооцсоныг энэ өгцлэлээс олж мэдэх боломжтой. Ядуурлын талаар судалгаа хийж байгаа хэнд ч болов онол, арга зүйн ач холбогдолтой.*

## 031

**Даваасүрэн, С (Davaasuren, S). (2001). Measuring inequality (Тэгш бус байдлыг хэмжих нь), Эдийн засаг: онол, практик сэтгүүл (33, х 40-51). Монгол, Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.**

*Өгцүлэл, 11 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Орлогын тэгш бус байдал, орлого хуваарилалт, ядуурал, ажилгүйдэл  
*JEL:* O15, I30, E24

Уг ажлын зорилго нь хөгжлийн эдийн засгийн онолд сүүлийн үед ихээхэн анхаарал татаж буй маргаантай асуудлуудын нэг болох тэгш бус байдлыг хэмжих арга зүйн хандлагуудын талаар цэгцтэй ойлголт өгөх, практик үнэлгээний аргачлалуудыг танилцуулах явдал юм. Үнэлгээний аргачлалуудыг Монголын бодит тоон өгөгдөл ашиглан тооцож харуулсан ба үр дүнд шинжилгээ хийсэн. Хот болон хөдөөгийн орлогын тэгш бус хуваарилалтыг хэмжсэнээр хотын орлого хуваарилалт хөдөөгийнхөөс тэгш бус байдал нь илүү байна гэсэн үр дүн гарчээ.

*Судлаачид болон оюутнууд ашиглахад илүү тохиромжтой. Тэгш бус байдлыг хэмжих онолын асуудлуудыг хамарсан ба Монголын тоон өгөгдөл дээр үнэлсэнээрээ орлого хуваарилалтын хэмжүүрийг ашиглах арга зүйг харуулсан ажил болсон байна. Судалгаа нь 1997-1998 оныг хамарсан ба цаашид уг ажлыг сүүлийн үеийн тоон өгөгдөл, баримт материал ашиглан сайжруулж болох юм.*

## 032

**Дарьжин, М. “Mongolia”. (Монгол).**

*Өгцүллэг, 8 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлыг бууруулах бодлого, макро эдийн засаг  
*JEL:* I30, I32, N15

Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тоо, мэдээ материал, баримтад тулгуурлан харуулсан. Уг бүтээл нь эдийн засгийн гадаад, дотоод орчин болон улсын төсөв гэсэн үндсэн хэсгүүдээр Монголын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг авч үзсэн байна. Ядуурлын асуудлыг тусгахдаа гадаадын зээл тусламжийг авч үзээд гадаадын байгууллагуудаас Монголын ядуурлыг бууруулахад хийгдэж байгаа хөтөлбөр, үйл ажиллагааг дурьдсан байна. Ядуурлыг бууруулах үйл ажиллагааны үр дүн нь эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийг илүү хурдан бий болгох, мөн түүнчлэн засаглалын ерөнхий стандартыг хүчтэй болгоход засгийн газар хэр амжилттай ажиллахаас ихээхэн хамаарна гэж дүгнэжээ. Дунд хугацааны шийдвэрлэх асуудал нь нийгмийн секторыг хөгжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах, хувийн секторын хөрөнгө оруулалт болон орон нутгийн эдийн засгийг дэмжих явдал юм гэж дүгнэжээ.

*Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг судалж цаашид дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогуудыг санал болгосон ач холбогдол бүхий бүтээл болжээ. Монголын эдийн засгийн талаар мэдээлэл авах, судалгаа хийж байгаа хүмүүс уг ажлыг ашиглах боломжтой.*

## 033

**Должинсүрэн, Ж. (1997). Эмэгтэйчүүд ба ядуурал. Монголын хүн ам зүйн сэтгүүл, эмхэтгэл 2, (21, х 104-110).**

*Өгцлэл, 7 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Эмэгтэйчүүдийн ядуурал, ядуу өрх, ядуурал

*JEL:* I30, J16

Энэ өгүүлэл нь эмэгтэйчүүдийг зөвхөн хүн амын нөхөн үржихүйд гүйцэтгэж буй үүргийнх нь хүрээнд бус нийгмийн амьдралд оролцон эрэгтэйчүүдийн нэгэн адил ажиллаж, давхар ачаалал үүрч явдаг бие даасан хувь хүнийх нь хувьд авч үзэн, эмэгтэйчүүдийн ядууралд өртсөн байдлыг шинжлэн, ядуурлаас гарах арга замыг тодорхойлох зорилготой. Энэхүү ажил нь Оршил, Эмэгтэйчүүдийн ядуурлын өнөөгийн байдал, эмэгтэйчүүдийг ядуурлаас гаргах арга зам гэсэн бүлгүүдээр монголын эмэгтэйчүүдийн нийгмийн байдлын түүхэн он дарааллыг харуулж, өнөөгийн байдлыг статистик тоон мэдээллээр илэрхийлжээ. Энэ судалгаа нь статистик тоон судалгаа, тэдгээрийг харьцуулан шинжлэх замаар монголын эмэгтэйчүүдийн ядууралд өртөж байгаа үндсэн шалтгаан, ядуурлаас гаргах арга замуудыг тодорхойлон гаргажээ.

*Энэ өгцлэл нь оюутан, судлаач эрдэмтэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон бусад бүх хүрээний хүмүүс унших, ашиглахад тохиромжтой, статистик шинжилгээ, харьцуулсан судалгааны ажил юм. Уг ажилд 1996 оны байдлаарх тоон мэдээллийг ашиглан эмэгтэйчүүдийн ядуурлыг тусгайлан авч үзсэнээрээ ач холбогдолтой. Гэхдээ бүтээлийн бүтэц тааруу, зарим агуулгыг давхардуулсан зэрэг дутагдал байна.*

## 034

**Дэлхийн Банк. (World Bank). Poverty diagnostics (Ядуурлыг тодорхойлох).**

<http://www.worldbank.org/participation/section2.pdf>

*Илтгэл, 6 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, эдийн засгийн бодлого

*JEL:* I30, E60

Ядуурлыг тодорхойлох оролцооны аргын хандлагыг ерөнхийд нь авч үзээд Монгол, Вьетнам болон Уганда улсын оролцооны аргын судалгааг шигтгээ байдлаар оруулсан байна. Монголын амьжиргааны түвшний түүвэр судалгаа нь төрийн эн тэргүүний хэд хэдэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг санал болгосноос гадна оролцооны аргын судалгааны үр дүнг бодлого боловсруулалт, төсвийн талаарх шийдвэр, түүнийг хянах, үнэлэх ажиллагаатай холбох боломжуудыг харуулжээ.

*Энэ илтгэл нь амьжиргааны түвшний оролцооны аргын судалгааны үр дүнг бодлоготой холбох талаар зөвлөмж өгснөөрөө бодлого боловсруулагч, судлаачдын хувьд ач холбогдол бүхий ажил болжээ.*

## 035

**Дэлхийн банк (World Bank). (1995). Mongolia: Poverty alleviation for vulnerable groups project (Монгол Улс: эмзэг бүлгийнхний ядуурлыг бууруулах төсөл).**

Тайлан, 79 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, эмзэг бүлэг  
*JEL:* I30

Уг тайлан Монгол Улсад эмзэг бүлгийнхний ядуурлыг бууруулах ажлын институцийн хүрээг бий болгох, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эмзэг бүлгийнхний дунд зохицуулах, богино хугацаанд ядуучуудын ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх, суурь боловсролын хамралтыг сайжруулах, төрөлтөөс болж эхчүүдийн нас барах явдлыг бууруулах, тахир дутуу хүүхдүүд, насанд хүрсэн хүмүүст туслалцаа үзүүлэх зорилгоор тусгай төслийг хэрэгжүүлэх ажлын шаардлага, үндэслэлийг гаргажээ. Тайланд Монгол Улсын эдийн засгийн шилжилт, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг тусгаж, эмзэг бүлгийнхэнд зориулсан төслийг санал болгож дэлгэрэнгүй танилцуулсан байна.

*Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилт, эмзэг бүлгийнхний нийгэм эдийн засгийн байдлыг судалж буй эрдэмтэд, бодлого боловсруулагч нар ашиглах боломжтой.*

## 036

**Дэлхийн банк (World Bank). (1996). Mongolia: poverty in a transition economy (Монгол улс: шилжилтийн эдийн засаг дах ядуурал, судалгааны тайлан). World Bank.**

Судалгааны тайлан, 65 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурлын хэмжилт, эдийн засгийн бодлого  
*JEL:* I32, E60

1996 онд Дэлхийн банкны судалгааны багаас бэлтгэн гаргасан уг судалгааны ажлын гол зорилго нь Монгол Улсын ядуурлын эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн ба бүс нутгийн талаас гүнзгийрүүлэн судалж, ядуурлыг бууруулах зорилгуудыг төрийн бодлогод тусгахад тусламж үзүүлэх, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд олон улсын тусламж хэрхэн нөлөөлж байгааг судлахад оршино. Уг судалгааны тайлан бол Монгол Улсын ядуурлыг хэмжих анхны том судалгаануудын нэг болсон бөгөөд уг тайланг бэлтгэх явцад Монгол Улсын засгийн газар судалгааны багтай хамтран ажилласан. Уг тайлан 5 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд амьжиргааны түвшинг нарийвчилан тодорхойлох замаар ядуурлын түвшинг тогтоож Монгол Улсын ядуурлыг тал бүрийн статистикийн үзүүлэлт, тоогоор хэмжих, макро эдийн засгийн бодлого нь ядууралд ямар нөлөө үзүүлж буйг олох, нийгмийн халамжийн бодлогоор ядуурлын эсрэг хэрэгжүүлж байгаа ажлыг шинжиж, цаашид төрөөс авч хэрэгжүүлэх ядуурлыг бууруулах бодлогыг боловсронгуй болгох талаар зөвлөлгөө өгсөн тайлан болжээ.

*Уг тайлан нь ядуурлыг бууруулах эдийн засаг, бодлогын асуудлуудыг нэгтгэн системтэй авч үзсэн, Монгол Улс дахь ядуурлыг онол практикийн талаас сайн судалсан, бодлого боловсруулагчид, судлаачдад зориулсан баримт, статистикийн тоо, зөвлөмж бүхий чухал судалгааны материал болсон.*

037

**ЖАЙКА, Төлөвлөлт ба Үнэлгээний Хэлтэс (JICA, Planing and Evaluation Department). (2003). Country profile study on poverty (Улс орны ядуурлын төлөв байдлын судалгаа).**

[http://www.jica.go.jp/english/global/pov/profiles/pdf/mon\\_eng.pdf](http://www.jica.go.jp/english/global/pov/profiles/pdf/mon_eng.pdf)

*Илтгэл, 8 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал

*JEL:* I30

Уг илтгэл нь Монголын ядуурлын талаар мэдээлэл өгөх зорилготой. Нэгдүгээр хэсэгт Монгол Улсын үндсэн үзүүлэлтүүдийг ядуурал, хүн ам, эдийн засаг болон нийгмийн талаас нь харуулсан байна. Хоёрдугаар хэсэгт, Монголын ядуурлыг авч үзсэн. 1995-1998 оны хооронд Улаанбаатар болон хөдөөд ядуурлын түвшин яльгүй буурсан байхад аймгийн төвүүдэд бага зэрэг өссөн байна. Мөн орлогын тэгш бус байдал бага зэрэг нэмэгдсэн. Малыг хувьчилсан болон худалдаа үйлчилгээний салбарт ажил эрхлэлт бий болсноор нийслэл болон хөдөөд ядуурал бага зэрэг буурсан байна. 1998 оны амьжиргааны түвшний түүвэр судалгаанаас харахад ядууралд нөлөөлж буй үндсэн хүчин зүйл нь боловсрол, ажил эрхлэлт байна гэж дүгнэжээ.

*Монголын ядуурлын талаарх танилцуулга, ядуурлын талаар өргөн хүрээтэй мэдээллийг оруулж чадсанаараа ач холбогдолтой болжээ. Монголын ядуурлын өнөөгийн байдлын талаар товч, тодорхой мэдээлэл авах зорилго бүхий уншигчдад зориулагдсан байна.*

038

**Жаргалсайхан, Ж. (Jargalsaikhan, J). (2001). Mongolia: Experiences of Preparing I-PRSP". (Монголын ядуурлыг бууруулах дунд хугацааны стратегийн баримт бичгийг бэлтгэх туршлага). Ядуурлыг бууруулах үндэсний стратегийн талаарх бүс нутгийн семинар.**

[http://www.worldbank.org/wbi/attackingpoverty/eap/hanoi\\_jargalsaikhan.pdf](http://www.worldbank.org/wbi/attackingpoverty/eap/hanoi_jargalsaikhan.pdf)

*Илтгэл, 5 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, стратегийн баримт бичиг

*JEL:* O18

Энэ илтгэлийг стратегийн баримт бичгийг бэлтгэхэд туршлага, загвар болгох зорилгоор бичжээ. Ядуурлыг бууруулах дунд хугацааны стратегийн бичиг баримтын бэлтгэл ажиллагааны зохион байгуулалт, уг бичиг баримтын бүтэц, түүнийг боловсруулахад учирсан хүндрэл бэрхшээл болон түүнийг бичсэний ач холбогдол, давуу талуудыг дурдсан байна.

*Уг илтгэл нь бодлого болон стратегийн баримт бичиг боловсруулагчдад цлгэр дууриал, сургамж өгөх мэдээллийн ач холбогдолтой. Түгнчлэн стратегийн баримт бичгийг боловсруулсан цйл явц, арга зүйг нарийвчлан гаргаж өгснөөрөө энэ илтгэл нь цаашид сургамж, туршлага болохуйц ажил болсон байна.*

## 039

**Зүүн Ази & Номхон далайн бүсийн хотын хөгжлийн секторын нэгж (Urban development sector unit east Asia & Pacific region). (2003). Mongolia municipal finance note (Монгол Улс: Хотын захиргааны санхүүгийн тэмдэглэл).**

*Тайлан, 49 хуудас, англи*

*Түлхүүр цгс:* ядуурал, ядуурлын шугам

*JEL:* I32, R11

Энэ тайлан нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн бодит бололцоо, хэтийн чиг хандлагыг тодорхойлох, хотын дэд бүтэц, ялангуяа түргэн өсөлттэй албан бус сектор дахь гэр хорооллын асуудлуудыг үнэлэх зорилготой. Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг орчим нь нийслэл хотод амьдардаг бөгөөд үүний 40-өөс 60 хувь нь гэр хороололд амьдардаг. Улаанбаатар хотын маш түргэн өргөжилт нь гэр хороололд шилжин ирэгсдийн нийгмийн асуудлуудыг бий болгож байна. Гэр хороололд амьдрагсад нь цэвэр усны хангамж, цахилгаан эрчим хүч, утсан харилцаа зэрэг хотын үйлчилгээнээс хүртэх боломж хангалтгүй байна. Мөн гэр оронгүй ядуучууд олноор бий болж байгааг энд дурьджээ. Түүнчлэн энэхүү тэмдэглэлд Улаанбаатар хотын захиргааны санхүүжилтийг сайжруулахад шаардлагатай хэд хэдэн зөвлөмжийг санал болгожээ.

*Энэ тэмдэглэлд нийслэл хотын өнөөгийн байдал, санхүүг авч үзсэн. Нийслэл хотын гэр хорооллын асуудал нь ядуурал тэр дундаа хотын ядууралтай нягт холбоотойг харгалзан, хотын ядуурлыг тусгайлан авч үзсэн нь энэ ажлын ач холбогдлыг илэрхийлнэ. Түүнчлэн энэ чиглэлийн судлаач, бодлого боловсруулагчдад хэрэгтэй мэдээллүүдийг агуулсан сайн тайлан болжээ.*

## 040

**Клейри, С (Cleary, S). (1993). Mongolia: Report of a poverty alleviation mission (Монгол: Ядуурлыг бууруулах үйл ажиллагааны тайлан).**

*Тайлан, 63 хуудас, англи*

*Түлхүүр цгс:* Ядуурал, туйлын ядуурал, ядуурлын шугам, эмзэг бүлэг, амьжиргааны түвшин, орлогын хуваарилалт

*JEL:* I30, I31, O15, R11

Уг тайлан нь Монгол Улсын ядуурлын төлөв байдлыг тодорхойлох, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, дүгнэлт өгөх зорилготой. Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон анхаарал татаж буй асуудал болох ядуурлыг тодорхойлох, хэмжих талаар авч буй арга хэмжээг нийгмийн хөгжлийн асуудлуудтай уялдуулан тайлбарласан. Аймгуудын жишээ болон тоо баримтуудыг оруулсан бөгөөд ядуурлыг бууруулах талаар Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийсэн. Хамрагдаагүй болон хангалтгүй авч үзсэн асуудлуудыг тодотгож цаашид нэгдсэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргасан.

*Шилжилтийн эхэн цед цусч гарсан нийгмийн тулгамдсан асуудал болох ядуурлын*

талаар тодорхой авч үзэн, Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийсэн нь чухал ач холбогдолтой болсон байна. Цаашид хэрэгжүүлэх бодлогуудын талаар зөвлөмж гаргасан ба дутуу орхигдсон асуудлуудыг тодорхойлон гаргасан нь судалгааг нухацтай хийснийг харуулж байна. Тодорхой кейс судалгаагаар баяжуулсан нь ажлыг цр дцнтэй болоход ч нөлөөлжээ. Судлаачид, бодлого боловсруулагч нар ашиглахад тохиромжтой.

#### 041

**Курибаяши, С (Kuribayashi, S.). (2004). On the regional GDP distribution and poverty issue in Mongolia (Бүс нутаг дахь ДНБ-ий хуваарилалт ба Монгол дахь ядуурлын асуудал). Монголын хөгжлийн судалгааг дэмжих төв. "Latest Economic Development Issues in the Northeast Asia and Mongolia". х 65-79. Улаанбаатар**

*Номын бцлэг, 15 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, тэгш бус байдал, орлого хуваарилалт

*JEL:* O15, O18, I38, I32

Энэхүү бүтээл нь эдийн засгийн байдлыг бүс нутгуудаар нь авч үзэж, зохиогчийн үнэлгээнд үндэслэн 1995-аас 2001 оны хоорондох бүс нутгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хуваарилалт дахь тэгш бус байдлын хандлагыг илэрхийлэх зорилготой. Судалгааны ажил нь эрэлтийн талын өгөгдлийн дутагдалтай байдлаас шалтгаалан бүс нутгийн нэг хүнд ногдох ДНБ-ийг тооцохдоо нийлүүлэлтийн талын тооцоог ашиглажээ. Судлаач хэд хэдэн харьцуулалт дээр үндэслэн алслагдсан бүс нутгуудад амьжиргааны түвшин дорой байдалтай байна гэж дүгнэжээ. Цаашилбал, хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнөөс шалтгаалан Улаанбаатар хотод ядуурал тууштай өсч байгаа гэжээ. Гэхдээ ядуурлын тухайд нэмэлт судалгаа хэрэгтэй бөгөөд үүний тулд статистикийн шинэ өгөгдлүүд хэрэгтэй гэдгийг дурьджээ.

Судлаач ҮСГ-аас гаргадаг статистикийн мэдээлэлд тулгуурлан аймаг болон бүс нутгуудын орлого хуваарилалт, тэгш бус байдлыг судалснаараа шинэлэг, ач холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээл болжээ. Мөн бүс нутгуудын тэгш бус байдлын хандлагыг харуулж, тэгш байдлыг хангахад ЭГ-ын оролцоог чухалчилсан нь бодлого боловсруулагчид ч ашиглах боломжтой. Харин уг ажилд ядуурлын асуудлыг тусгайлан авч үзээгүй байна.

#### 042

**Лампетти, Ж.А. (Lampietti, J.A) & Сталкер, Л. (Stalker, L). (2000). Consumption Expenditure and female Poverty: A Review of the Evidence (Хэрэглээний зардал ба эмэгтэйчүүдийн ядуурал: нотолгоог дахин авч үзвэл). Цуврал, ?11.**

<http://www.worldbank.org/gender/prr/wp11.pdf>

*Өгцлэл, 73 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, жендэр, хүйсийн ялгаа

*JEL:* J16, D12, I32

Уг бүтээлд дурьдснаар НҮБХХ-ийн Хүний Хөгжлийн илтгэлд (1995) дурьдсанаар дэлхийн ядуучуудын 70-аас илүү хувь нь эмэгтэйчүүд байна. Энэхүү бүтээлд хоёр асуудлыг хөндөн авч



үзсэн. Үүнд нэгдүгээрт, ядуу эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүд болон ядуу бус эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрүүл мэнд, боловсрол, хоол хүнсний байдал, ажиллах хүчинд оролцох байдал зэрэг нийгмийн үзүүлэлтүүдээр ямар байдалтай байна. Хоёрдугаарт, ядуучуудын дотор эмэгтэйчүүд өрх толгойлсон өрхүүд олон байна уу? гэсэн асуудлууд юм. Эдгээр асуултад харинулах болон ядуурлын тодорхойлолтыг тохиромжтой байлгахын тулд энд хэрэглээний зардлын хэмжээсээр өгүүллээ хязгаарлажээ. Монгол Улсын хувьд эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн ядуурлын индекс илүү өндөр байна гэж дурьджээ. Ялангуяа хот суурин газарт нийт хүн амын 20 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх байхад, түүний 60 хувь нь ядуу байна гэжээ. Судлаач дээрх асуудлуудыг хөндөөд эмэгтэйчүүд толгойлсон өрхүүдийн ядуурал нь онцгой тохиолдол юм гэж дүгнэжээ. Түүнчлэн өрхүүдийн бүтцийн ялгаатай байдлыг авч үзсэн байна.

*Энэ бүтээл нь эмэгтэйчүүдийн ядуурлын асуудлыг сонирхон судлаж буй судлаач, бодлого боловсруулагчдад олон орны жишээ, туршлагыг танилцуулах болно. Энэхүү ажил нь ядуурал дахь хүйсийн ялгаатай байдлыг судалсан бөгөөд ядуурлын судалгаа, ядуурлыг бууруулах бодлогын хүрээнд чухал ач холбогдолтой болно. Эмэгтэйчүүдийн ядуурлын асуудлыг олон талаас нь тухайлбал, эрүүл мэнд, хоол хүнс, боловсрол, ажиллах хүчний оролцоо, цаг ашиглалт зэргээр авч үзэхдээ дотор нь бус нутаг тус бүрийн хувьд болон улс орны жишээн дээр харуулснаараа онцлог ажил болсон байна.*

#### 043

**Лувсандорж, П. (Luvsandorj, P). (1998). Mongolia: Strategies for Transitional Economy (Монгол Улс: Шилжилтийн эдийн засгийн стратеги), EDAP Joint Policy Studies 4. Австрали: Asia Pacific Press.**

*Өгүүлэл, 17 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Шилжилт, өсөлт

*JEL:* P20, O40

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын эдийн засгийн шилжилтийн нөхцөл байдлыг судалж, шилжилтийн үед эдийн засгийг хөгжүүлэх стратегийг авч үзсэн. Эхний хэсэгт, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явцыг авч үзсэн байна. Харин хоёрдугаар хэсэгт, эдийн засгийн шинэчлэлтийн бодлогыг авч үзжээ. Зах зээлийн тогтолцоо нь шинжлэх ухаан, технологийн шинэ шинэ ололт бүхий өндөр бүтээмжтэй эдийн засгийг бүрдүүлнэ гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.

*Судалгаа нь эдийн засгийн шилжилтийн үйл явцын талаар сонирхолтой дүгнэлт хийж, мэдээ баримтаар баяжуулагдсан байна. Шилжилтийн эдийн засгийг судлаж байгаа хүмүүст онол арга зүйн ач холбогдолтой юм.*

## 044

**Лхагважав, С. (1998). Малчин өрхийн аж ахуйн хөгжлөөс мал аж ахуйн хөгжил хамаарна. Хөдөө аж ахуйн эдийн засаг сэтгүүл. 1998-1(01).**

*Өгцлэл, монгол*

*Түлхүүр цгс:* ядуурал, хөдөө аж ахуй

*JEL:* I30, Q10

Хөдөө аж ахуйн хөгжил нь анхдагч нэгж болсон малчин өрхүүдийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай болохыг тоо баримтаар харуулж улмаар 1992 оноос хойшхи судалгаагаар хөдөөд баян хоосны ялгаа нэмэгдэж байгааг болон энэ ялгааг багасгахад хэрэглэж болох арга замуудыг тодорхойлжээ.

*Хөдөөгийн ядуурлыг сонирхон судлаж байгаа хүмүүс шилжилтийн эхэн үе дэх малчин өрхийн аж байдалд гарч байгаа өөрчлөлтийг танин мэдэхэд ач холбогдолтой өгцлэл юм.*

## 045

**Маккинли, Т (McKinley, T). (2003). The Macroeconomics of Poverty Reduction, Initial Findings of the UNDP Asia-Pacific Regional Programme (Ядуурлыг бууруулах макро эдийн засгийн онол, НҮБ-ийн Ази-Номхон далайн бүс нутгийн хөтөлбөрийн эхний ололтууд). Discussion Paper..**

[http://www.networkideas.org/featart/sep2003/Terry\\_McKinley.pdf](http://www.networkideas.org/featart/sep2003/Terry_McKinley.pdf)

*Өгцлэл, 36 хуудас, англи*

*Түлхүүр цгс:* Ядуурал, ядуурлыг бууруулахад чиглэсэн эдийн засгийн өсөлт

*JEL:* I30, O40

Энэхүү өгүүлэл нь макро эдийн засаг, бүтцийн өөрчлөлтийн бодлого нь ядууралд үзүүлэх нөлөөллийг судалжээ. Судалгаанд Бангладеш, Вьетнам, Индонези, Кампуч, Монгол, Мянмар, Непаль, Хятад, Шриланка зэрэг 9 оронд хийгдсэн кейс судалгааны анхны үр дүнгүүдийг тусгасан байна. Эдгээр орнуудын нэг хүнд ногдох ДНБ, өсөлтийн хурд, инфляци, ядуурал, хөрөнгө оруулалт, хадгаламж, зээлийн хүү, татвар, эдийн засгийн салбарууд, ажил эрхлэлт зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулсан байна. Бодлогуудын үр дүнг орон орноор шинжилж дүгнэжээ.

*Энэ ажил нь Монголын талаар олон сонирхолтой тоон өгөгдлүүдийг агуулаад зогсохгүй бусад орнуудтай харьцуулснаараа ихээхэн сонирхолтой, ач холбогдолтой болжээ. Ядуурлыг бууруулахад чиглэгдсэн эдийн засгийн өсөлтөнд хүрэхийн тулд ямар бодлого хэрэгжүүлбэл зохих, энэ тал дээр бусад орны сургаж, туршлага ямар байгааг харуулснаараа бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдэд өргөн хэрэглэгдэх боломжтой.*

**046****Монгол Улсын Засгийн Газар. (1994). Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр. Монгол, Улаанбаатар.**

*Баримт бичиг, 42 хуудас, монгол*

**Government of Mongolia. (1994). The national poverty alleviation programme. Mongolia, Ulaanbaatar.**

*Баримт бичиг, 35 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, нэн ядуу, эмзэг бүлэг, ажилгүйдэл, нийгмийн хамгаалал  
*JEL:* I30, E24, H55

Уг баримт бичгийн зорилго нь шилжилтийн эдийн засаг бүхий Монгол Улсад тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлуудын нэг болох ядуурлыг бууруулах, арилгах үндэсний үйл ажиллагааг хөтөлбөр болгон гаргах явдал юм. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр нь ядуурлыг арилгахад чиглэсэн Засгийн газрын зорилго, бодлого, үйл ажиллагааг тодорхойлсон анхны суурь баримт бичиг болжээ. Хөтөлбөрийн хүрээнд ядууст үр ашиг бий болгохуйц тэнцвэртэй эдийн засгийн өсөлтөнд чиглэсэн макро эдийн засгийн ба салбаруудын бодлого боловсруулах, төвлөрсөн болон орон нутгийн түвшинд ядуурлыг арилгах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг урамшуулах, эдийн засгийн сэргэлт, өсөлтөд хувь нэмрээ оруулах тогтвортой, өндөр түвшний хүний хөгжлийг бий болгох, хөдөөгийн болон эмэгтэйчүүдийн ядуурлыг арилгах, хүүхдийн зайлшгүй хэрэгцээг хангах нийгмийн хамгааллын сүлжээг боловсронгуй болгох болон хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Засгийн газар, хандивлагчидтай гэрээ хэлцэл байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Хөтөлбөрт үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүжилтийг эх үүсвэрээр тодорхой харуулсан байна.

*Шилжилтийн үед Монгол Улсад үүсээд байсан ядуурлыг арилгах талаар боловсруулагдсан үйл ажиллагааны анхны хөтөлбөр учраас ядуурлыг бууруулахад маш их ач холбогдолтой болсон байна. Бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч болон судлаачид ашиглахад тохиромжтой. Харин хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн хянах, зорилгуудыг ямар цаг хугацаанд хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй нь учир дутагдалтай юм.*

**047****Монгол Улсын Засгийн Газар. (1995). Ядуурал, ядуурлыг бууруулах үндэсний бодлого, үйл ажиллагаа. Монгол Улсын Үндэсний илтгэл, Нийгмийн хөгжлийн асуудлаархи дэлхийн дээд хэмжээний уулзалт. (х 15-20). Монгол, Улаанбаатар.**

*Номын бүлэг, 6 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, ядуурлын шалтгаан, нэн ядуу  
*JEL:* I30

Ядуурал, ажилгүйдлийг арилгахад тулгарч байгаа бэрхшээлийг даван туулах арга замыг тодорхойлох зорилготой. Илтгэлд ядуурал гэж юу болох, ядуурлын шалтгаан, ЯБҮХ-ийн зорилго, зорилтуудыг тодорхой оруулсан байна.

*Дэлхийн дээд хэмжээний уулзалтаас ядуурлыг багасгах талаар гарах шийдвэр нь Монгол Улсад ядуурлыг бууруулахад чухал ач холбогдолтой болно гэж найдвар тавьжээ.*

#### 048

**Монгол Улсын Засгийн Газар (The Government of Mongolia). (2001). Sector strategies and project proposals 2001-2004 (Салбаруудын стратеги ба төслийн саналууд 2001-2004), Монгол, Улаанбаатар**

*Баримт бичиг, 243 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Бага болон дунд орлоготой өрхүүд, ядуурал, ажилгүйдэл, амьжиргааны түвшин  
*JEL:* I30, I32, E24

Уг баримт бичгийн зорилго нь 2001-2004 онд хэрэгжүүлэх макро эдийн засгийн удирдлага, шинэчлэлийн хөтөлбөр ба салбаруудын стратегиудын талаар нарийн тодорхой мэдээллээр хангах явдал юм. Баримт бичиг нь Засгийн газрын эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги, макро эдийн засгийн удирдлага болон стратегийн дунд хугацааны хөтөлбөрийг салбар тус бүрээр харуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйл ажиллагаа нь хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах ба нийгмийн хамгааллын үйлчилгээг хүчтэй болгоход чиглэнэ. Дунд хугацааны зорилго нь ядуусын тогтвортой амьжиргааг дэмжих эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулах нийгмийн бодлого хэрэгжүүлэхэд оршино гэж үзсэн.

*Хандивлагчид болон бодлого боловсруулагчдад зориулсан. Дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд, үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлон гаргасан байна. Салбарын стратегийн талаар мэдээлэл авахад боломжтой. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд тус болохуйц чухал материал юм.*

#### 049

**Монгол улсын Засгийн газар. (2001). Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр (National household livelihood capacity support). Улаанбаатар.**

*Баримт бичиг, 65 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* ядуу, нэн ядуу, өрхийн амьжиргаа, өрхийн амьжиргааны чадавх

*JEL:* I18, I30, I31

1994-2000 онд хэрэгжүүлсэн Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн ололт, амжилт, алдаа сургамж дээр үндэслэн түүний дараагийн шатны зорилт болгон Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас батлан гаргасан. Хүний хөгжлийн хүчин зүйл, чадавхийг дэмжин хөгжүүлэхэд шаардагдах эдийн засаг, нийгмийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар нэн ядуу болон ядуу өрхийг ядуурлаас гаргах, ядуу бус бага орлоготой өрхийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэх нь хөтөлбөрийн үндсэн зорилго гэж тодорхойлжээ. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хорооны бүрэлдэхүүн, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хорооны дүрэм гэсэн хавсралт хэсгүүдтэй бичигджээ.

Монгол Улсын хүн амын амьжиргааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал болон амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цр дүн, сургамжийг авч үзэн хөтөлбөрийн нийтлэг үндэслэлийг дэвшүүлэн гаргаснаараа ач холбогдолтой баримт бичиг болжээ.

## 050

**Монгол Улсын Засгийн Газар. (2001) Рио де Жанейрогийн 1992 оны дэлхийн чуулга уулзалтаас хойш тогтвортой хөгжлийн салбарт Монгол Улсын олсон ололт амжилтын тухай үндэсний илтгэл. Монгол, Улаанбаатар.**

*Илтгэл, 2 хуудас, монгол, англи.*

**Түлхүүр үгс:** Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр  
**JEL:** I30

Рио де Жанейрогийн 1992 оны дэлхийн чуулга уулзалтаас хойш тогтвортой хөгжлийн салбарт Монгол Улсын олсон ололт амжилтыг харуулах зорилготой. Уг илтгэлд ядуурлыг бууруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөрөнгө нөөц санхүүжилт, улс төрийн дэмжлэг, эрх зүйн дэмжлэг, зохион байгуулалт, удирдлагын бүтцийг харуулжээ. Үндэсний хэмжээнд тулгамдаж буй асуудал, өсөн нэмэгдэж буй ядуурал гэсэн хэсэгтээ ядуурлын асуудлыг авч үзсэн.

*Ядуурлын асуудлыг хүрээлэн буй орчны доройтолтой холбож үзсэнээрээ онцлогтой.*

## 051

**Монгол Улсын Засгийн газар, (2003.09). Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг. Улаанбаатар: Санхүү, эдийн засгийн яам.**

**Government of Mongolia, (2003.09). Economic Growth Support and Poverty Reduction Strategy. Ulaanbaatar: Ministry of Finance and Economy.**

**Монгол Улсын Засгийн газар, (2003.11). Economic Growth Support and Poverty Reduction Strategy. Улаанбаатар: Санхүү, эдийн засгийн яам.**

*Баримт бичиг, 258 хуудас, монгол, англи.*

**Түлхүүр үгс:** Эдийн засгийн өсөлт, ядуурал.  
**JEL:** O40, I30

“Ядуурлыг бууруулах ба эдийн засгийн өсөлтийг дэмжих стратеги” нь Монгол Улсын Засгийн Газрын дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг хурдасгах болон ядуурлыг бууруулахад баримтлах гол гол бодлогын чиглэлүүдийг тусгасан баримт бичиг юм. Энэ нь 6 бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт, Монгол Улсын шилжилтийн үеийн өнөөгийн байдлыг макро эдийн засаг, хүн ам, ядуурал, жендер, хүний аюулгүй байдлын хүрээнд авч үзэн, Засгийн газраас ядуурлыг бууруулах чиглэлд хийсэн гол гол арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийжээ. Хоёрдугаар бүлэгт, ядуурлыг бууруулах болон эдийн засгийн өсөлтийг дэмжих дунд хугацааны стратегийн хамрах хүрээ, стратегийг боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангасан байдал болоод ядуурлыг бууруулахад чиглэсэн эдийн засгийн өсөлтийн дунд хугацааны зорилтыг агуулжээ. Гуравдугаар бүлэгт, дунд хугацаанд санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг

хангах зорилтуудыг, тэдгээрийг хангах арга замуудыг хөнджээ. Дөрөвдүгээр бүлэгт, зах зээлийн хүртээмжийг сайжруулах дунд хугацааны стратегийг бизнесийн орчин, эрх зүйн шинэчлэл, дэд бүтэц, Гадаадын шууд хөрөнгө оруулалт, зах зээлийн хүртээмж, бүсийн ба хөдөөгийн хөгжил болон хүрээлэн буй орчны хүрээнд тодорхойлжээ. Тавдугаар бүлэгт, хүний тогтвортой хөгжлийг хангах стратегийг боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, нийгмийн халамж, хүйсийн тэнцвэртэй байдал гэсэн хүрээнд тодорхойлжээ. Зургаадугаар бүлэгт, стратегийг хэрэгжүүлэх болон түүний хөндлөнгийн хяналтыг хэрхэн хангах тухай бичжээ.

*Энэхүү баримт бичиг нь салбар бүрийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, улмаар дунд хугацааны зорилтуудыг тооцоолж, түүнд хүрэхийн тулд баримтлах гол стратегиудыг тодорхойлжээ. Шинжилгээндээ өргөн баялаг тоон мэдээлэл, баримтууд ашигласан байна. Энэ нь судлаачид, оюутнууд төдийгүй, олон нийт, ард иргэдэд засгийн газраас хэрэгжүүлж ирсэн бодлого, түүний үр дүн, цаашид хэрэгжүүлэх гэж буй бодлого, стратегийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгч буйгаараа ихээхэн ач холбогдолтой юм. Гэвч стратегиуд нь эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ядуурлыг бууруулах гол зорилттой нь хэрхэн холбогдож буй нь бүрхэг байна.*

## 052

### **Монгол Улсын Засгийн Газар (Government of Mongolia). (2003). Medium-Term Regional Development Strategy of Mongolia, 2001-2010 (Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн дунд-хугацааны стратеги, 2001-2010). Монгол, Улаанбаатар хот**

*Баримт бичиг, 60 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* бүс нутгийн хөгжил

*JEL:* O18

Энэ нь Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл, баримтлалд тусгагдсан 5 бүсийг (Баруун, Хангай, Төв, Зүүн болон Улаанбаатар) 2010 хүртэл хөгжүүлэх дунд хугацааны стратегийг тодорхойлсон баримт бичиг юм. Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдтэй холбоотой, нийгэм-эдийн засгийг бүхэлд нь хөгжүүлэх нэгдмэл бодлого, арга зүйг тодорхойлон, түүнийг бүс нутгуудын онцлог байдалд хэрхэн хэрэгжүүлэхийг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гаргаж өгсөн байна. Эдгээр стратегиудыг хэрэгжүүлэх нийгэм-эдийн засгийн дэд зориултуудад ядуурал, түүнтэй холбоотой асуудлуудыг оруулж, эдгээр зорилтууд хэрэгжснээр гарах хүлээгдэж буй үр дүнгүүдийг тодорхойлжээ.

*Монгол Улсын нийгэм-эдийн засгийг 5 бүсээр хөгжүүлэхэд нэгдсэн ямар бодлого баримтлах, бүс тус бүрт эдийн засгийн өөр өөр боломжит нөхцөл байдалд дэвшицлсэн зорилгоо хэрхэн хэрэгжүүлэх, ямар үр дүнгүүд гарч болохыг тодорхойлсон төрийн баримт бичиг учраас хэн боловч ашиглаж болохоос гадна эрдэмтэн судлаачид нийгэм-эдийн засгийн хөгжлийн судалгаандаа ашиглахад чухал мэдээлэл болох юм. Бүс нутгуудын онцлог, давуу болон сул талууд, ядуурал, нийгмийн ялгаатай байдлыг бууруулахад баримтлах бодлого, арга хэрэгсэл, үзүүлэлтүүдийг тодорхойлсон учраас орон нутгийн удирдлага, нийгмийн ажилтнуудын үйл ажиллагааны үндсэн чиглэл болно.*

## 053

**Монгол Улсын Засгийн газар ба НҮБХХ. (1997). Монголын хүний хөгжлийн илтгэл 1997. Монгол, Улаанбаатар: Адмон хэвлэл.**

**The Government of Mongolia & UNDP. (1997). Human Development Report of Mongolia 1997. Mongolia, Ulaanbaatar: Admon Press.**

*Илтгэл, 69 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* хүний хөгжил, засаглал

*JEL:* O15, H00

Энэхүү илтгэл нь Монгол Улсын хүний хөгжлийн анхны илтгэл юм. Илтгэлийг бичих ажлын хүрээнд Монголд анх удаа хүний хөгжлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Хүний хөгжлийн гол үзүүлэлтүүд тус бүрд дүн шинжилгээ хийжээ. Түүнчлэн засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогууд, тэдгээрийн хүний хөгжилд үзүүлж буй нөлөөллийг судалж, цаашид хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж өгч, Монголын нийгэм, эдийн засгийн талаар арвин баялаг мэдээлэл багтаасан байна. Илтгэлийн гуравдугаар бүлгийн нэгдүгээр хэсэг нь ядуурал, орлого хуваарилалтад анхаарлаа хандуулсан байна. Энд аймгуудыг ядуурлын түвшнээр нь эрэмбэлж бүлэглэсэн бөгөөд Өмнөговь аймаг хамгийн өндөр букуу ядуурлын түвшин нь 41.9 хувь байна гэжээ.

*Илтгэлд хүний хөгжил, ядуурал, орлого хуваарилалт, өрхийн амьжиргаатай холбоотой баялаг тоон мэдээлэл оруулсан нь судлаачид, оюутнууд цаашдын судалгаандаа хэрэглэх боломжтой юм. Харин шинжилгээнд хэрэглэсэн ядуурлын талаарх тоон мэдээлэл нь арга зүйн хувьд 1995, 1998 оны амьжиргааны түвшний түцвэр судалгаанаас ялгаатай.*

## 054

**Монгол Улсын Засгийн газар ба НҮБХХ. (2000). Монголын хүний хөгжлийн илтгэл 2000. Монгол, Улаанбаатар: Адмон хэвлэл.**

**The Government of Mongolia & UNDP. (2000). Human Development Report of Mongolia 2000. Mongolia, Ulaanbaatar: Admon Press.**

*Илтгэл, 66 ба 58 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* хүний хөгжил, засаглал.

*JEL:* O15, H00

Монголын хүний хөгжлийн илтгэл 2000 нь “Төрийг шинээр зүглүүлэхүй” сэдвээр бичигдсэн бөгөөд 6 бүлгээс бүрдэнэ. Уг илтгэлд шинээр бий болгосон тогтолцоонд төрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж, Монгол Улсын хүний хөгжлийн индекс, хүний хөгжлийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн хандлагыг шинжилж, эдийн засгийн өнөөгийн байдал, төрөөс хэрэгжүүлж буй бодлогыг авч үзэж, хүрээлэн буй орчинд гарч байгаа өөрчлөлтүүд, энэ чиглэлд хэрэгжүүлэх бодлогыг судалж, нийгмийн салбарт хэрэгжүүлэх төрийн бодлого, энэ салбарын өнөөгийн байдлыг авч үзэж, монголын засаглалын өнөөгийн байдлыг шинжлэн цаашдын өөрчлөлт, шинэчлэлтийн чиглэлийг тодорхойлжээ. Илтгэлд, ядуурал, орлогын тэгш бус хуваарилалт нь анхаарал татах гол асуудлууд болохыг дурдаад нийгмийн салбарын санхүүжилт буурсаар байгаа нь энэ салбарт нийгмийн хамгааллын шинэ, үр нөлөө бүхий тогтолцоог бүрдүүлэхгүй бол цаашдаа хүний хөгжилд сөргөөр нөлөөлнө гэжээ.

Монголын хүний хөгжлийн илтгэл 2000 нь шинэ тогтолцоонд төрийн гүйцэтгэх үүрэг, төрийн бодлогын үр нөлөөг үнэлж дүгнэн, цаашдын чиг хандлагыг тодорхойлсноороо ач холбогдолтой юм. Түүнчлэн ядуурал, орлого хуваарилалт, өрхийн амьжиргаа, нийгмийн салбартай холбоотой болон макро эдийн засгийн талаар өргөн хүрээтэй тоон мэдээлэл агуулсан нь судлаачид, оюутнууд цаашдын судалгаандаа ашиглах боломжтой юм.

## 055

**Монгол Улсын Засгийн газар ба НҮБХХ. (2002). “Хөгжлийн стратегид Ядуурлыг бууруулах асуудлыг тусгах нь” сэдэвт үндэсний семинарын тайлан. 1-р дэвтэр. Монгол, Улаанбаатар: Амаржаргал Сан.**

**The Government of Mongolia & UNDP. (2002). “National Workshop on “Integrating Poverty Reduction Into Development Strategy”. Vol 1. Mongolia, Ulaanbaatar: Amarjargal Foundation.**

*Эмхэтгэл, 104 хуудас, монгол, англи.*

*Түлхүүр үгс:* Ядуурал, орлого хуваарилалт, албан бус сектор  
*JEL:* I30, O15, O17

Монгол Улсын Засгийн газар НҮБХХ-тэй хамтран “Хөгжлийн стратегид ядуурлыг тусгах нь” семинарийг Засгийн газрын “Сайн засаглал, хүний аюулгүй байдал” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан байна. Энэхүү эмхэтгэл нь үндэсний семинарын хүрээнд хэлцэгдсэн асуудлуудыг нэгтгэсэн байна. Семинарт Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга, Засгийн газрын болоод Улсын Их Хурлын гишүүн зэрэг албаны хүмүүс, нийт 160 гаруй хүн оролцож санал бодлоо солилцжээ.

*Энэ материал нь янз бүрийн салбарын хүмүүсийн ядуурлыг бууруулах, эдийн засгийг хөгжүүлэх талаарх харилцан адилгүй үзэл бодлыг тусган харуулснаараа сонирхолтой юм. Ядууралтай холбоотой асуудлуудыг сонирхон судалдаг судлаачид, оюутнууд болон бодлого боловсруулагчдад мэдээлэл, шинэлэг санаа өгөх ач холбогдолтой.*

## 056

**Монгол Улсын Засгийн газар ба НҮБХХ. (2002). “Хөгжлийн стратегид Ядуурлыг бууруулах асуудлыг тусгах нь” сэдэвт үндэсний семинарын тайлан. 2-р дэвтэр. Монгол, Улаанбаатар: Амаржаргал Сан.**

**The Government of Mongolia & UNDP. (2002). “National Workshop on “Integrating Poverty Reduction Into Development Strategy”. Vol 2. Mongolia, Ulaanbaatar: Amarjargal Foundation.**

*Эмхэтгэл, 214 хуудас, монгол, англи.*

*Түлхүүр үгс:* Ядуурал, орлого хуваарилалт, албан бус сектор  
*JEL:* I30, O15, O17

К. Гриффин нь 1994 онд хийгдсэн “Монголын эдийн засгийн шилжилт ба ядуурал”, 2001 онд хийгдсэн “Ядуурал, тэгш байдлын асуудлуудыг улсын хөгжлийн стратегитай холбох нь” сэдэвт судалгааны багийн ахлагч юм. Энэхүү эмхэтгэл нь дээрх хоёр судалгааны тайлангуудаас бүрдсэн 2 үндсэн хэсэгтэй. Уг хоёр судалгаа нь монголын ядуурлыг макро эдийн засаг, нийгмийн



халамж, хүмүүн капитал, шилжих хөдөлгөөн ба МАА, ажил эрхлэлт, хүрээлэн буй орчин, засаглал, хөгжлийн стратеги, зээл тусламж зэрэг олон хүчин зүйлтэй холбож судалсан байна. Уг тайлангууд нь бүхэлдээ дараах агуулгатай. Нэгдүгээрт, нэг хүнд ногдох орлогын өсөлтийг хурдасгах, Хоёрдугаарт, тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь ядуурлыг бууруулах зайлшгүй нөхцөл болно. Гуравдугаарт, өсөлт ба тэгш байдал нь өөр хоорондоо зөрчилдөх учиргүй бөгөөд хөрөнгө дахин хуваарилах бодлогыг зөв хэрэгжүүлбэл эдийн засгийн өсөлтийг хурдасгах боломжтой. Дөрөвдүгээрт, ядуурлыг хурдан бууруулж болох нэг арга нь бүтээмжит ажил эрхлэлтийг бий болгох явдал юм. Тавдугаарт, шилжилтийн үйл явцыг удирдах шинэ байгууллагуудыг бий болгох, эдийн засгийн шинэчлэл хийх, улсын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, эмзэг бүлгийг дэмжих чадвар бүхий төр шаардлагатай. Түүнчлэн ядуурлыг бууруулахад гадны санхүүжилтийн гүйцэтгэх үүрэг их гэдгийг цохон тэмдэглэсэн байна.

*Энэхүү эмхэтгэл нь ядууралтай холбоотой асуудлаар судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэд, судлаачид, оюутнууд болон бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдэд монгол дахь ядуурлын талаархи гарын авлага болохуйц сайн бүтээл юм. Монголын ядууралтай холбоотой асуудлуудаар боломжтой тоон өгөгдлийг чадварлаг шинжилж, сонирхолтой дүгнэлтүүдийг хийсэн байна. Энэ нь зөвхөн практик зөвлөмж өгөөд зогсохгүй, онолын сонирхолтой асуудлуудыг дэвшилцэн тавьснаараа ач холбогдолтой. Эмхэтгэлд ядуурал, ядуурлыг хэмжих талаар гарч буй сүүлийн үеийн хөгжлийн хандлагуудыг харуулж монголын ядуурлын байдлыг түүнтэй холбон тайлбарлажээ.*

## 057

### **Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ ба МУИС-ийн ХАЗССТ. (2004).**

**Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн. Монгол, Улаанбаатар: Адмон хэвлэл. The Government of Mongolia, UNDP & PTRC of NUM. (2004). Urban Poverty and Migration. Mongolia, Ulaanbaatar: Admon Press.**

*Судалгааны тайлан, 133 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, шилжих хөдөлгөөн.

*JEL:* I30, O15

Энэ судалгааны тайлан нь Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшинг орлого, хэрэглээнд үндэслэн тооцож, ядуурал, шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлах зорилгоор хийгдсэн түүвэр болон чанарын судалгаанд түшиглэн бичигджээ. Түүвэр судалгаа нь хоёр шатлал бүхий санамсаргүй түүврийн аргаар хийгдсэн бөгөөд Улаанбаатар хотын нийт өрхийг 1500 өрхөөр төлөөлүүлжээ. Уг тайланд Улаанбаатар хотын ядуурлын түвшинг орлого, хүртээмж, нийгмийн оролцоо гэсэн гурван хүрээнд тодорхойлж, хүн амын 33 хувь нь орлого/хэрэглээний хувьд 24.5 хувь нь, хүртээмжийн хувьд 24.3 хувь нь нийгмийн оролцооны хувьд ядуу байна гэж дүгнэжээ. Түүнчлэн нийт хүн амын 10 хувь нь орлогын хувьд нэн ядуу буюу сарын орлого/хэрэглээ нь ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй байгааг тэмдэглэжээ.

*Судалгаа нь ядуурал ба шилжих хөдөлгөөнийг хамтад нь авч үзсэнээрээ ач холбогдолтой бөгөөд ядуурлын цаашдын судалгаанд ашиглагдахуйц, өргөн мэдээлэл агуулсан үр өгөөжтэй ажил болжээ. Ядуурлын асуудлыг тал бүрээс нь авч үзэж, шинэлэг үзүүлэлтүүдээр*

хэмжих оролдлого хийсэн нь шинэлэг юм. Харин орлого хуваарилалтын хэмжүүрцүдийг зарлагаар хэмжсэн нь тэдгээр үзүүлэлтүүдийг цаашдын судалгаанд уламжлалт хэвшсэн утгаар хэрэглэгдэх боломжийг хязгаарлажээ.

## 058

**Монгол Улсын Засгийн газар, Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр. (2003). Сайн засаглал, ядуурал ба ажилгүйдэл. Монгол, Улаанбаатар.**

*Ном, 111 хуудас, монгол.*

*Түлхүүр үгс:* Хөдөлмөрийн нөөц

*JEL:* J21

Өнөөгийн нөхцөл дэх ядуурал, ажилгүйдлийн дүр төрхийг тодорхойлох зорилготой. Энд ядуурал гүнзгийрч, орлогын тэнцвэрт байдал алдагдсаар байгааг тоо баримтаар харуулжээ. Мөн хүний эрүүл мэндийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал хэрхэн алдагдаж байгаа талаар тодорхой жишээгээр тайлбарлаад ядуурлыг бууруулахад төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцох хэлбэрийг 6 чиглэлээр тодорхойлсон байна.

*Ядуурлыг бууруулахын тулд бүх үе шатуудад тухайлбал, бодлого боловсруулахад, ядуурлын асуудалд дүн шинжилгээ хийхэд, төрийн үйлчилгээ явуулахад гэх мэт анхаарах асуудлуудыг тодорхой гаргаж тавьсан нь зөвхөн судлаачдад төдийгүй бодлого боловсруулагчид, ядуурлын цнэлгээ хийж, цр дүнг тодорхойлж байдаг хүмүүст гарын авлага болохуйц ач холбогдолтой болжээ.*

## 059

**Монгол Улсын Засгийн Газар. (Government of Mongolia). (2001). The government's medium term strategy and policies to deepen economic reform and restructuring (Засгийн газрын дунд хугацааны стратеги болон эдийн засгийн өөрчлөлт, бүтцийн шинэчлэлтийг гүнзгийрүүлэх бодлогууд). Монгол, Улаанбаатар.**

*Баримт бичиг, 26 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, эдийн засгийн хөгжил

*JEL:* F35, E60, I38

Энэ баримт бичигт Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих он жилүүдэд олон улсын хандивлагч байгууллагууд болон донор орнуудтай хамтран ажилласнаар эдийн засаг, нийгмийн хөгжилд ахиц дэвшил гарч эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийг цаашид гүнзгийрүүлэхийн төлөө чармайж байгааг тодорхой харуулжээ. Бодит судалгаанд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн стратегийг боловсруулжээ. ЗГ-ын стратеги цаашдын зорилго нь шилжилтийн үеийг хөнгөвчлөх эдийн засгийн өөрчлөлт, нийгмийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, гол зорилтууд нь макро эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засгийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх, санхүүгийн секторын болон дэд бүтцийн салбарын өөрчлөлтийг түргэтгэх, экспортод чиглэсэн эдийн засгийг бий болгох юм. Эн тэргүүний зорилт нь ядуурлыг бууруулах стратеги болон нийгмийн салбарын өөрчлөлтийн бодлогууд байх болно гэдгийг тэмдэглээд цаашдаа макро эдийн засгийн

тогтворжилтыг хангах, эдийн засгийн өсөлтийг хурдасгах боломжийг бүрдүүлэхийн тулд хөгжлийн албан ёсны тусламжийг хэрэглэх шаардлагатай. Түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, ялангуяа макро эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэхэд донор болон хөрш орнуудын тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэхийн чухлыг баримтаар харуулсан байна.

*Дунд хугацаанд хэрэгжүүлэх цйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон. Макро эдийн засгийн талаарх статистикийн тоон мэдээллүүд багтааснаараа хандивлагчид, бодлого боловсруулагчдад цнэ цэнэтэй баримт бичиг болжээ.*

## 060

**Монгол Улсын Засгийн Газар. (Government of Mongolia). (2001). Cooperation with the international donor community and requirements for ODA (Олон улсын донор орнуудын хамтын ажиллагаа ба хөгжлийн албан ёсны тусламжийн шаардлага).**

**Монгол, Улаанбаатар.**

*Баримт бичиг, 11 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, олон улсын хамтын ажиллагаа, гадаадын зээл, тусламж  
*JEL:* F35, F42

Энэхүү баримт бичигт олон улсын донор орнуудын тусламж нь макро эдийн засгийг тогтворжуулах, бүтцийн өөрчлөлтийг хурдасгах, шинэтгэлийг түргэтгэх, экспортын шинэ зах зээлийг судлах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, дотоодын хадгаламжийг нэмэгдүүлэх, нийгмийн салбарын асуудлыг шийдвэрлэх зэрэгт чухал үүрэгтэй болохыг харуулжээ. Түүнчлэн тусламжийн амлалт, зарцуулалтын байдал, Засгийн газрын эдийн засгийн бодлого, стратеги болон хөгжлийн албан ёсны тусламжийн уялдаа холбоо, тусламжийн менежментийг оновчтой болгоход Засгийн газраас тавьсан хүчин чармайлт, хөгжлийн албан ёсны тусламж дахь Засгийн газрын эн тэргүүний зорилт, хөгжлийн албан ёсны тусламжтай холбоотой 2001-2004 оны санхүүгийн эрэлт хэрэгцээ зэрэг донор орнуудын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллүүдийг агуулжээ.

*Монгол Улсын эдийн засагт зээл, тусламжийн гүйцэтгэх цэргийг тодорхойлж, 1990 оноос хойшхи зээл, тусламжийн байдал, үр дүнгийн талаар хандивлагчид, бодлого боловсруулагчдад өргөн хүрээтэй бодит мэдээлэл өгөх зорилготой баримт бичиг болжээ.*

## 061

**Монгол Улсын Засгийн газар. (Government of Mongolia). (2001). Interim poverty reduction strategy paper (Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг).**

**Монгол, Улаанбаатар.**

*Баримт бичиг, 64 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг  
*JEL:* I30

Энэхүү баримт бичгийн эхний хэсэгт Монголын эдийн засаг болон ядуурлын талаар дэлгэрэнгүй авч үзсэн байна. Дараагийн хэсэг нь уг стратегийн баримт бичгийн гол агуулгыг тусгажээ. Үүнд, ядуурлыг бууруулах стратегийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг ядуурлыг бууруулах ерөнхий стратеги,

макро эдийн засгийн хүрээ, хүний тогтвортой хөгжил, дэд бүтцийн хөгжил, бүс нутаг болон орон нутгийн хөгжил, байгаль орчны хамгаалал, засаглал, дунд хугацааны зорилго гэсэн үндсэн бүтэцтэйгээр авч үзжээ. Эцэст нь, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулах зохион байгуулалтын асуудал, уг арга хэмжээнд төр, олон нийтийн байгууллагуудын оролцоо ямар байх түүнчлэн ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна. Мөн хавсралт болгож Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тухайн үеийн бодит болон ирээдүйн төлөв байдлаар харуулсан байна.

*Монгол Улсын засгийн газраас ядуурлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ, түүнийг хянах механизмыг олон нийтэд танилцуулснаараа ач холбогдолтой ажил болжээ.*

## 062

**Монгол Улсын Сангийн Яам, МОРЕС, ЖАЙКА ба МХБДЯГ-ийн хамтарсан судалгааны төсөл. (1997). Монголд хөгжлийн албан ёсны тусламжийг үр дүнтэй ашиглах зөвлөмж. Монгол, Улаанбаатар.**

*Зөвлөмж, 35 хуудас, монгол*

*Түлхүүр цгс:* Хүний хөгжил, ядуурлыг бууруулах стратеги  
*JEL:* O15

Уг зөвлөмж нь Монгол Улсын Засгийн Газарт хөгжлийн албан ёсны тусламжийг үр ашигтай ашиглах асуудлыг нухацтай судлан үзэж цаашдын ажил хэрэгтээ санаа авахад дэмжлэг үзүүлэх зорилготой хамтарсан судалгааны төслийн жилийн эцсийн үр дүн юм. Монгол Улсад үзүүлж буй хөгжлийн албан ёсны тусламжийн (ХАЁТ) хэмжээ багасах хандлагатай байгаа нь ХАЁТ-ийг үр ашигтай ашиглах асуудлыг хэлэлцэх шаардлагыг бий болгожээ. ХАЁТ-ийг хөгжлийн стратеги, бүтцийн өөрчлөлт, хүний хөгжилтэй нягт холбон авч үзэх, ЗГ ядуурлыг бууруулах хөтөлбөрийн жишээгээр төрийн бус байгууллагууд, Монголд буй НҮБ-ын сайн дурынхантай хамтран ажиллах шаардлагатай гэсэн зөвлөмжийг хандивлагчид гаргасан байна.

*Энэхүү зөвлөмжийг Засгийн газар болон хандивлагчдад зориулжээ. Хөгжлийн албан ёсны тусламжийг хэрхэн үр ашигтай зарцуулах талаар зөвлөмж болсноороо ач холбогдолтой юм. Цаашид бусад төрлийн зээл тусламжид мөн ийм зөвлөмж гаргах нь үр өгөөжтэй.*

## 063

**Монгол Улсын Засгийн Газар, Санхүү Эдийн Засгийн Яам. (2003). Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил 2002 онд. Монгол, Улаанбаатар.**

*Товхимол, 126 хуудас, монгол*

*Түлхүүр цгс:* Ядуурал, нийгмийн хамгаалал  
*JEL:* I30, H55

Энэхүү товхимол нь Монгол Улсын Засгийн Газар, СЭЗЯ-аас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар 2002 онд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, үр дүнг 7 бүлэг, хавсралтуудаар гаргасан байна. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд, салбаруудад хийсэн ажил, гарсан үр дүн, төлөв байдлыг бүхэлд нь тоон болон чанарын хэмжүүрээр

илэрхийлжээ. Ингэхдээ ядууралтай холбогдсон асуудлуудын төлөв байдлыг нийгмийн хамгаалал, бараа үйлчилгээ худалдан авалт, цалин, тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговор, шилжүүлэг гэсэн салбар бүлгүүдэд дотоодын хөрөнгө оруулалтыг анх удаа тухайн ондоо багтаан санхүүжүүлсэн; нийт төсвийн хөрөнгө оруулалтын 8%-ийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт хийсэн зэрэг үр дүнгүүдээр тодорхойлсон байна. Мөн “Хүний хөгжил, нийгмийн бодлого” гэсэн тусгай бүлгээр нийгмийн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, нийгмийн даатгал ба халамж, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, үр дүнг тусгайлан тодорхойлж өгсөн байна.

*Уг товхимол нь олон нийтэд зориулагдсан учир нийгэм-эдийн засгийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх албан ёсны мэдээлэл олохыг хүссэн иргэн, судлаач эрдэмтэн гээд хэн боловч ашиглаж болох юм. Засгийн Газар, СЭЗЯ-аас эрхлэн гаргасан, бүхэлдээ сайн, эерэг үр дүнгүүдийг илтгэсэн, нэг талын хандлага, дүгнэлт, мэдээллийг агуулсан товхимол юм. Энэ товхимолоос 2002 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төслүүд, бодлого, арга хэмжээнүүд болон албан ёсны статистик тоон мэдээллийг дэлгэрэнгүй олж авч болох ба Засгийн газар, СЭЗЯ-ны нийгэм-эдийн засгийн бодлого, үйл ажиллагаатай тодорхой танилцан, үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой юм.*

## 064

**Монголын макро эдийн засгийн судалгааны баг ба Монголын хөгжлийн бодлогыг дэмжих Японы баг (Mongolian Macroeconomic Research Group & Mongolian Development Policy Support Group of Japan). (1994). Social problems and the safety net. Joint study on Mongolian economic development: major issues of transition to a market-oriented economy (Нийгмийн асуудлууд ба нийгмийн хамгааллын сүлжээ. Монголын эдийн засгийн хөгжлийн хамтарсан судалгаа: зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн гол асуудлууд), (бүлэг 1-6). Монгол, Улаанбаатар.**

*Судалгааны тайлан, 8 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ажилгүйдэл, ядуурлын шугам, нийгмийн хамгаалал  
*JEL:* I30, E24, H55

Уг судалгаа нь шилжилтийн үеийн нийгмийн хамгааллын сүлжээтэй холбоотой нийгмийн асуудлуудыг авч үзэх зорилготой юм. Судалгаанд нийслэл хот, орон нутгийн хотууд болон хөдөөгийн амьдралын хэв маягийг тус бүрд нь авч үзсэн. Ядуурлын шугамын үнэлгээ, ажилгүйдлийн бүртгэлтэй холбогдсон хүндрэл, ажилгүйдлийн шалтгаан, нийгмийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн сүлжээтэй холбогдсон асуудлыг авч үзсэн. Монгол Улсад тулгараад буй нийгмийн олон асуудлыг шийдвэрлэхэд хувийн секторын дэмжлэгийг авах, улсын ба хувийн секторууд хамтран ажиллах, гадаадын байгууллагуудыг үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд татан оролцуулах зэрэг зөвлөмжүүдийг гаргасан. Цаашид энэ талын судалгааг зөвхөн макро эдийн засгийн түвшинд бус бүс нутгийн хэмжээнд хийх шаардлагатай гэж үзжээ.

*Шилжилтийн үед Монгол Улсын эдийн засгийн хөгжилд тулгарч буй асуудлуудыг тодорхойлон гаргасан, цаашид хэрэгжүүлж болох бодлогын зөвлөмжүүдийг санал болгосноороо*

хамтарсан судалгаа нь чухал ач холбогдолтой болсон байна. Тухайн үеийн тоо мэдээлэл, бодлогын талаар баримт мэдээлэл авахад тохиромжтой материал юм. Эрдэмтэн судлаачид ашиглах боломжтой.

## 065

**Намсрай, Д. (2000). Ажилгүйдэл, инфляцийн хамаарал. Эдийн засаг: онол, практик сэтгүүл (? 2, х 51-58). Монгол, Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр**

*Өгцлэл, 8 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин

*JEL:* I30, E24, I31

Уг судалгааны зорилго нь ажилгүйдэл, инфляцийн хамаарлыг онолын болон эмпирик түвшинд судлах, бодлогын зөвлөмж өгөх юм. Макро эдийн засгийн бодлогод ажилгүйдэл, инфляци чухал байр суурь эзэлдэг. Ажилгүйдэл инфляцийн хамаарлыг онолын түвшинд Филиппсийн муруйгаар судалж Монгол Улсын статистикийн тоон өгөгдлүүдэд дүн шинжилгээ хийсэн байна. Ажилгүйдэл нь хүн ам ядууралд өртөх үндсэн шалтгаан болдог, өндөр инфляци нь аюултай гинжин холбоог үүсгэдэг ч ажилгүйдлээр түүнийг орлуулах нь улс орныг ядууралд хөтөлж байгаа хэрэг бөгөөд хөгжил, ядуурал, ажилгүйдэл, инфляци дөрөв өөр хоорондоо эвлэршгүй зөрчилтэй юм гэж дүгнэжээ.

*Макро эдийн засгийн чухал үзүүлэлтүүд болох ажилгүйдэл, инфляцийн хамаарлыг судалсан ч онолын болон практик судалгааны хэсэг нь хоорондоо уялдаа холбоо муутай, санал дүгнэлтүүд нь хэт ерөнхий лоозон маягаар өгсөн ажил болжээ. Оюутнууд, анхан шатны мэдлэг олж авах зорилготой уншигчдад зориулсан байна.*

## 066

**Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам. (2001). Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн-2001. Монгол, Улаанбаатар.**

*Судалгааны тайлан, 15 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны түвшин

*JEL:* I30, I31

Энэхүү судалгааны тайлан нь 2001 оны 5, 6 сард явуулсан ядуурлын улсын үзлэгийн дүнг нэгтгэжээ. Ядуурлын улсын үзлэгийн хүрээнд ихээхэн хэмжээний мэдээ мэдээлэл цуглуулсан байна. Судалгаа нь ядуу, нэн ядуу, бага орлоготой гэсэн ангиллын хүн амын амьжиргааны байдалд илүүтэй чиглэгджээ. Судалгааны үр дүнд нийт хүн амын 13.8 хувь нь бага орлоготой, 20.0 хувь нь ядуу, 16.3 хувь нь нэн ядуу байна гэж дүгнэжээ.

*Судалгаанд бага орлоготой буюу, ядуурлын ирмэг дээр байгаа хүн амын хувийн жинг тооцоолсноороо шинэлэг юм. Гэвч түүврийн төлөөлөлд төдийлөн анхаарал тавиагүй байна. Ядуурлын асуудлаар судалгаа, шинжилгээ хийх зорилготой бүх хүмүүст мэдээлэл өгөх ач холбогдолтой.*

## 067

**Нортон, А (Norton, A). (2001). A guide to PPAs: Participatory Poverty Assessment, an Introduction to Theory and Practice (Ядуурлын оролцооны аргын үнэлгээ, онол ба практикийн танилцуулга), UK Department for International Development's Social Development Department. <http://www.odi.org.uk/pppg/cape/ppatwo.pdf>**

*Судалгааны тайлан, 116 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал

*JEL:* I30

Их Британи улсын Олон улсын хөгжлийн тэнхмээс гаргасан уг судалгаанд ядуурлыг оролцооны аргаар үнэлэх зөвлөмжийг танилцуулж, түүний онол практикийн үйл ажиллагааг тайлбарласан байгаа. Ядуурлын оролцооны аргын үнэлгээний гол онцлог нь ядуурлыг хэмжин шинжлэх, ядуурлыг бууруулах бодлогыг боловсруулахад ядуучуудын өөрсдийнх нь бодол санааг өргөнөөр тусгадаг оршино. Энэ үнэлгээг ашиглан боловсруулсан ядуурлыг бууруулах бодлого нь илүү үр өгөөжтэй байж чаддаг гэж үзжээ. Уг судалгаанд ядуурлын оролцооны аргын үнэлгээний хөгжлийн түүх, үйл ажиллагааны гол зарчмууд, энэ үнэлгээний сул болон давуу талууд, судалгааны жишээ, үнэлгээний үр дүнг бодлого боловсруулах үйл явцтай холбох талаар дэлгэрэнгүй бичигдсэн бөгөөд Уганда улсын туршлагыг судалгааны жишээ болгон авч, Монгол Улсад хийгдсэн ядуурлын оролцооны аргын үнэлгээний ажлын талаар товч танилцуулсан байна. Монгол Улсад ядуурлын оролцооны үнэлгээг явуулахад Өрхийн тогтвортой амьжиргааны судалгааг өргөнөөр хэрэглэснийг судалгаанд дурджээ.

*Уг судалгаа нь ядуурлыг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж буй байгууллагуудын ажилтнууд, судлаач, эрдэмтдэд зориулсан ядуурлын оролцооны үнэлгээний талаар иж бүрэн мэдээлэл, танилцуулгыг агуулсан, хэн боловч хэрэглэх боломжтой судалгаа болсон байна.*

## 068

**Монгол дахь НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (UNDP Mongolia). (2002). Sustainable Development Indicators in Mongolia 2000: Report of the Study on Sustainable Development Indicators (Монгол дахь тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд 2000: Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд дээрх судалгааны тайлан). Монгол, Улаанбаатар.**

**<http://www.un-mongolia.mn/reports/files/survey%20report.pdf>**

*Судалгааны тайлан, 31 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Тогтвортой хөгжил, үзүүлэлтүүдийн тогтолцоо, ядуурлын үзүүлэлтүүд

*JEL:* O15, I32

Уг судалгааны тайланд дурьдснаар 1992 онд Бразил Улсын Рио-Де-Жанейро хотод Нийгмийн Хөгжил ба Хүрээлэн буй орчны асуудлаар хуралдсан НҮБ-ийн Хурлаас “Глобал Аженда 21” гэсэн тулгуур баримт бичиг гаргасан ба энд тогтвортой хөгжлийн нийт 134 үзүүлэлт багтсан байдаг. Үүний дагуу Монгол Улсын ЗГ-аас Үйл Ажиллагааны Хөтөлбөр “Аженда 21”-ийг нарийвчлан боловсруулж эхлүүлжээ. Өнөөг хүртэл үргэлжилж буй үйл явцаас харахад тогтвортой хөгжил нь хөгжлийн асуудалд чиглэгдсэн оновчтой шийдвэрийг

гаргахад шаардлагатай үзүүлэлтүүдийн тогтолцоог шаарддаг. Энэ тогтолцоо нь нийгэм-эдийн засаг, хүрээлэн буй орчны өгөгдлүүдийг үнэлсэн, тэдгээртэй холбогдсон мэдээллийн үр ашигтай бүтэц юм гэдэг нь тодорхой байна. Ийм нөхцөл байдалд уг судалгааны гол зорилго нь өнөөгийн нийгэм-эдийн засаг, хүрээлэн буй орчны өгөгдлүүдийн тархалт, бүрдүүлэлтийн тогтолцоо, тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийн бүрдлийг авч үзэн, харьцуулсан түүвэр судалгаа хийхэд чиглэгджээ. Манай улсын тогтвортой хөгжлийн өнөөгийн үзүүлэлтүүдийн боломжит хувилбарыг тодорхойлон, хөгжлөөр адил түвшний улсуудад хэрэглэж байгаа үзүүлэлтүүд, бусад хүчин зүйлсийг тооцон үндэсний хэмжээний болон аймгуудын түвшинд ямар үзүүлэлтүүд тогтвортой хөгжлийг илэрхийлэхийг тодорхойлж, сонгож авсан үзүүлэлтүүд манай улсын хувьд ямар байгааг үнэлсэн байна.

*Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийн тогтолцоонд ядууралтай холбогдсон үзүүлэлтүүд багтдаг болохоор энэхүү судалгааны ажлаас манай улсын ядуурлын төлөв байдлын статистик тоон мэдээлэл, тэдгээрийг тооцож гаргасан болон харьцуулсан судалгаатай танилцах боломжтой. Тогтвортой хөгжил, ядуурлын асуудал хоёрын уялдаа хамаарал агуулагддаг үзүүлэлт, түүний тоон үр дүнтэй танилцан оюутан, судлаач эрдэмтэн, бодлого боловсруулагч нар цаашид судалгаандаа ашиглах боломжтойгоороо энэхүү ажил ач холбогдолтой юм.*

## 069

**НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. (2001). Second country cooperation framework for Mongolia 2002-2006 (Монголд зориулсан хоёр дахь хамтын ажиллагааны хүрээ 2002-2006).**

[www.undp.org/execbrd/pdf/ccfmon2.PDF](http://www.undp.org/execbrd/pdf/ccfmon2.PDF)

*Тайлан, 11 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, тогтвортой хөгжил

*JEL:* I30, O10

Энэхүү тайланд Монгол хүний тогтвортой хөгжлийн нөхцөл байдлыг улс төр, эдийн засгийн шилжилт болон хүний тогтвортой хөгжлийн хэтийн төлөв байдлын хувьд авч үзэн өнгөрсөн үйл явцын үр дүн, сургамжуудыг өгүүлсэн байна. Эцэст нь НҮБХХ-ийн зорилго, хөтөлбөрийн хүрээ болон хүлээгдэж буй үр дүнг ардчилсан засаглал, эдийн засгийн шилжилт ба ядуурлыг бууруулах, байгалийн нөөцийн менежмент дэх түүний оролцоогоор тус тусад нь жишээ татан бичжээ. Энд ядуурлыг бууруулах үндэсний бодлого, стратегийг боловсруулахад НҮБХХ нь засгийн газрыг дэмжиж улмаар энэ хөтөлбөр нь ядуурал, ажилгүйдлийг бууруулах, орлого хуваарилалтыг оновчтой болгох, амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэгдэнэ гэжээ. Ядууралтай холбоотой боловсруулагдаж буй уг хөтөлбөр нь ядуурлын шалтгааныг задлан шинжлэх, эдийн засгийн бодлогуудыг тодорхойлох, үр ашигтай бодлогыг хэрэгжүүлэх зэрэг үр дүнд хүргэх юм.

*Энэ тайлан нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төр түүнчлэн НҮБХХ-өөс хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн зорилго, хүрээ болон хүлээгдэж буй үр дүнгийн талаар мэдээлэл өгөх тул эрдэмтэн, судлаач, оюутнууд ашиглах боломжтой.*



070

**НҮБ Ази Номхон Далайн Эдийн Засаг-Нийгмийн Зөвлөл (UNESCAP). (2004). Poverty Reduction Strategies: Tackling the Multidimensional Nature of Poverty (Ядуурлыг бууруулах стратегиуд: Ядуурлын мөн чанарын олон хэмжээст байдлыг шийдвэрлэх нь). Economic and Social Survey of Asia and the Pacific 2004 (Ази, Номхон Далайн Эдийн засаг ба Нийгмийн Судалгаа 2004), (х 241-293). [http://www.unescap.org/pdd/publications/survey2004/Survey04\\_11.pdf](http://www.unescap.org/pdd/publications/survey2004/Survey04_11.pdf)**

Өгцүлэг, 54 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлын олон хэмжээс, Ядуурлыг бууруулах стратегиуд (ЯБС)-г үнэлэх шалгуурууд

*JEL:* I32, I38

Уг ажил нь ядуурлын мөн чанарыг хэмжих хэмжилтүүдээс хамгийн гол 4 хэмжээсийн арга, аргачлалыг (орлогын, чадавхийн, нийгмээс гадуурхагдаж байгаа байдлын, оролцооны) танилцуулан, Ази Номхон Далайн Бүсийн орнуудын (Монгол Улс хамрагддаг) хувьд эдгээр 4 хэмжээсийг ашиглаж байгаа хандлагыг шалгаж, үр дүнг илтгэсэн байна. Дараа нь эдгээр орнуудын Ядуурлыг Бууруулах Завсрын эсвэл Бүрэн Стратегиуд, үндэсний хөгжлийн төлөвлөгөөнүүдийг нь тусгай шалгууруудаар шинжлэн ЯБС-ийн ерөнхий хэлбэр, үр ашигтай бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах туршлага, нийтлэг сургамжийг олж танилцуулан, энэ чиглэлээр цаашид анхаарах санал, зөвлөмжийг боловсруулсан байна. Монгол Улсын хувьд дээрх хэмжээсүүдийн болон ЯБС-ын шинжилгээний үр дүнг тусад нь гаргах боломжтой гэж дүгнээд, цаашид ядуурлыг хэмжихэд шинэ ямар арга хэрэглэх, ЯБС-ийг боловсруулах, хэрэгжүүлэхэд юу анхаарах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахад нэг бүс нутгийн орнуудад тохиолдож буй нийтлэг туршлага, сургамжуудыг танилцуулсан байна.

*Уг ажил нь ядуурлын мөн чанарыг онол, практикийн өндөр түвшинд авч үзэж, ядуурлын мөн чанарыг хэмжих сүцлийн цөийн арга аргачлал, бүс нутгийн орнууд болон манай орны хувьд тэдгээрийг хэрэглэн гарсан үр дүнг танилцуулснаараа олон талын мэдээлэл өгөх ач холбогдолтой ажил юм. Энэ бүтээлээс өөрийн орны ЯБС-ийн онцлог, давуу болон сул талууд, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, цаашид анхаарах асуудал, туршлага, сургамжуудыг олж мэдэх боломжтойгоороо оюутан, эрдэмтэн судлаачдын ядуурлын асуудлаарх цаашдын судалгаанд өндөр ач холбогдолтой юм.*

## 071

**НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP). (1994). Poverty and the Transition to a Market economy in Mongolia (Монгол Улсын зах зээлийн эдийн засаг дахь шилжилт ба ядуурал). Монгол, Улаанбаатар.**

Судалгааны тайлан, 129 хуудас, англи

*Түлхүүр үгс:* ядуурал,

*JEL:* I32

Уг тайланг, Монгол Улсын засгийн газраас тавьсан хүсэлтийн дагуу НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр 1994 онд Монгол Улс дахь ядуурлын талаар судалгаа явуулж, Монгол Улсын засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулахад туслалцаа үзүүлэх зорилгоор эмхэтгэн гаргасан байна. Уг тайланд Монгол Улсын эдийн засгийн шилжилтийн байдлыг судалж, ядуурлын түвшинг тогтоох түүвэр судалгааны аргачлал, явцын талаар зөвлөлгөө өгч, ядуурлыг ажил эрхлэлт, хүмүүн капиталын талаас авч үзэж, орлогын ядуурлаас гадна чадавхийн ядуурал байдгийг тэмдэглэжээ. Судалгаанд Монголын эмэгтэйчүүдийн байдал, орон нутгийн хөгжлийн байдлыг хамруулж, ядуурлыг бууруулахад засгийн газрын бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах бодлогын үндэсний чадавхийг бэхжүүлэх, олон улсын тусламжийг ашиглах боломжийн талаар зөвлөмж өгсөн байна.

*Уг тайлангийн онцлог нь ядуурлыг хүмүүн капитал, боловсрол, жендер, хөдөө аж ахуйн талаас түлхүү анхаарч, газар тариаланг хөгжүүлэх зөвлөлгөө өгч, гадаадын болон хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхийг зөвлөж, ядуурлыг бууруулахад үндэсний хэмжээний зохицуулалт шаардлагатайг онцлон тэмдэглэсэн байсан. Энэхүү ажил ядуурлыг бууруулах бодлого, нийгэм эдийн засгийн хөгжлийг сонирхон судалдаг эрдэмтэн, судлаач нар ашиглахад тохиромжтой.*

## 072

**НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP). (2000). Overcoming human poverty: Poverty Report 2000, (Хүний ядуурлыг шийдвэрлэж байгаа нь: ядуурлын илтгэл 2000).**

<http://www.undp.org/...>

Илтгэл, 140 хуудас, англи

*Түлхүүр үгс:* ядуурал, ядуурлын асуудлууд, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг

*JEL:* I30, I38

Уг илтгэлд өгүүлснээр 1995 онд болсон Нийгмийн Хөгжлийн төлөөх Дэлхийн Чуулган (1995 World Summit for Social Development) дээр ХБО-ууд ядуурлыг бууруулах, арилгахад өөрт тохиолдож буй бодит бэрхшээл хүндрэлүүдийг гаргаж тавьснаар ядуурлын эсрэг дэлхий нийтийн хамтын хүчин чармайлтыг улам нэмэгдүүлэх болон ядууралд түлхүү анхаарсан, үр ашигтай стратегийг шаардах болсон байна. НҮБХХ нь тухайн улс орнуудын үндэсний бодлого боловсруулах үйл ажиллагааг сайжруулах, засаглалын бүтцийг шинэчлэх, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг тусламж үзүүлэх үүрэгтэй байдаг. Энэхүү илтгэл нь олон үндэстнүүдийн ядуурлын хөтөлбөрүүдийг үнэлэхэд чиглэгдсэн ямар улсын аль хөтөлбөр нь

амжилттай, аль нь амжилтгүй байгааг олж тогтоон хамгийн сайн бодлогын туршлагыг тодруулж өгсөн бүтцийн хувьд 11 бүлэг, хэсгээс бүрдсэн бүтээл юм. Энэ илтгэлийн үнэлгээнд манай улс, бусад улсууд нийт 23 орны ядуурлын хөтөлбөрийг харьцуулан үнэлж, дүгнэж бичсэн. Манай улсын ядуурлын талаар Үндэстнүүдийн ядуурлын эсрэг төлөвлөгөөг хөгжүүлж байгаа нь гэсэн 2-р бүлэг, Ядуурлыг үндэсний бодлогуудтай холбох нь гэсэн 3-р бүлэг, Түлхүүр асуудлуудыг (жендэр ба хүрээлэн буй орчны бодлогууд, эрүүл мэндийн санаачлага) ядуурлын хөтөлбөртэй хослуулж байгаа нь гэсэн 9-р бүлэг, Улсуудын дүр төрх (Country Profile) хэсэгт Ядуурлыг бууруулах сангаар нөөцүүдийг хуваарилж байгаа нь гэсэн агуулгаар тодруулж бичжээ.

*Энэхүү ядуурлын илтгэлийн үнэлгээ, харьцуулалтад Монгол Улсын хөтөлбөр хамрагдснаар өөрийн орны ядуурлыг бууруулах хөтөлбөрийн давуу болон сул талууд, онцлог байдал, ашигласан статистик тоон мэдээлэл, цаашид анхаарах зүйл зэргийг олж авах боломжтой, энэ утгаараа ихээхэн ач холбогдолтой юм. Энэхүү илтгэл нь олон нийтэд зориулагдсан учир ядуурлын асуудлаарх сүцлийн цөийн үзэл, хандлага, түүнийг бууруулах цр ашигтай, хамгийн сайн бодлого, арга хэрэгслүүдийн талаар сонирхсон хүн бүр ашиглах боломжтой юм.*

## 073

**НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр. (2003). Малжуулалтаар малчин өрхүүдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг баталгаажуулах стратегийн үр дүнг үнэлэх нь. НҮБХХ/ШОУХА “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” МОН/01/Ю01 төсөл, Монгол, Улаанбаатар**

*Тайлан, 82 хуудас, монгол*

*Түлхүүр цгс:* Малжуулах нь  
*JEL:* Q19

Уг тайланд, манай орны нутаг дэвсгэрийг хамарсан ган, зудын гамшгийн улмаас малчин өрхийн амьжиргааны гол хэрэгсэл болох мал сүрэг ихээр хорогдож ядуу өрхүүдийн тоо нэмэгдэж байгааг судалгаагаар харуулж, ядуурлыг бууруулахад малжуулах үйл ажиллагааг ашиглахын давуу болон сул талыг тодорхой харуулжээ. Түүнчлэн малжуулах явцад гарч байгаа алдаа дутагдлыг тодорхой заагаад түүнийг дахин давтахгүй байх үүднээс алдаа гарах болсон шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийг судалгаандаа тусгасан байна. Малчин өрхүүдийг малжуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг судалснаар цаашид тэдний амьдралыг дээшлүүлэх арга зам, малжуулах арга хэлбэрийн талаар зөвлөмж гаргажээ.

*Ядуу өрхүүдийг малжуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цр дүнг нэгтгэн дүгнэсэн нь цаашид энэхүү үйл ажиллагааг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой баримт бичиг болжээ. Ялангуяа ган, зудад нэрвэгдсэн аймгуудад малжуулах үйл ажиллагааг цргэлжлүүлэн явуулахад анхаарах сургамж зөвлөмжүүдийг тусгасан нь амьдралд хэрэгжих боломжтой, цаг үеэ олсон чухал ажил болсон байна. Энэхүү тайланг малжуулах төсөл хэрэгжүүлж байгаа аймаг орон нутгийн удирдлагууд судалж танилцуваас дэлгэрэнгүй мэдээлэл олж авах болно.*

## 074

**НҮБ-ын Хүн Амын Сан. (2002). Дэлхийн хүн амын байдал 2002 онд: Хүн ам ба ядуурал. Монгол, Улаанбаатар.**

*Илтгэл, 88 хуудас, монгол*

*Түлхүүр цгс:* ядуурал, ядуурлын хэв шинж, ядуурлыг хэмжих, ядуурлын шалтгааны сүлжээ, *JEL:* I30, J10, I32

Илтгэлд өгүүлснээр хүний эрхийг хангах, хөгжлийн үйл явцыг түргэтгэх, улс хоорондын болон тухайн орны тэгш бус байдлыг багасгах зорилгоор ядуурлыг бууруулах нь дэлхий дахины өмнө тавигдаж буй тулгамдсан асуудал бөгөөд дэлхийн улс гүрний удирдагчид Мянганы Хөгжлийн Зорилт зэрэг шинэ санаачлагууд дээр зөвшилцөж байна. Дэлхийн Хүн Амын энэхүү илтгэл нь ядуурлын асуудлаарх хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулж, цаашид авах арга хэмжээнд анхаарал хандуулах зорилготой, ядууралтай холбогдсон бусад чухал асуудлуудыг авч үзсэн байна. Тухайлбал, ядуурлын хэв шинж, макро эдийн засаг, ядуурал, хүн ам ба хөгжил, эмэгтэйчүүд ба хүйсийн тэгш бус байдал, эрүүл мэнд ба ядуурал, ХДХВ/ДОХ ба ядуурал, боловсрол ба ядуурал зэрэг олон асуудлуудыг авч үзжээ.

*Ядууралтай холбоотой бүхий л асуудлуудыг авч үзэж, дэлхий нийтийн өмнө тулгамдаад буй асуудлыг тодорхойлон гаргаж, 2015 он гэхэд ядуучуудын тоог хоёр дахин бууруулахын тулд юу хийх шаардлагатайг тодорхойлсноор бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, эрдэмтэн судлаачдад өргөн хүрээтэй мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой илтгэл болжээ.*

## 075

**Нэргүй, Д (Nergui, D). (2000). The World Bank and International Monetary Fund Joint Workshop on Poverty Reduction Strategies in Mongolia: Poverty Reduction Strategies Paper Development (“Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийн хөгжил” сэдэвт Монголын ядуурлыг бууруулах стратегийн асуудлаарх Дэлхийн Банк, Олон Улсын Валютын сангийн хамтарсан зөвлөгөөн). Монгол, Улаанбаатар.**

<http://www.worldbank.org/poverty/strategies/events/mongolia/workgrp.pdf>

*Товхимол, 26 хуудас, англи*

*Түлхүүр цгс:* ядуурал, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг  
*JEL:* I30, I38

Уг товхимол нь Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан хамтран “Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг (ЯБСББ)-ийн Хөгжил” сэдвээр Улаанбаатар хотод зохион байгуулсан зөвлөгөөний материалд тулгуурлан бэлтгэгдсэн. Уг зөвлөгөөнөөр манай улсын ядуурлын дүр төрх, ядуурлыг бууруулах стратегийг боловсрол, эрүүл мэнд, хувийн сектор ба дэд бүтэц, ядуурлын тоон өгөгдөл, түүний хэмжилт, макро эдийн засгийн бодлогын асуудлууд, улсын төсвийн зарцуулалт гэсэн дэд сэдвүүдээр авч хэлэлцэн, шийдвэрлэх асуудлууд, хэрэгжүүлэх арга хэрэгсэл, илэрхийлэх үзүүлэлт, хариуцах төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын үүргийг тодруулан завсрын баримт бичгийг бүрэн болгоход цаашид хийх

алхмуудыг тодорхойлжээ. Эцэст нь зөвлөгөөний ажлын хэсгүүдээс санал болгосон ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийн хэрэгжилт, түүнийг хэрэгжүүлэх шинэлэг арга замууд, үр дүн, цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа зэргийг оруулсан байна.

*Уг товхимолд, манайд хамгийн идэвхтэй цйл ажиллагаа явуулдаг олон улсын томоохон хоёр байгууллагаас хамтран зохион байгуулж, манай улсын ядуурал, түүнийг бууруулах стратегийн баримт бичгийг авч хэлэлцсэн томоохон зөвлөгөөний үр дүнг танилцуулснаараа ач холбогдолтой юм. Ядуурлыг бууруулах стратегитай холбоотой дэд сэдвүүдийн зөвлөгөөний үр дүнтэй нарийвчлан танилцаж, эрдэмтэн судлаачид өөрийн судалгаандаа баримт мэдээллийн журмаар ашиглах боломжтой юм.*

## 076

**Одгэрэл, Х. (1996). Монгол дахь ажилгүйдлийн төлөв байдал, хандлага. Монголын хүн ам зүйн сэтгүүл, эмхэтгэл 1, (21, х 124-133). Монгол, Улаанбаатар.**

*Өгцлэл, 10 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Ажилгүйдэл, ажилгүйдлийн түвшин

*JEL:* E24

Уг ажил нь монголын ажилгүйдлийн төлөв байдлын судалгаанд зориулагдсан, “Ажилгүйдлийг бууруулах шаардлага” гэсэн хэсэгт ядуурал ба ажилгүйдлийн харилцан хамаарлыг авч үзжээ. Статистик тоон мэдээллийг дурдах, харьцуулах замаар ашиглан дараах дүгнэлтүүдийг гаргажээ. ...Олон ам бүлтэй, орлого багатай өрхийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, тахир дутуу, хагас болон бүтэн өнчин хүүхэд, залуучууд, харах хүнгүй өндөр настан, ажилгүйчүүд ядууралд илүү өртөж байна. Нийт ядуу өрхийн 25.3% нь 16-аас доош насны 4-өөс дээш хүүхэдтэй, 31.9% нь ажил эрхэлдэг хүнгүй, 22.8% нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байна. Хот газар үйлдвэрлэлийн уналт, ажилгүйдэл өссөнөөс болж хөдөлмөрийн хөлснөөс өөр орлогын эх үүсвэргүй иргэд ядууралд нэрвэгдэж байхад, хөдөө орон нутагт дэд бүтэц, зах зээл хөгжөөгүй, уламжлалт МАА-н ашиг шим бага зэргээс малгүй болон цөөн малтай иргэд ядууралд илүү өртөж байна... гэж дүгнэжээ.

*Энэ ажлын гол агуулга нь ажилгүйдэл учраас ядуурлын тухайд зөвхөн дээр дурдсан тоон мэдээлэл, дүгнэлтүүдийг л ашиглах боломжтой. Гэхдээ ажилгүйдэл, ядуурал гэсэн нийгмийн бие даасан хоёр, сөрөг үзэгдлүүд нь хоорондоо шууд хамааралтай болохыг тодорхойлж, ажилгүйдлийг багасгаснаар ядуурлыг бууруулж болохыг зааснаараа ач холбогдолтой юм. Цаашид энэ хамаарлыг тусад нь авч үзэн онол, практикийн тоон судалгаа хийж өргөжүүлэх нь эдийн засгийн онолын болон эдийн засгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой ажил болох юм.*

## 077

**Олон Улсын Валютын Сан ба Олон Улсын Хөгжлийн Нийгэмлэг (International Monetary Fund & International Development Association). (2001). Assessment of the interim poverty reduction strategy paper (Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийн үнэлгээ). [http://poverty.worldbank.org/files/Mongolia\\_JSA\\_of\\_PRSP.PDF](http://poverty.worldbank.org/files/Mongolia_JSA_of_PRSP.PDF)**

*Баримт бичиг, 15 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, эмзэг бүлэг, орлого хуваарилалт

*JEL:* I30, O15

Энэхүү тайлангийн зорилго нь Монгол Улсын Засгийн газрын ядуурлыг бууруулах гол стратегийг тусгасан Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт үнэлгээ өгөх явдал юм. Стратегийн завсрын баримт бичиг нь ядуурлыг бууруулах бүрэн хэмжээний стратегийн баримт бичиг боловсруулах үндэс суурийг тавьсан байна. Стратегийн завсрын баримт бичиг нь нийгмийн салбарын хяналтын үзүүлэлтүүдийг маш сайн тодорхойлон гаргасан. Нийгмийн салбарын дэд бүтцийг сайжруулахыг онцлон дурдсан ч одоогийн нөөцийн хуваарилалтанд оршиж байгаа үр ашиггүй байдлыг орхигдуулсан байна. Стратегийн завсрын баримт бичиг нь Ядуурлыг Бууруулах бүрэн хэмжээний Стратегийн баримт бичгийг боловсруулахад хангалттай суурь болж чадсан гэж дүгнэжээ.

*Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт хамтарсан баг үнэлэлт дүгнэлт өгснөөрөө дутагдалтай болон хангалтгүй боловсруулсан талыг анхаарч бүрэн хэмжээний баримт бичиг боловсруулахад тустай ажил болсон байна. Хөтөлбөр, баримт бичиг боловсруулагч, хэрэгжүүлэгч, санхүүжүүлэгч нар ашиглахад тохиромжтой юм.*

## 078

**Олон Улсын Валютын Сан ба Олон Улсын Хөгжлийн Нийгэмлэг (International Monetary Fund & International Development Association). (2003). Poverty reduction strategy paper: joint staff assessment (Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг: албан хаагчдын хамтарсан үнэлгээ). [http://poverty.worldbank.org/files/Mongolia\\_JSA\\_of\\_PRSP.PDF](http://poverty.worldbank.org/files/Mongolia_JSA_of_PRSP.PDF)**

*Тайлан, 20 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, эмзэг бүлэг, амьжиргааны түвшин

*JEL:* I30, I31

Уг тайлангийн зорилго нь ядуурлыг бууруулах стратегийн анхны баримт бичиг болох Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегид үнэлэлт өгөх явдал юм. Үнэлгээний хүрээнд стратегийн баримт бичгийг үйл ажиллагааны төрөл тус бүрээр ололттой болон дутагдалтай талыг нь тодорхойлон гаргасан. Тохиолдож болох эрсдэлүүдийг үнэлсэн. Стратегийн баримт бичиг нь боловсрол, эрүүл мэнд, хөдөөгийн хөгжил, эрчим хүч, төрийн удирдлага гэх мэт салбар тус бүрийн хувьд маш сайн боловсруулагдсан байна. Хувийн секторын хөгжил ба тээврийн салбаруудын стратегийг илүү сайн боловсруулах, сайжруулах шаардлагатай гэж дүгнэжээ.

*Стратегийн баримт бичигт хамтарсан баг үнэлэлт дүгнэлт өгснөөрөө дутагдалтай талыг анхаарч баримт бичгийг сайжруулах, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг*

боловсруулахад маш их тустай ажил болсон байна. Бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, санхүүжүүлэгч нар ашиглахад тохиромжтой юм.

## 079

**Онон, С. (1996). Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн стратеги.**

*Илтгэл, 10 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр

*JEL:* I30, I38

Илтгэлд дурьдснаар 1994 оны 6-р сард Монгол Улсын Засгийн газраас зургаан жилийн хугацаатай Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү хөтөлбөр нь Монгол дахь ядуурлыг 2000 он гэхэд бууруулах зорилготой. Хөтөлбөр нь Засгийн газрын ядуурлыг бууруулах бодлогод тусгагдаж, үндэсний үйлдвэрлэлийн чадавхийг сэргээн эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, ажлын байр бий болгох замаар бүтээмжтэй ажил эрхлэлтийг дэмжих, эрүүл мэнд, боловсролын өмнө хүрсэн түвшинг хадгалан тэдгээрийг цаашид ахиулах нөхцлийг бий болгох, эдийн засгийн шинэ тогтолцоонд тохирсон нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох, улс төр, эдийн засаг, нийгэмд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг гол зарчмуудын хүрээнд төвлөрдөг гэж үзжээ.

*Энэ илтгэл нь өнгөрсөн хоёр жилийн туршилага, цаашид анхаарах гол асуудлуудыг авч үзсэнээрээ бодлого боловсруулагч, судлаачдад чухал мэдээлэл болох юм.*

## 080

**Османи, С.Р (Osmani, S.R). (1997). The challenges of poverty alleviation in a sparsely-populated low-income transition economy: the case of Mongolia (Шилжилтийн эдийн засагтай бага орлоготой сийрэг суурьшсан орнуудад ядуурлыг бууруулахад тулгарч буй бэрхшээлүүд: Монголын жишээ).**

*Тайлан, 53 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал

*JEL:* I30

Энэхүү судалгаа нь Монгол Улс шиг шилжилтийн эдийн засагтай, бага орлоготой, хүн ам нь сийрэг суурьшсан оронд ядуурлын байдлыг тодорхойлж, үнэлгээ өгөх зорилготой юм. Энэ ажил нь макро эдийн засгийн орчин, шилжилтийн үеийн ядуурал, хүний хөгжил дэх нөлөөлөл, ядуурлыг бууруулах болон нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд, Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн зарцуулалт зэрэг асуудлуудыг дэлгэрэнгүй авч үзжээ.

*Шилжилтийн эдийн засагтай буурай орны ядуурлыг бууруулах асуудлыг Монгол Улсын жишээн дээр авч үзсэнээрээ судлаач, бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдэд чухал мэдээлэлцүдийг өгөх болно.*

081

**Отгонтуяа, Д. “Mongolia”. (Монгол Улс).**<http://www.ipcte2004.org/download/papers/country-papers-series-mongolia.pdf>

Өгцүлэл, 33 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлыг бууруулах бодлого, макро эдийн засаг*JEL:* I30, I38, J68

Уг өгүүлэл нь Монгол Улсын эдийн засгийн байдлыг гадаад, дотоод орчин болон засгийн газрын төсвийн байдалд тулгуурлан дэлгэрэнгүй авч үзжээ. Гадаад орчинг авч үзэхдээ Монгол Улсын гадаад худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтын тоон үзүүлэлтүүдийг ашиглан тайлбарласан байна. Мөн гадаадын зээл тусламжуудыг авч үзэж, ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөр, стратегиудыг дурьдсан байна. Дотоод орчныг эдийн засгийн өсөлт, инфляци, хөрөнгө оруулалт, мөнгө ба зээл гэсэн байдлаар авч үзжээ. Төсвийн орлого, зардал, өр ялангуяа төсвийн орлогыг бүтэц бүрэлдэхүүн нэг бүрээр нь маш дэлгэрэнгүй тайлбарласан байна. Эцэст нь Монгол Улс түүхий эдийн экспортод түшиглэсэн нь үнийн хэт хэлбэлзлээс болоод макро эдийн засгийн тогтвортой байдлаа хадгалахад төвөгтэй нөхцлийг бий болгож байна. Засгийн газрын өмнө тулгарч байгаа хүндрэл бэрхшээл нь санхүүгийн сектор болон төсвийн баланс юм. Үүнийг шийдэхгүйгээр хувийн секторийн хөгжил, уг секторт ажил эрхлэлтийг бий болгоход хүндрэлтэй байх болно. 1991 онд ядуурлын түвшин 15 хувь байсан бөгөөд 1996 онд 36 хувь болж, харин 1996 оноос хойш харьцангуй тогтвортой байна. Ядуурал гүнзгийрч байгаа нь өнөөгийн хөгжлийн үйл явц ажил эрхлэлт, орлогыг бий болгоход хүрэлцэхүйц боломжийг бүрдүүлж чадахгүй байна гэж үзжээ. Засгийн газраас ядуурал их байгаа хөдөө орон нутагт ажлын байрыг бий болгох, ажлын шинэ байрыг бий болгохын тулд хувийн секторыг дэмжих, туйлын ядуу хүмүүсийн нийгмийн хамгааллын сүлжээг сайжруулах, ядуурлын шинэ хэлбэрүүдээс зайлсхийхийн тулд нийгмийн шаардлагатай үйлчилгээг хангахад туслах хэрэгтэй гэж дүгнэжээ.

*Энэ өгцүллэгээс Монголын эдийн засгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой. Ядуурлыг бууруулахад чиглэгдсэн нэлээд сайн зөвлөмжийг гаргаснаараа ач холбогдолтой болжээ. Монголын эдийн засгийг сонирхож буй бүх хүмүүс ашиглах боломжтой.*

082

**Оюун, С (Oyoon, S). (2003). From the Year of the White Horse to the Year of the Black Horse: Mongolia After Twelve Years of Transition (Цагаан морин жилээс хар морин жилд: Монгол Улс 12 жилийн шилжилтийн дараа).**[http://www.iias.nl/iiasn/31/IIASN31\\_01.pdf](http://www.iias.nl/iiasn/31/IIASN31_01.pdf)

Илтгэл, 2 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Эдийн засгийн шилжилт, ядуурал*JEL:* P20, I30

Энэхүү илтгэлд Монгол Улсын шилжилтийн үйл явцад бий болсон өөрчлөлтүүд, хүрсэн түвшин, үр дүнд дүн шинжилгээ хийжээ. Шилжилтийн үед ядуурал өсөж, орлого хуваарилалт



улам бүр тэгш бус болж байгааг дурьдаад Засгийн газар энэ чиглэлд түлхүү анхаарах шаардлагатай гэж үзсэн байна.

*Энэхүү илтгэл нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлыг товч тодорхой дүгнэжээ. Түгнчлэн худалдааны бодлогын талаар өвөрмөц, сонирхолтой дүгнэлт хийсэн байна.*

### 083

**Оюунжаргал, Ц., Нямаа, Т. (2002). Монгол дахь бичил санхүүгийн дэд салбарын судалгаа. Монгол, Улаанбаатар: “Батхийморь” хэвлэлийн газар**

*Судалгааны тайлан, 135 хуудас, монгол*

**Oyunjargal, Ts., Nyamaa, T. (2002). Sub-sector review of micro-finance in Mongolia.**

**<http://www.uncdf.org/english/microfinance/reports/technical/mongolia-sumreview.pdf>**

*Тайлан, 71 хуудас, англи*

*Түлхүүцр цгс:* Ядуурал, бага орлоготой өрхүүд, хөрөнгийн хуримтлал, орлогын ядуурал, эмзэг хэсэг

*JEL:* I30, O15, D31

Уг тайлангийн зорилго нь Монгол дахь жижиг зээлийн хөгжил, цаашдын чиг хандлага ба боломжуудыг тодорхойлох юм. Энэхүү ажлын хүрээнд жижиг зээл нь санхүүгийн улсын секторын дэд хэсэг хэмээн ойлгогдоно. Жижиг зээл нь ядуурлыг арилгах, хөрөнгө хуримтлуулах, орлогын эх үүсвэр бий болгоход маш чухал арга хэрэгсэл болох нь батлагджээ. Жижиг зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлан, жижиг зээлээс үр ашиг хүртэгчдийг тодорхойлсон, төр, хандивлагчдаас хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт, үйл ажиллагааг авч үзсэн. Жижиг зээлийн үр шимийг хүртэгчид нь ихэвчлэн ядуу болон хөдөөгийн өрхүүд байна гэж дүгнэжээ.

*Бичил санхүүгийн талаар бүрэн хэмжээний мэдээлэл авах боломжтой. Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэгчид, төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүдэд зориулсан байна.*

### 084

**Оюунчимэг, М. (1999). Poverty. (Ядуурал)**

**[http://www.unescap.org/stat/meet/povstat/pov7\\_mog.pdf](http://www.unescap.org/stat/meet/povstat/pov7_mog.pdf)**

*Илтгэл, 3 хуудас, англи*

*Түлхүүцр цгс:* Ядуурал, ядуурлыг хэмжих нь

*JEL:* I30, I32

Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зорилго, засгийн газрын бодлого, стратегийг тодорхойлж, ядуурлын тоо баримтуудыг дурьдсан байна. Ядуу, нэн ядуу хүмүүсийг тодорхойлохдоо ҮСГ-аас гаргасан ядуурлын шугамаас гадна өөрийн хөрөнгөтэй эсэх, түүгээрээ орлого олдог эсэх, ажиллах чадвар, ажиллах хүсэл сонирхол, хүрэлцэхүйц орлоготой халамжлагч байгаа эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үзэх шаардлагатай гэсэн байна. Монголд ядуурлын

шугамыг тогтоох ялгаатай хоёр хандлага байдаг гэдгийг ч дурьджээ.

*Ядуурлыг тодорхойлоход нэмэлт байдлаар хэрэглэж байгаа үзэцлэлтүүд нь цаашид ядуурлын шугам болон ядуучуудыг тодорхойлоход чухал ач холбогдолтой үзэцлэлт болж чаджээ.*

## 085

**Өлзийбат, Н. (2002). Хүн ам ба ядуурал. Монголын хүн амын сэтгүүл, ? 7, х 11-15**

*Нийтлэл, 4 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, орлогын ядуурал, ядуурлын хэмжилт, ядуурлын төрөл, ядуурлын хэв шинж

*JEL:* I30, J10

Энэхүү нийтлэл нь “Хүн ам ба Ядуурал” сэдвээр хэвлэгдэн гарсан Дэлхийн Хүн Амын Илтгэлийг олон нийтэд түгээхэд зориулан бэлтгэгджээ. Аливаа улс орны тогтвортой хөгжлийн нэг үндсэн баталгаа бол хүн амын амьжиргааны түвшингийн эрс ялгаатай байдлыг багасгах, ядуурлыг бууруулах явдал гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Хүн амын асуудлаархи дэлхийн Дээд хэмжээний чуулга уулзалт, бага хурлын зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор Дэлхийн хүн амын өдрийг 2002 онд “Ядуурал, хүн ам ба хөгжил” уриан дор зарлаж, ядуурлыг бууруулах асуудалд хүн төрөлхтний анхаарлыг хандуулж байна.

*Эндээс та бүхэн дэлхий дахинаа ядуурлын асуудал хэрхэн тавигдаж, нийгэм, хүн амын дунд ямар цр дагавар үзэцлж байгаа талаарх илтгэлд дурьдагдсан судалгааны цр дүнгүүдтэй танилцахын зэрэгцээ ядуурлын төрөл, хэв шинжүүд, ядууралд нөлөөлж буй зарим хүчин зүйл, ядуурлын шалтгааны сүлжээ, ядуурлыг хэмжих аргын талаар тодорхой мэдээллийг авах болно. Энд ядуурал, ядуурлын нэг үндсэн төрөл болох орлогын ядуурлын тухай тайлбарласан байна. Мөн ядуурлын хэв шинжүүд, ядууралд нөлөөлж буй хүчин зүйлс, ядуурлын шалтгааны сүлжээг авч үзжээ.*

## 086

**Риллера, Г.Е (Rillera,G.E). (2001). ADB and Northeast Asia (АХБ ба Зүүн Хойд Ази). (x2-3). <http://www.forum-adb.org/unsorted/subic01-rpt.pdf>**

*Илтгэл, 2 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, шилжилтийн эдийн засаг

*JEL:* I30, P20

1999 онд АХБ ядуурлыг бууруулах үйл ажиллагаа, сайн засаглалын элементүүдийг бий болгоход зориулсан үйл ажиллагааны шинэ стратегийг гаргасан. Энэ стратегийг 2000 онд 2000-2004 оны хугацаанд хэрэгжүүлэхээр тогтсон. Энэ нь стратегийн хувьд сонгон авсан таван салбарт чиглэгдэж байгаа. Үүнд, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд санхүүгийн сектор, хөдөө аж ахуйн сектор, улсын сектор, нийгмийн сектор болон ядууралд

чиглэсэн хотын хөгжлийн асуудлыг хамрах болно.

*Судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан. АХБ-аас хэрэгжүүлэх байгаа цйл ажиллагааны чиглэлийг танилцуулсан.*

**087**

**Пүрэвсүрэн, С., (2001). Монголын эдийн засаг ба хөдөө аж ахуйн өнөөгийн нөхцөл байдал. <http://www.fadinap.org/ipns/workshop2001/Mongolia.PDF>**

*Судалгааны тайлан, 11 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* хөдөө аж ахуй, эдийн засгийн хөгжил

*JEL:* Q10, O10, O53

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсын эдийн засаг, хөдөө аж ахуйн өнөөгийн нөхцөл байдлыг авч үзэн, дүн шинжилгээ хийх зорилготой. Шилжилтийн үеийн эдийн засгийн байдал, хот хөдөөгийн шилжилт, малчдын ахуй амьдрал зэрэг асуудлуудыг судалжээ. Судлаачийн үзэж байгаагаар шилжилт нь дундаж орлогын түвшинг бууруулаад зогсохгүй орлогын хэт хэлбэлзлийг бий болгосон. Ялангуяа малчдын эдийн засгийн аюулгүй байдал алдагдсан нь 1999-2000 оны зуднаар тод харагдсан гэжээ. Энэ зуднаар 2.4 сая мал үрэгдэж, 2400 малчид малгүй болсон нь хөдөөнөөс хот руу нүүх шилжилтийн шалтгаан болсныг дурьджээ.

*Уг судалгааны тайланг Монгол Улсын эдийн засаг, хөдөө аж ахуйг сонирхон судалж буй эрдэмтэн, судлаач, бодлого боловсруулагч, олон нийт ашиглах боломжтой. Тайлан нь статистикийн тоо баримтыг харьцуулан дүгнэлт хийх хэлбэрээр бичигдсэн байна.*

**088**

**Стейдл, М. (Micheal Steidl)., Ломбарди, Ж. (Jacopo Lombardi). (2003). UNDP Mongolia, Poverty Research and Employment Facilitation Project MON/01/U01, Training Voucher Program Assessment of the Transition Phase and Recommendations to the Central Employment Office (Монгол дахь НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, Ядуурлын судалгаа ба ажил эрхлэлтийг дэмжих төсөл MON/01/U01, Сургалтын эрхийн бичгийн хөтөлбөрийн шилжилтийн үеийн үнэлгээ ба хөдөлмөр эрхлэлтийн төв албанд өгөх санал, зөвлөмж). Монгол, Улаанбаатар. <http://www.un-mongolia.mn/reports/files/Transition%20Phase%20Assessment%20Report%20Oct.%202003.pdf>**

*Тайлан, 40 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ажил эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, нийгмийн асуудал

*JEL:* I32, J21

2002 онд Монгол Улс дахь НҮБХХ-ийн газраас ажил эрхлэлтийг дэмжих шинэ арга хэрэгсэл болох ажилгүйчүүд, хувиараа болон албан ёсны ажил эрхэлж буй хүмүүст зориулсан сургалтын Эрхийн Бичгийн Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Уг үнэлгээний ажил нь хэрэгжиж дууссан туршилтын хугацааны үр дүнг үнэлэн, хөтөлбөрийн сул, дутагдал доголдолтой талуудыг тодорхойлон, цаашдын зорилгод санал зөвлөмжийг өгч, хавсралт хэсэгт сул, дутагдалтай талуудыг даван туулах зарим арга, хэрэгслийг танилцуулсан байна. Уг үнэлгээний дүнгээс ядуурлын

асуудалтай холбоотой хэд хэдэн үр дагавар гарсан байна. Жишээ нь, уг хөтөлбөрт хамрагдагсдын 81% нь эрхийн бичиг нь ядуурлыг бууруулахад тохиромжтой арга юм гэж үзсэн байна.

*Уг судалгааны ажлаас төслийн зорилго, ажил эрхлэлтийг дэмжсэн бодлого нь нийгмийн бусад асуудлууд, тухайлбал ядуурлын асуудлуудтай хэрхэн холбогдож, зэрэг, сөрөг ямар үр нөлөө үзүүлснийг үнэлсэн үр дүнгүүдээс олж авах боломжтой. Мөн хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх орчин үеийн шинэлэг арга аргачлалтай танилцах боломжтойгоороо ач холбогдолтой юм.*

## 089

**Сувд,Б. Алтанцэцэг,Б. Отгонтөгс,Б. Цэвэлмаа,Х. Лхагвасүрэн,Б. Баярмаа,Д. Оюунбаатар,Т. Дөлбадрах,С. Соёлмаа,Б. Доосмаа,Н. (2003). Assessment household vulnerability to poverty in Mongolia (Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлын үнэлгээ). Монгол. Улаанбаатар.**

*Судалгааны тайлан, 23 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурах эмзэг байдал, ядуурал, орлого хуваарилалт, ядуурлын шугам  
*JEL:* 015, I32

Уг судалгааны ажлын зорилго нь Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлыг тодорхойлох явдал юм. Үнэ чөлөөлснөөр инфляци нь орлогын өсөлтөөс илүү өссөн, ажилгүйдэл нэмэгдсэн зэрэг нь Монголын ядуурлын нэг шалтгаан юм. Үүнээс гадна ядуурлын шалтгааныг хот, хөдөөгийн хувьд ялгаатай авч үзсэн. Судалгааны хүрээнд Архангай, Хэнтий, Дорноговь болон Улаанбаатар хотын айл өрхүүдээс асуулга, ярилцлагын аргаар судалгаа авч, уг өгөгдөл дээрээ задлан шинжилгээ хийж, ядуурах эмзэг байдал гэсэн ойлголтыг шинээр оруулж ирсэн. Ирээдүйн хэрэглээ нь ядуурлын шугамаас доогуур болох магадлалаар ядуурах эмзэг байдал тодорхойлогддог. Өрхүүдийн хэрэглээний эконометрик загвар үнэлэх замаар ядуурах эмзэг байдлыг үнэлж тооцсон. Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдалд өрхийн тэргүүний боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, хүйс, орон сууцны нөхцөл зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна. Судалгааны үр дүнд тулгуурлан бодлогын зөвлөмж боловсруулж, цаашдын судалгааны чиглэлийг тодорхойлсон байна.

*Энэхүү судалгааны тайлан нь судлаачид, бодлого боловсруулагчдад зориулагдсан, ядуурлын асуудлыг нэгэнт ядуу болсон хойно нь биш ядуурахаас өмнө анхаарах хэрэгтэй гэдгийг харуулсан шинэлэг ажил болсон байна. Энэ судалгаа нь ийм төрлийн судалгаа хийх хэрэгцээ шаардлага байгааг харуулснаараа чухал ач холбогдолтой юм.*

## 090

**Сувд, Б. Вальтерс, Б (Walters, B)., Никсон, Ф (Nixson, F). (1999). Монгол дахь ядуурал. Монголын эдийн засаг: Шилжилтийн эдийн засгийн гарын авлага (х 102-133). Монгол, Улаанбаатар: “Адмон” хэвлэлийн газар.**

*Номын бэлэг, 31 хуудас, монгол*

**Suvd, B. Nixson, F. & Walters, B. (2000). Poverty in Mongolia. The Mongolian economy: Manual of applied economics for a country in transition (х 189-205). Cheltenham, UK & Northampton, MA, USA: Edward Elgar Publishing.**

*Номын бэлэг, 16 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлын шугам, орлого хуваарилалт, амьжиргааны түвшин  
*JEL:* I30, I32, O15, I31

Уг ажлын зорилго нь Монгол дахь ядуурлын асуудлыг шалтгаан, үр дагавраар нь задлан шинжилж түүнийг бууруулах, арилгах үндсэн чиглэл, арга замыг тодорхойлсноор шилжилтийн эдийн засагтай орныг судлах гарын авлага гаргах юм. Ядуурлын хэлбэрүүдийг тодорхойлон гаргаж, хот, хөдөөгийн ядуурлыг харьцуулан дүн шинжилгээ хийсэн. Онолын үндсэн ойлголтуудыг өгч бодит тоо мэдээнд тулгуурлан санал дүгнэлт хийсэн байна. Ядуурлыг бууруулах, арилгах талаар төрөөс ямар бодлого баримтлан хэрэгжүүлж болох талаар зөвлөмж гаргасан.

*Бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, судлаачид болон өргөн олон ашиглах боломжтой. Монгол дахь ядуурлыг эдийн засгийн онол, тухайн үеийн тоо баримтад тулгуурлан тодорхой гаргаж ирсэн. Харьцуулсан шинжилгээнүүд их хийгдсэн ажил болсон байна.*

## 091

**Сувд, Б., Алтанцэцэг, Б (Suvd, B & Altantsetseg, B). (2001). Poverty situation of Mongolia (Монголын ядуурлын төлөв байдал). Эдийн засаг: онол, практик сэтгүүл (?3, х 13-27). Монгол, Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.**

*Өгцлэл, 13 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны түвшин, тэгш бус байдал  
*JEL:* I30, I31, O15

Уг ажлын зорилго нь Монгол дахь ядуурлын шалтгаануудыг хот, хөдөө дэх төлөв байдлаар нь авч үзэн судлах юм. 1995, 1998 онуудад хийгдсэн Амьжиргааны түвшний түүвэр судалгаа болон Хүний хөгжлийн илтгэлийг ашиглан ядуурлын шалтгаануудыг ангилсан. Орон байрны орчин, жендерийн асуудал, ажил эрхлэлт, боловсрол, эрүүл мэндийн асуудлуудыг судлан хот, хөдөөгийн ядууралд харьцуулсан шинжилгээ хийсэн. Монголын тоон өгөгдөл, баримтуудаас хотын ядуурал нь хөдөөгийнхөөс их байгааг гаргаж шалтгаануудыг тус бүрд нь нарийн тодорхой авч үзжээ. Монгол дахь ядуурал нь чадавхаас илүү орлогод үндэслэн бий болж байна гэж дүгнэсэн.

*Бодлого боловсруулагч, судлаачид, оюутнууд ашиглахад илүү тохиромжтой. Ядуурлын шалтгаануудыг задлан шинжилсэн, хот, хөдөөгийн ялгаатай байдлыг тод томруун харуулж*

чадсан дорвитой ажил болжээ. Онолын үндэслэлтэйгээр ядуурлын шалтгаануудыг тодорхойлон тоо баримтаар баталгаажуулсан байна.

## 092

**Сувд, Б. (2002). Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын орчин үеийн хандлага. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, шалгуур үзүүлэлтүүд: илтгэлүүдийн эмхэтгэл (х 2-14). Монгол, Улаанбаатар.**

*Өгцлэл, 12 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Орлогын хуваарилалт, ядуурал, эмзэг байдлын түвшин, ажилгүйдэл  
*JEL:* O15, I30, E24

Уг илтгэлийн зорилго нь дэлхий нийтээрээ даяаршиж буй өнөө үед жижиг, нээлттэй эдийн засагтай манай орны тухайд өөрийн орны онцлог байдлыг тусгасан эдийн засгийн аюулгүй байдлын тодорхойлолыг гаргаж, түүний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох юм. Эдийн засгийн аюулгүй байдлыг гадаад эдийн засгуудтай харилцан хамааралтайгаар орших чадвар, хүн амын сайн сайхан байдлыг тогтвортой хангах гэсэн хоёр агуулгын хүрээнд тодорхойлсон. Эдийн засгийн тогтолцооны тогтвортой, бие даасан байдлын шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж үүнд, инфляци, ажилгүйдэл, ядуурал, эмзэг байдлын түвшин, эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвар, санхүүгийн аюулгүй байдал зэрэг үзүүлэлтүүдийг багтаан оруулсан. Мөн хүн амын сайн сайхан байдлын шалгуур үзүүлэлтүүдэд хүний хөгжил, орлого хуваарилалтын асуудлыг авч үзсэн. Үзүүлэлт тус бүрийн хувьд аюулгүй байдалтай хэрхэн уялдаж холбогдохыг тодорхойлон гаргасан болно.

*Эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг олон улсын жишиг, Монгол Улсын онцлогийг харгалзан тодорхойлсон ажил болсон байна. Илтгэлүүдийн эмхэтгэлийг албан ажлын хэрэгцээнд зориулан гаргажээ. Эдийн засгийн үзүүлэлтүүдийг үндэсний аюулгүй байдалтай хэрхэн холбогдохыг тодорхойлон гаргаснаараа ач холбогдолтой болсон байна.*

## 093

**Туул, Ю. (1997). Ядуурал юунаас болж байна вэ?. Монголын хүн ам зүйн сэтгүүл, эмхэтгэл 2, (21, х 98-103).**

*Өгцлэл, 6 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Амьжиргааны түвшин, ядуурал, ядуу өрх, шилжилтийн эдийн засаг  
*JEL:* I31, I30, P20

Уг ажил нь 1995 онд Монгол Улсын Статистикийн Газар Дэлхийн Банктай хамтран гүйцэтгэсэн “Монголын ард түмний Амьжиргааны түвшин”-г тодорхойлох, түүвэр судалгааны үр дүнг ашиглан ядуурлын шалтгааныг тодорхойлох зорилготой бэлтгэгджээ. Уг ажил ерөнхийд нь нэгтгэн дүгнэсэн байдалтай дотроо тодорхой хэсгүүдэд хуваагдаагүй, статистикийн түүвэр судалгааны тархаах замаар гарсан үр дүнг ашиглан ядуурлын хамарч байгаа хүрээ, ядуурлын түвшин, үндсэн шалтгаан, үр дагавар, бууруулах арга замуудыг тодорхойлохдоо Монгол Улсын Засгийн Газраас өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настан, тэтгэврийн хүмүүсийг шилжилтийн бэрхшээлд хамгийн их

өртөж буй эмзэг хэсэг гэж тодорхойлсныг голлон анхаарчээ. Уг судалгаа ядуурлын төлөв байдлыг тодорхойлон түүнд нөлөөлөгч бодит шалтгаанууд, нөлөөлөгч бусад хүчин зүйлүүд тухайлбал, тооцож буй арга аргачлал, үнийн өсөлт зэргүүдийг тодорхойлж өгчээ.

*Энэ ажил нь оюутан, судлаач эрдэмтэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, бүх хүрээний бусад хүмүүс унших, ашиглахад тохиромжтой, статистик шинжилгээ, харьцуулсан судалгааны ажил юм. Цаашид өргөжүүлж, нарийвчилсан судалгаа хийж болох ач холбогдолтой хэд хэдэн санаа дэвшүүлсэн. Судлаачийн дэвшүүлсэн ядуурлын бодит шалтгаануудыг тус тусад нь илүү нарийвчлан судлаж түүний үр дагавар, нөлөөллийг тоон шинжилгээгээр үнэлж судалгааг өргөжүүлэх боломжтой юм.*

#### 094

**Туул, Ю. (2004). Хүн амын амьжиргааны түвшин ба ядуурлын статистик. МУИС-ЭЗС, Эдийн Засгийн Боловсрол Холбооны сэтгүүл “Эдийн Засаг: онол, практик”, (223 (11), х 77-83).**

*Өгцлэл, 7 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Амьжиргааны түвшин, хүний хөгжлийн индекс, амьжиргааны доод түвшин буюу ядуурлын шугам

*JEL:* I30, I31, I32, O15

Уг ажил нь дэлхий нийтэд хамгийн өргөн тархсан хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлдог ухаалаг, зохистой хэрэглээний хэмжээнд хүн амын тодорхой хэсэгт нэн шаардлагатай материаллаг болон үйлчилгээний хэрэглээг тооцох арга, аргачлалыг танилцуулсан. Хүн амын амьжиргааны түвшинг судлах хүрээ, манай улсын хувьд хэрэглэж буй хүн амын амьжиргааны түвшинг илэрхийлэх бүтцийн хувьд ялгаатай үзүүлэлтүүдийн системийг танилцуулж, эдгээр үндсэн үзүүлэлтүүдийн нэгдсэн системийн өнөөгийн байдлаар хүрээд байгаа нэг амжилт болох НҮБХХ-ийн мэргэжилтнүүдийн боловсруулсан Хүний Хөгжлийн Чадавхийн Индекс (ХХЧИ) буюу Хүний Хөгжлийн Индекс (ХХИ)-ийг хэрхэн тооцох аргачлалыг товчхон тайлбарлаж, танилцуулсан. Эцэст нь хүн амын амьжиргааны түвшний бас нэг гол үзүүлэлт бол хүн амын амьжиргааны доод түвшин буюу ядуурлын шугам юм гэж үзэн энэ шугамыг тооцдог арга аргачлал, нөлөөлөгч хүчин зүйлүүдийг тодорхойлон өөрийн орны хувьд хэрхэн тооцож байгаа, тооцож гаргасан үр дүнгүүдийг товчхон илтгэжээ.

*Энэ ажил нь хүн амын амьжиргааны болон ядуурлын шугам, ХХИ-ийн тооцоо, статистикийн арга, аргачлалыг мэдэх, судлах, шинжлэх зорилготой, тодорхой хэмжээний статистикийн онолын мэдлэгтэй оюутан, судлаач эрдэмтэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид унших, ашиглахад тохиромжтой, танин мэдэхүйн ач холбогдол бүхий өгцлэл юм. Бичигч тухайн арга аргачлалд дүн шинжилгээ хийсэн, дутагдалтай болон онцлог, анхаарах талыг нь дурдсан, ОХУ-ын байдалтай харьцуулалт хийсэн, дэлхийн бусад орны статистик мэдээг өгснөөрөө уг ажлыг илүү ач холбогдолтой болгосон байна.*

**095**

**Улаан, Ч. (2003). Mongolia (Монгол Улс).**

[www.adb.org/AnnualMeeting/2002/Speeches/MON.pdf](http://www.adb.org/AnnualMeeting/2002/Speeches/MON.pdf)

*Илтгэл, 2 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлыг бууруулах бодлого

*JEL:* I30

Азийн хөгжлийн банк 1999 онд ядуурлыг бууруулах стратегийн зорилтуудыг тодорхойлж Монгол Улсын засгийн газар тэдгээр зорилтуудыг дэмжиж, энэ стратегийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Ядуурлын асуудлууд зөвхөн Монголын хувьд ч бус ази номхон далайн бусад орнуудын хувьд ч бас анхаарал татсан хэвээр байна. Хамгийн маргаантай асуудал бол ядуурал XXI зуунд нэн чухал шийдвэрлэх асуудал хэвээр үлдэх эсэх юм. АХБ-ний гишүүн орнууд ядуурлыг бууруулах зорилго, зорилтоо нэгтгэж, Дэлхийн банк, ОУВС, НҮБХХ, олон улсын бусад байгууллагууд болон улс орнуудтай хамтран ажиллавал илүү үр ашигтай байх болно. Бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд, АХБ-ны дэмжлэгтэйгээр бүс нутгийн түвшинд ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах үйл ажиллагаанд Монгол Улс идэвхитэй оролцох бодлого баримталж байгааг харуулжээ.

*Энэ илтгэл нь Олон улсын байгууллагуудын явуулж буй ядуурлыг бууруулах цйл ажиллагаанд Монгол Улсын баримталж байгаа бодлогыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ач холбогдолтой.*

**096**

**Үндэсний Статистикийн Газар. (2000). Цаг ашиглалтын туршилтын судалгаа 2000.**

**МОН(97)201. Монгол, Улаанбаатар.**

*Тайлан, 65 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* албан бус сектор

*JEL:* O17

Энэхүү тайланд Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлснээр урьд өмнө манайд тооцож байгаагүй шинэ үзүүлэлтүүдийг олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу, өөрийн орны өвөрмөц онцлогийг тусган тооцох шаардлагатай болсныг харуулжээ. Үндэсний статистикийн газраас албан бус сектор дахь ажил эрхлэлтийн түвшин, эмэгтэйчүүд өрх, гэрийн амьдралд болон эдийн засагт оруулж буй хувь нэмрийг үнэлж тооцох зорилгоор 2000 оны 4-р сард цаг ашиглалтын туршилтын судалгааг явуулжээ. Энэ судалгааны үр дүн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад үнэтэй мэдээллийн шинэ эх сурвалжыг нээн өгч, албан ёсны статистикийн хүрээнд хийгдэн судалгааны тоо баримтад тулгуурлан бодлогын зарим зөвлөмжүүдийг өгсөн байна. Гэхдээ энэ ажил нь ажиллах хүчний ерөнхий дүр зураг, динамик өөрчлөлт, хөдөлгөөнийг харуулах боловч бодлого боловсруулахад хангалттай бус гэдгийг дурьдсан байна. Цаг ашиглалтын судалгаагаар гарсан баримт мэдээлэл нь НХХЯ-д бодлого, хөтөлбөр боловсруулах үндсэн эх материал болох юм. Ялангуяа хөлстэй, хөлсгүй хөдөлмөр дэх цагийн



хуваарилалт, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоо, ажил эрхлэлттэй холбоотой бодлогын асуудлыг ойлгож тодорхойлоход судалгааны дүн ихээхэн чухал юм.

*Олон улсын практикт хэрэглэгддэг цаг ашиглалтын судалгааны арга зүйг ашиглаж, мэдээллийн шинэ эх сурвалжийг бий болгосноороо ач холбогдолтой, Монголын нөхцөлд ашиглах боломжтой ажил болжээ.*

## 097

**Үндэсний Статистикийн Газар (National Statistical Office), (2002.01). Poverty Statistics in Mongolia (Монголын ядуурлын статистик.).**

[http://www.unescap.org/stat/cos13/cos13\\_8e.pdf](http://www.unescap.org/stat/cos13/cos13_8e.pdf)

*Илтгэл, 11 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлын шугам

*JEL:* I30, 32

Энэхүү илтгэл нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, ялангуяа ядуурлын талаархи тоон өгөгдлүүдийг агуулаад зогсохгүй тэдгээрийн өөрчлөлт, хандлагад дүн шинжилгээ хийсэн байна. Тоон өгөгдлүүд нь 1998 оны амьжиргааны түвшний түүвэр судалгааны үр дүнд түшиглэжээ.

*Энэхүү илтгэл нь эрдэмтэн, судлаачид, оюутнууд ядууралтай холбоотой асуудлаар хийх цаашдын судалгаанд ашиглагдах өргөн баялаг мэдээлэл агуулснаараа ач холбогдолтой.*

## 098

**Үндэсний Статистикийн Газар (National Statistical Office), Дэлхийн Банк (World Bank). (2001). Mongolia Participatory Living Standards Assessment 2000 (Монголын амьжиргааны түвшний оролцооны аргын судалгаа 2000). Монгол, Улаанбаатар: ADMON хэвлэл.**

*Судалгааны тайлан, 45 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны түвшин, эмзэг байдал

*JEL:* I30, I32

Энэхүү судалгаа нь оролцооны аргаар хийгдсэн Монголын анхны судалгаа бөгөөд ядуучуудын үзэл бодол, дуу хоолойг ядуурлыг бууруулах бодлого, стратегийг боловсруулахад тусгах боломж олгож байна. Уг судалгаа нь Монголын ядуурал, амьжиргааны түвшнийг өргөн хүрээнд хөрөнгө чинээ, сайхан амьдрал, байршил, хүйс, насны үзүүлэлтүүдээр нь авч үзэж нарийвчлан шинжилсэн байна. Оролцогсад өөрсдөө амьдралын сайн, муу ялгааг хэрхэн ойлгож буйг тодорхойлж, хүмүүсийн амьдралын чанарт гарч буй өөрчлөлтүүдийг шинжлэн, амьжиргааны эх үүсвэр, арга замуудыг судалсан байна. Цаашид ядуурлыг бууруулахад чиглэгдсэн бодлого, стратегийг боловсруулахад ядуурлын харилцан адилгүй, нарийн төвөгтэй нөхцөл байдлыг тооцож үзэх шаардлагатай гэж дүгнэжээ.

*Тайлан нь ядуурлын дүр зургийг олон талаас нь нарийвчлан судалснаараа Монголын ядуурлыг ойлгох, тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой болжээ. Ядууралтай холбоотой*

асуудлуудыг сонирхдог судлаач, оюутнуудад Монголын ядуурлын талаар дэлгэрэнгүй ойлголт өгнө.

## 099

**Үндэсний Статистикийн Газар ба НҮБХХ. (1999). Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998. Монгол, Улаанбаатар: Адмон хэвлэл.**

**National Statistical Office & UNDP. (1999). Living Standard Measurement Survey 1998. Mongolia, Ulaanbaatar: Admon Press.**

Судалгааны тайлан, 104 ба106 хуудас, монгол, англи.

*Түлхүүр үгс:* Амьжиргааны түвшин, ядуурал

*JEL:* I30, I31

Энэ нь 1995-1998 онд хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдал хэрхэн өөрчлөгдөж, ямар ахиц дэвшил гарсныг дүгнэх зорилгоор 1998 онд хүн амын дунд хийгдсэн түүвэр судалгааны тайлан юм. Олон шатлал бүхий пропорциональ хамааралтай санамсаргүй түүврийн аргаар 3 үе шаттайгаар судалгааг явуулсан байна. Судалгаа нь ядуурлын шугамыг өрхийн орлого, зарлагын судалгаанд үндэслэн тодорхойлж, өрхийн амьжиргааны түвшинг өрхийн зарлагад суурилан тодорхойлжээ. Тайлан нь танилцуулга, судалгааны арга зүй, ядуурлын хэмжүүр, монгол дахь ядуурлын байдал, ядуу хүний хэрэглээ, хангамж болон дүгнэлт гэсэн 6 бүлгээс бүрдэнэ. Уг судалгаа нь 1995-1998 онд ядуу хүн амын тоо 2.6 хувиар өссөн боловч монголын ядуурлын түвшин бараг өөрчлөгдөөгүй, ядуурал хөдөөгөөс хот руу төвлөрч, ядуурлын гүнзгийрэлт, хүн амын орлогын тэгш бус хуваарилалт нэмэгдсэн байна гэж дүгнэжээ. Түүнчлэн, ядуу өрхийн нилээд их хувийг эмэгтэй тэргүүнтэй өрхүүд эзэлж ядууралд өртсөн өрхүүд голдуу ам бүл олонтой өрхүүд байна гэж үзжээ.

Энэхүү тайланд амьжиргааны түвшний түцвэр судалгааны тоон өгөгдлүүдийг нэгтгэн, монголын ядуурал, түцнийг тодорхойлогч шинж чанаруудыг олон талаас нь авч үзжээ. Шинжилгээний үр дүн, зөвлөмж дүгнэлтүүд нь түцвэр судалгааны тоон өгөгдлөөс урган гарч байна. Энэ нь Монголын ядуурлын маш нарийн тоон мэдээллийг агуулснаараа монголын ядуурлын талаарх цаашидын судалгаа шинжилгээнд ашиглагдах өргөн боломжтой. Судалгааны тайлангийн ихэнх бүлгүүд энгийн, ойлгомжтой хэлбэрээр бичигдсэн нь мэргэжилтэн судлаачид төдийгүй олон нийт унших, ашиглах боломжтой болжээ. Харин зарим бүлэг, тухайлбал, ядуурлын хэмжүүрийн тухай бүлэгт мэргэжлийн зарим нэр томъёо нь ойлгоход түвэгтэй байдлаар бичигдэж, цаашид судалгааны тайланд огт хэрэглэгдэхгүй нэр томъёог ч оруулжээ. Түүнчлэн, түцврийн хэмжээг хэрхэн сонгосон, түцний төлөөлөл нь ямар болох нь бүдэг бүрхэг байна.

## 100

**Финч, Х (Finch, Ch). (2003). Assessment and profile of other donor activity in Mongolia (Монголд үйл ажиллагаа явуулдаг бусад доноруудын үйл ажиллагааны дүр төрх, үнэлгээ). No.3. <http://www1.oecd.org/dac/images/AidRecipient/mng.gif>**

*Өгцүлэл, 18 хуудас, англи*

*Түлхүүр цгс:* доноруудын үйл ажиллагаа

*JEL:* F35, F34

Энэ ажил нь Монголд үйл ажиллагаа явуулж буй бусад доноруудын өнөөгийн дүр төрхийг авч үзсэн. Хөгжлийн албан ёсны тусламжийн ихэнх нь Монгол Улсын Засгийн газраар дамждаг. Нэг хүнд ногдох байдлаар авч үзвэл Монгол улс дэлхийд нэлээд дээгүүрт тооцогдох доноруудын тусламжийг авдаг. 1991-2001 оны хооронд Хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ жилд дунджаар 216 мянган доллар байсан. Энэхүү ажилд засаглал, хууль эрх зүй, эдийн засаг, нийгмийн салбар, дэд бүтэц, хүрээлэн буй орчин, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, хувийн сектор зэрэг салбаруудаар доноруудын үйл ажиллагааг авч үзсэн. Монгол Улсын хөгжлийн эн тэргүүний зорилтыг шийдвэрлэхэд доноруудын тусламж чухал ач холбогдолтой. Иймээс ч ядуурлыг бууруулахад чиглэсэн олон хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлснийг энэ ажилд дурьдсан байна.

*Судлаач, бодлого боловсруулагчдад зориулсан. Доноруудын үйл ажиллагааг салбар бүрээр авч үзсэн нь мэдээллийн ач холбогдолтой. Мөн салбаруудыг хооронд нь харьцуулах, харьцуулсан шинжилгээ хийх боломжтой.*

## 101

**Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр (Rural Poverty Reduction Programme). Progress Report 2003 (2003 оны ахиц дэвшлийн тайлан). <http://www.rprpmongolia.mn/eng/pdf/Progress%20report%202003%20Eng.Ver.pdf>**

*Тайлан, 36 хуудас, англи*

*Түлхүүр цгс:* ядуурал

*JEL:* I30

Энэхүү ажил нь Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгуудад хэрэгжсэн Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрт үнэлгээ өгөх зорилготой. 2003 оны хөтөлбөрт хамрагдсан дээрх аймгийн зарим сумдын нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүд, ялангуяа ядуу өрхийн талаарх мэдээллийн санг байгуулсан. Эдгээр аймгуудын судалгаанд хамрагдсан сумдыг экологи, цаг агаарын хүчин зүйл, дэд бүтцийн хөгжил, ядуурлын түвшин, засаглалын менежмент зэрэг үзүүлэлтүүдээр сонгож авчээ.

*Энэ ажилд Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгуудад хэрэгжсэн Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааг танилцуулж, цр дүнг нэгтгэн дүгнэжээ. Судалгааны цр дүнг нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад үнэтэй, чухал мэдээллийн шинэ эх сурвалжийг бий болгосноороо ач холбогдолтой болжээ.*

## 102

**Хэен, М (Micheal Heyn). (2001). Final Evaluation Report: MicroStart Mongolia (Микростарт Монгол төслийн эцсийн үнэлгээний тайлан). Монгол, Улаанбаатар. [http://www.un-mongolia.mn/reports/files/microstart\\_evaluation.pdf](http://www.un-mongolia.mn/reports/files/microstart_evaluation.pdf)**

*Тайлан, 65 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, бичил санхүү

*JEL:* I38, G29

Микростарт туршилтын төсөл нь анх 1997 онд батлагдан, 1998 оны дундаас эхлэн 2001 оны дунд хүртэл НҮБХХ болон олон улсын бусад санхүүжүүлэгч байгууллагуудын хөрөнгөөр хэрэгжсэн ядуу, санхүүгийн боломжгүй хүмүүс, жижиг дунд бизнесийн үйл ажиллагаанд зээл олгох, бичил санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, санхүүгийн нэг хэлбэр болох банк бус санхүүгийн байгууллагыг амжилттай төлөвшүүлэхэд зориулагдсан төсөл байсан. Уг шинжилгээний тайлангийн гол зорилго нь Монгол Улсын хөгжлийн нөхцөл байдал; харилцагч, хамрагдагчдын нийгэмд гүйцэтгэж буй үүрэг; бичил санхүүгийн орчны боломжит байдал ба санхүүгийн бусад байгууллагууд, гадаад харилцагч нарын ололт амжилт; өрхийн амьжиргааны аюулгүй байдалд үйл ажиллагаагаараа үзүүлсэн нөлөөлийг үнэлэх явдал байна. Үнэлгээний шинжилгээнээс дүгнэлтүүд гаргаж, цаашдын үйл ажиллагаанд чухал хэд хэдэн санал зөвлөмжийг боловсруулжээ. Уг төсөл хөгжлийн асуудалтай, тэр дундаа ядуу өрх, хүн, ядууралтай илүү холбоотой хэрэгжсэн учраас үр дүн нь манай улсын ядуурал, түүнийг бууруулах, арилгахад үр нөлөөтэй бичил санхүүгийн тогтолцооны бүтэц, удирдлага, хэрэгжүүлэх арга механизмтай чанд уялдан холбогдож гарчээ.

*Энэхүү тайлан нь уг төслөөс үзүүлсэн нөлөөллийг олон талаас нь бодит баримт, тоон өгөгдөл дээр тулгуурлан гаргасан олон чухал үр дүн, зөвлөмж санал, ялангуяа ядуурлыг бууруулахад цаашид үргэлжлүүлж болох бичил санхүүгийн төслийг хэрэгжүүлэхэд анхаарах алдаа, дутагдал, авч болохуйц санаа, туршлага зэргийг тодорхойлсон, ядуурлыг бууруулах болон санхүүгийн секторын хөгжлийн хамаарлыг илэрхийлсэн ач холбогдолтой ажил юм.*

## 103

**Цэвэлмаа, Х. (2003). Орон сууцны хувьчлалын ядуурал, тэгш бус байдалд үзүүлсэн нөлөөллийн судалгаа. Эдийн засаг: онол, практик, ? 214 (10), х 98-108.**

*Өгцлэл, 11 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, тэгш бус байдал

*JEL:* I30, O15

Энэхүү судалгааны ажлын гол зорилго бол Монгол Улс дахь ядуурал, тэгш бус байдалд орон сууцны хувьчлалын үйл явц 1990-ээд оноос хойшхи хугацаанд хэрхэн нөлөөлснийг шинжлэх явдал юм. Мэдээллийн хоёрдогч эх үүсвэрүүд болох олон улсын болон үндэсний зөвлөхүүд, судлаач, шинжээчдийн судалгааны материал, санал дүгнэлт, статистикийн мэдээлэл, орон сууцны хувьчлалыг явуулсан туршлага сургамж зэрэг материалуудыг судалж өмч хувьчлал, ядуурал, тэгш бус байдлын харилцан хамаарлыг авч үзэж, орон сууцны хувьчлал нь ядуурал,

тэгш бус байдалд нөлөөлснийг тодорхойлох түүвэр судалгааны аргачлалыг тайлбарлаж, түүвэр судалгааны үр дүнгийн зарим хэсгээс танилцуулжээ.

*Судлаач, бодлого боловсруулагчдад зориулагдсан. Судалгааны ажлын хүрээнд орон сууцны хувьчлал, баялгийн хуваарилалтын асуудлыг шинжилж, орон сууцны хувьчлал нь орлого хуваарилалт, хөдөлмөр эрхлэлт, ядуурал ба тэгш бус байдалд хэрхэн нөлөөлж буйг, өрхийн тэргүүний хүйсийн болон боловсролын түвшний ялгаа, орон сууцны хувьчлалтай холбоотой бусад асуудлуудыг авч үзсэнээрээ ач холбогдолтой ажил болжээ.*

#### 104

**Цэвэлмаа, Х. (2002). Хүнсний аюулгүй байдал. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, шалгуур үзүүлэлтүүд: илтгэлүүдийн эмхэтгэл (х 61-74). Монгол, Улаанбаатар.**

*Өгцлэл, 14 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Хүнсний аюулгүй байдал, ядуурал, ядуурлын шугам, амьжиргааны түвшин  
*JEL:* I30, H55, I32, I31

Уг судалгааны зорилго нь глобальчлагдаж байгаа эдийн засагт, тэр дундаа жижиг нээлттэй эдийн засагт хүнсний аюулгүй байдлыг хөгжлийн бодлогын тоон шинжилгээний талаас судалж, улмаар бодлогын хувилбарыг сонгох юм. Хүнсний аюулгүй байдлыг тодорхойлж буй олон улсын жишиг, Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдлыг тодорхойлно. Хүнсний аюулгүй байдлын хүрээнд сонголт нь өлсгөлөн, ядууралтай зайлшгүй холбогдож байдаг. Судалгааны эцэст хүнсний аюулгүй байдлын бодлогод өгөх санал зөвлөмж, дүгнэлтийг оруулжээ.

*Илтгэлүүдийн эмхэтгэлийг албан ажлын хэрэгцээнд зориулан гаргасан. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлон, хүнсний үйлдвэрлэл, орлогын хоорондын хамаарал нь ядуурлыг бууруулах бодлогод чухал болохыг дурьдсан байна. Цаашид энэ талаар хийх судалгааны ажлын чиглэлүүдийг тодорхойлсон нь чухал ач холбогдолтой болжээ.*

#### 105

**Цэдэндамба, Л., Ренчинбазар, Р. (Tsedendamba, L., Renchinbazar, R.). A Need of Efficient Reflection of Issues on Rural Poverty in the Strategy of Poverty Reduction, and Some Methodologies (Ядуурлыг бууруулах стратегид хөдөөгийн ядуурлын асуудлуудыг бүтээлчээр тусгах шаардлага ба зарим арга зүй).**

[http://www.worldbank.org/wbi/attackingpoverty/events/Asia\\_1002/mongolia\\_regional\\_tsedendamba\\_eng.pdf](http://www.worldbank.org/wbi/attackingpoverty/events/Asia_1002/mongolia_regional_tsedendamba_eng.pdf)

*Өгцлэл, 10 хуудас, англи.*

*Түлхүүр үгс:* Ядуурал, бүс нутаг

*JEL:* I30, R00

Энэхүү өгүүлэлд ядуурлыг эдийн засгийн бүсүүдээр авч үзэж судалсан байна. Судалгаанд бүсүүдийн нэг хүнд ногдох орлого, ядуурал, ажилгүйдлийн түвшин, нэг хүнд ногдох ДНБ

болон зарим үйлчилгээний хүртээмжийн байдлыг харьцуулан судалжээ. Түүнчлэн ядуурлыг бууруулах стратегийг бүсүүдийн хөгжлийн стратегитэй уялдуулах шаардлагатай болохыг зөвлөмж болгожээ.

*Энэхүү судалгаа нь эдийн засгийн бүсүүдийн үзвэлтүүдийг хооронд нь харьцуулан шинжилснээрээ сонирхолтой юм. Харин зарим нэр томъёо нь зарим талаар ойлгомж муутай болжээ.*

## 106

**Цэрэнпил, Д. (1999). Монголын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд. МУИС, Эрдэм шинжилгээний бичиг (?5 (149), х 1-17). Монгол, Улаанбаатар.**

*Өгцлэл, 17 хуудас, монгол.*

*Түлхүүр үгс:* Шилжилтийн үйл явц, ядуурал

*JEL:* P20, I30

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардлагатай гэсэн арга хэмжээнүүдийг санал болгосон байна. Уг ажилд, сүүлийн жилүүдэд хүн амын амьдралын түвшин доройтож, ядуурал өссөөр байна гэж дүгнэжээ. Түүнчлэн ядуурал нь зөвхөн хүн амын орлогын бууралтаар илэрч байгаа төдийгүй, хүний эрүүл мэнд, боловсролын түвшин доошлох, ёс суртахуунаар доройтох үйл явцтай зэрэгцэн явагдаж байна гэжээ. Малчин өрхийн малын тоо толгой өссөөр байгаа боловч баян, ядуугийн ялгаа нэмэгдэх хандлагатайг тоон мэдээллээр харуулсан байна.

*Энэхүү өгцлэл нь ядуурал, орлогын ялгаатай байдлын чиг хандлагад дүн шинжилгээ хийж, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлжээ. Судалгаанд малчин өрхийн малын тоо, ядуурлын түвшин, ядуу хүн амын талаарх сонирхолтой тоон мэдээллүүд ашиглагдсан байна.*

## 107

**Чимэд, Ү., (2000). Эдийн засгийн өсөлт, ядуурал ба орлого хуваарилалт. Дорж, Т., (ред.), Хөгжлийн эдийн засаг., х 74-109. Улаанбаатар.**

*Номын бэлэг, 36 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, орлого хуваарилалт, тэгш бус байдал

*JEL:* I32, D31

Номын энэ бүлгийн зорилго нь хөгжлийн эдийн засаг дахь ядуурал, орлого хуваарилалтын онолын ойлголтыг танилцуулах юм. Түүнчлэн эдгээр ойлголтууд нь эдийн засгийн өсөлттэй хамааралтай болохыг авч үзжээ. Энэ ажилд эдийн засгийн өсөлт, орлогын хуваарилалт болон ядуурлын хоорондох хамаарлын асуудлыг авч үзэн онолын тайлбар өгсөн байна. Хөгжиж байгаа орнуудад харьцангуй тэгш бус байдал ямар хэмжээнд байгаа, хэнийг ядуу гэдэг ойлголтод хамруулах, хүн амын энэ давхаргын эдийн засгийн байдлыг яаж тодорхойлох, эдийн засгийн өсөлтийн шинж чанарыг юу тодорхойлдог, түүнээс хэн хождог, эдийн засгийн хурдан өсөлт

болон орлогын илүү тэгш хуваарилалт нь өөр хоорондоо уялдаа холбоотой, эсвэл зөрчилтэй эсэх, туйлын ядуурлын хэмжээг сааруулахын тулд ямар бодлого явуулах учиртай зэрэг онолын асуудлыг дэлгэрэнгүй авч үзжээ.

*Сурах бичгийн энэ бэлгийг оюутан залуучууд, эхлэн судлаачдад зориулжээ.*

108

**Шэлциг,К (Schelzig,К). (2000). The Pitfalls of poverty measurements in Mongolia (Монгол дахь ядуурлын хэмжилтийн гажиг). Хөгжлийн Альтернатив, улирлын сэтгүүл. (х 5-6). [http://www.dai.com/pdfs/Developments\\_Spring\\_2000.pdf](http://www.dai.com/pdfs/Developments_Spring_2000.pdf)**

*Нийтлэл, 2 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлыг хэмжих  
*JEL:* I30, I32

Энэ нийтлэлд ядуурлын хэмжилт нь цаг хугацааны хувьд тогтвортой байдлаа хадгалж чадахгүй гэдгийг Монголын нөхцөлд харуулахыг зорьсон байна. Ядуурлыг толгой дараалан хэмжих арга нь хамгийн сайн нь биш боловч амьдралд өргөн хэрэглэгддэг. Монголд амьжиргааны түвшний түүвэр судалгааг 1995, 1998 онд хоёр удаа хийсэн. Судалгааны үр дүнд ядуурал дорвитой буураагүй (1995 онд 36,3, 1998 онд 35,6) гэсэн дүгнэлт хийгдсэн. Энэ нь хэт түргэдсэн дүгнэлт байж болох юм. Хэдийгээр ядуурлын түвшинд өөрчлөлт гараагүй ч статистикийн тоо баримтаас харахад хүмүүсийн амьдралын сайн сайхан байдал дээшилсэн байна. Тухайлбал, дундаж бодит орлого өссөн, дундаж наслалт уртассан, малчин өрхүүдийн удаан эдэлгээт үл хөдлөх хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн, нэг хүнд ногдох хүнсний хэрэглээ нэмэгдсэн зэргийг дурьдаж болно. Энэ хоёр судалгааны арга зүйд хэд хэдэн өөрчлөлт гарчээ. Үүнд, судалгааны хүрээ өргөжсөн (хоёр маш ядуу аймгийг түүвэрт нэмж хамруулсан), хүнсний хэрэглээний сагсанд зайлшгүй байх 2 зүйл нэмэгдсэн, нийт ядуурлын шугамд хүнсний эзлэх хувь хэмжээ өөрчлөгдсөн, хүнсний янз бүрийн бүлэглэлүүдээс байгуулсан калорийн харьцаа шинэчлэгдсэн, насанд хүрсэн хүмүүсийн жишигт шилжүүлсэн коэффициент нь өөрчлөгдсөн. Иймд дээрх судалгааны үр дүнгүүдийг харьцуулах боломжгүй юм. Нөгөө талаар, ядуурлын шугамыг тооцож байгаа үндсэн зүйлс нь адилхан байх тохиолдолд хоёр судалгааг харьцуулах боломжтой. EPSP-ийн судалгаагаар ядуурлын шугам арай өндөр байсан гэж үнэлжээ. Цаашид энэ талаар илүү их судалгааны ажил хийх хэрэгтэй гэж тэмдэглэжээ.

*Судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан. Сонирхолтой санааг дэвшилцсэн, цаашид судлах шаардлагатай болохыг хөндсөнөөрөө ач холбогдолтой юм.*

109

**Шэлциг, К (Schelzig, K). (2000). Poverty in Mongolia: Comparing the 1995 and 1998 LSMS Headcounts (Монголын ядуурал: 1995, 1998 онуудын Амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнг харьцуулах нь). USAID.**

**[http://www.opensocietyforum.mn/res\\_mat/Poverty%20in%20Mongolia\\_04\\_2000.pdf](http://www.opensocietyforum.mn/res_mat/Poverty%20in%20Mongolia_04_2000.pdf)**

*Өгцлэл, 14 хуудас, англи.*

*Түлхүүр үгс:* Ядуурал, шилжих хөдөлгөөн

*JEL:* I30, O15

Энэхүү өгүүлэл нь Дэлхийн Банкны дэмжлэгээр Үндэсний Статистикийн Газраас хийсэн 1995, 1998 онуудын Амьжиргааны түвшний түүвэр судалгааны үр дүнг, ялангуяа, энэ хоёр судалгаанд хамрагдсан ядуу хүн амын тоог хооронд нь харьцуулах боломжийг судлах зорилготой. Судалгаанаас үзвэл, түүвэр судалгаануудын үр дүнг өөр хооронд нь харьцуулахад нэн болгоомжтой байж, түүвэр судалгаануудад хэрэглэгдэж буй ядуурлын тодорхойлолт, арга зүй нэг ижил байгаа эсэхийг хянах нь ядуурлын хандлагыг үнэн зөв харахад зайлшгүй чухал юм. Монгол Улсын 1995, 1998 онуудын түүвэр судалгааны үр дүнг харьцуулахад энэ санааг анхаарч үзвэл Улаанбаатар хотын хувьд гэхэд л 1998 онд ядуу хүн амын тоо 10000 гаруй хүнээр цөөн болох юм гэж дүгнэжээ.

*Энэ судалгааны ажил нь 1995, 1998 онуудын тцвэр судалгааны аргачлал, хэрэглэгдсэн ядуурлын шугамын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч байна. Зөвхөн мэдээлэл өгөөд зогсохгүй тэдгээрийг нарийвчлан судалж, судалгааны эцсийн дүнд хэрхэн нөлөөлөх талаар дүн шинжилгээ хийснээрээ ач холбогдолтой юм. Ядуурлын талаар судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачид, оюутнууд ашиглах боломжтой сайн ажил болжээ.*

110

**Энх-Ариун, О. (Enkh-Ariun, O). “Linking Policy with Monitoring” (Бодлогыг хяналттай холбох нь). [http://www.worldbank.org/wbi/attackingpoverty/eap/hanoi\\_cennk-ariunaa.pdf](http://www.worldbank.org/wbi/attackingpoverty/eap/hanoi_cennk-ariunaa.pdf)**

*Илтгэл, 3 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, ядуурлыг бууруулах бодлого

*JEL:* I38, I32

Монголын ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зорилт, түүний биелэлтийг дүгнэх, хянах механизмыг авч үзээд хяналтын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох шаардлагатайг дурьдсан байна.

*Судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан. Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх үзцүлэлтүүдийг тодорхойлох тулгамдсан асуудал байгааг харуулснаараа ач холбогдолтой болжээ.*



## 111

**Энхтайван, Л (Enkhtaivan, L). (2003). Current situation of Mongolian economic development and mid-term strategy, Factors of economic cooperation in the northeast Asia (Монголын эдийн засгийн хөгжил ба дунд хугацааны стратегийн өнөөгийн төлөв байдал, Зүүн хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагааны хүчин зүйлс) (х 98-100). Монгол, Улаанбаатар.**

*Судалгааны тайлан, 3 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ажилгүйдэл, ядуурал

*JEL:* E24, I30

Судалгааны зорилго нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн өнөөгийн төлөв байдлыг танилцуулан, Засгийн газрын нийгэм, эдийн засгийн дунд хугацааны хөгжлийн стратегийн талаар санал бодлоо солилцох юм. Дунд хугацааны хөгжлийн стратеги нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг урамшуулахад чиглэсэн. Монгол Улсын Засгийн газар 2002 оны байдлаар макро эдийн засгийн тогтворжилтийг хангах зорилгоо хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн бөгөөд ядуурлыг бууруулах эдийн засгийн өсөлтийг бий болгох дунд хугацааны зорилгыг амжилттай хэрэгжүүлэх болно гэж үзсэн байна.

*Тайлан нь эдийн засгийн тухайн үеийн төлөв байдлыг үндсэн үзүүлэлтүүдээр тодорхойлон гаргасан, дунд хугацааны хөгжлийн стратегийн талаар товч мэдээлээр хангах хэлбэрээр бичигдсэн ажил болсон байна. Зөвхөн 2002 оны бодлогын хэрэгжилтийн байдалд үндэслэн дунд хугацааны стратегийг хэрэгжих боломжтой гэж дүгнэсэн нь учир дутагдалтай болсон байна. Судлаачид, оюутан сурагчид ашиглахад зориулагдсан.*

## 112

**Энхцэцэг, Б. (1998). Монгол дахь ядуурлын дүр төрх, хүрээ тэлэлт. Монголын хүн ам зүйн сэтгүүл, 1, (х 49-58). Монгол. Улаанбаатар.**

*Өгүүлэл, 10 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, орлого хуваарилалт

*JEL:* I32, O15

Энэхүү өгүүллийн гол зорилго нь НҮБ-ийн сайн дурынхны Үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаа аймаг, дүүргүүдийн ядуу иргэдийн насны онцлог, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс төр, эрүүл мэнд, амьжиргааны нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл олж авахад оршино. Энэ нь тухайн орон нутагт ядуурал бууруулах үндэс суурь болж өгөх юм. ЯБҮХ-ийн газрын сайн дурынхны хэсгээс зохион байгуулсан Монголын ядуурлын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Өрхийн тэргүүн, өрхийн ам бүл, нас хүйсний бүтэц, гэрлэлтийн байдал, боловсрол, сургууль завсардалт гэсэн шинж байдлаар нь ядуу өрхүүдийг судалжээ. Ядуу өрхийн орлогын дийлэнх хэсгийг цалин бүрдүүлж байхад зардлын ихэнхийг хоол, хүнсний зардал эзэлж байна гэж дүгнэжээ.

*Судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан. Судалгааны түүврийн хэмжээ, судалгаанд хамрагдсан газрын талаар мэдээлэл хангалттай бус байна. Гэхдээ ядуу өрхүүдийн талаар нэлээд дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн байна.*

## 113

**Энхцэцэг, Б., (1997). Монголын эдийн засгийн хөгжил ба ядуурал. Монголын хүн ам зүйн сэтгүүл, Эмхэтгэл 3, ᠑1, х 50-59.**

*Өгцлэл, 10 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, ядуурлын түвшин

*JEL:* I30, I31

Энэ өгүүлэлд ядуурлыг тууштай бууруулж, нийгмийн бусад асуудлыг туйлбартай шийдвэрлэхэд өндөр үр ашигтай микро эдийн засаг, хариуцлагатай макро бодлого, тэдгээрт түшиглэсэн эдийн засгийн тогтвортой өсөлт зайлшгүй шаардлагатайг харуулжээ. Ядуурал нь хүн амын бодит орлого, амьжиргааны түвшин буурснаар илэрч байгаа төдийгүй, хоол тэжээлийн илчлэг дутагдсанаас эрүүл мэнд муудах, боловсрол, соёлын үйл ажиллагаа суларч, оюуны хоосролд орох, хүүхэд сургууль завсардах, тэнүүчлэх, нийгэм ёс суртахууны доройтолд орох, гэр бүл салах, хүүхэд өнчрөх, гэмт хэрэг өсөх зэрэг ноцтой сөрөг үр дагавартай байна. Тэрчлэн ажилгүйдэл, хагас ажилгүйдэл нэмэгдэж буй нь хөдөлмөрийн нөөцийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломжийг алдаж байна. Хэрэв ядуурлын одоогийн түвшин хэвээр байх эсвэл цаашид нэмэгдвэл зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц удааширч, өөрчлөлт шинэчлэлийн өргөн цар хүрээтэй бодлого, үйл ажиллагаанд ноцтой сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм. Ийнхүү ядуурал бий болох үндсийг арилгах, ядуурлыг бууруулах, ядуурлаас ангижрах оновчтой бодлогыг бодовсруулж, хэрэгжүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна гэжээ.

*Энэ ажил нь судлаач, бодлого боловсруулагчдад зориулагдсан. 1990 оноос эхэлсэн шилжилтийн үеийн сөрөг үр дагавар болох ард түмний амьжиргааны түвшин буурч, ядуурал нэмэгдэх болсныг Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдалтай холбон авч үзжээ. Монголд ядуурал их байгаа учир зөвхөн эдийн засгийн өсөлтийг хангаж байж ядуурлыг бууруулах бололцоо бүрдэнэ гэсэн дүгнэлтийг судлаач хийсэн байна.*

## 114

**Энхцэцэг, Б. (1996). Монголын хүн амын ядуурал ба амьжиргааны байдал. Монголын хүн ам зүйн сэтгүүл, эмхэтгэл 1, ( х 135-141).**

*Өгцлэл, 7 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Амьжиргааны түвшин, ядуу хүн, өрх, шилжилтийн эдийн засаг, орлого

*JEL:* I30, I31, D10, D31, P20

Уг ажилд дурьдсанаар ядуурал гэдэг нийгмийн асуудалд бага орлого, орлогын хомсдол гэсэн нэр томъёог түгээмэл хэрэглэдэг, гэтэл энэхүү ойлголт нь үйлдвэр түлхүү хөгжсөн умардынхны чинээлэг амьдралд үндэслэсэн ойлголт тул нүүдлийн соёл иргэншил давамгайлсан, хүн ам сийрэг суурьшилтай, зах зээлийн багтаамж бага, буурай хөгжилтэй манай орны хувьд амьдрал, амь зуулгын түвшинг хэрхэн тодорхойлохыг оновчтой болохыг онол, практикийн үүднээс нарийвчлан судалжээ. Энэхүү ажил нь Оршил, Монгол дахь ядуурлын шалтгаан, Ядуурлыг хэмжих, Ядуурлын өнөөгийн байдал, Хүн амын амьжиргааны байдал гэсэн үндсэн 5 хэсгээс бүрджээ. 1995 оны Өрхийн төсвийн судалгааны үр дүнг танилцуулж, тэдгээр үр

дүнгүүдэд статистик шинжилгээ, харьцуулалтын аргуудыг ашиглан Монгол дахь ядуурлын шалтгаан, түүнийг бууруулах, арилгах арга замуудыг тодорхойлжээ.

*Энэ ажил нь оюутан, судлаач эрдэмтэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, бүх хүрээний бусад хүмүүс унших, ашиглахад тохиромжтой, статистик шинжилгээ, харьцуулсан судалгааг багтаажээ. Уг ажлаас ерөнхийдөө 1995 оны Өрхийн төсвийн судалгааны үр дүнг болон уг түүхээр судалгааг хийсэн онцлог, бүртгэл, тооцоололт, үзүүлэлтүүдийн онцлог байдлыг тодорхой хэмжээнд мэдэж авах боломжтой. Судлаач өөрийн орны онцлогт тохирсон амьдрал, амь зуулгын түүвшинг тодорхойлох оновчтой аргыг тодорхойлох зорилго уг ажилд дэвшилцээгүй ч ядуурлыг бууруулах арга замуудыг олон талаас нь авч үзжээ. Цаашид ядуурлын судалгааг ямар чиглэлээр хийвэл зохистой талаар санал бодлоо дэвшилцж тавьснаараа ач холбогдолтой юм.*

## 115

**Энхцэг, Б. (1997). Монголын хөдөөгийн ядуурал. Монголын хүн ам зүйн сэтгүүл, эмхэтгэл 2, (21, х 44-49).**

*Өгцлэл, 6 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Ядуу өрх, хөдөөгийн ядуурал, амьжиргааны түвшин  
*JEL:* I30, I39, I31

Уг ажилаар хөдөөгийн ядуурлын мөн чанар, төлөв байдал, шалтгаан, түүнд нөлөөлөгч нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлүүдийг илрүүлэн тогтоож түүнийг бууруулах, улмаар арилгах арга замуудыг тодорхойлохыг зорьсон байна. Агуулга, хөдөө дөх ядуурлын шалтгаан, хөдөөгийн ядуурлыг хэмжих, хөдөөгийн ядуурлын төлөв байдал гэсэн үндсэн 4 хэсэгтэй. Ядуурал гэдгийг бага орлого, бага хэрэглээ гэж товчоор тодорхойлон, манайд ядуурлыг тодорхойлж буй “ядуурлын шугам”, амьжиргааны түвшний судалгааны үр дүнгийн статистик тоон мэдээллүүдийг дурдах, харьцуулах аргыг хэрэглэн хөдөөгийн ядуурлын үндсэн шалтгаануудыг илрүүлж, хөдөөгийн ядуурлыг шийдвэрлэхэд чухал хэд хэдэн хэрэгтэй санал, бодол, аргуудыг дэвшүүлжээ.

*Энэ ажил нь оюутан, судлаач эрдэмтэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, бүх хүрээний бусад хүмүүс унших, ашиглахад тохиромжтой, хүн ам зүй, статистик харьцуулсан судалгааны шинжтэй юм. Албан ёсны статистик мэдээллээр манай улс шилжилтийн эдийн засагтай орнууд дотроос бараг ганцаараа хотын ядуурал нь хөдөөгийнхөөсөө илүү байдаг онцлогтой. Ийм тохиолдолд хөдөөгийн ядуурлыг тусгайлан авч үзэх асуудал дэвшилцж, улмаар тухайн үеийнхээ статистик тоон мэдээллийг гаргаж авч байгаа бүртгэл, хэмжилтийн арга аргачлалыг сайтар тайлбарлаж, ашигласан нь цаашид хийх судалгааны ажилд ач холбогдолтой болжээ. Энд дурдагдсан ядуурлын шалтгаан, төлөв байдал, бууруулах арга хэрэгсэл, бодлогуудыг тус тусад нь нарийвчлан судалж гүнзгийрүүлэх боломжтой.*

## 116

**Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр. (2000). Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 1994-2000. Монгол. Улаанбаатар: Бит сервис ХХК-ийн хэвлэх үйлдвэр.**

*Товхимол, 50 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, ядуурал  
*JEL:* I38, I30

Энэхүү товхимол нь ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэн сурталчилж таниулах зорилготой. Энд уг хөтөлбөрийн зорилт, ЯБҮХ-ийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, ядуурлыг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээг төсөл хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд нэгтгэн харуулсан байна. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг түүнд хамрагдсан 12 иргэн, өрх гэрийнхэнтэй хийсэн ярилцлага, тэдний санал сэтгэгдэл зэргийг шигтгээ болгон авч үзжээ. Эцэст нь ядуурлыг бууруулах арга замуудыг хүмүүсийн санал сэтгэгдлийн хэлбэрээр харуулж ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн дараагийн шатны үйл ажиллагаа болох Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг баталсан тогтоолыг тайлбарын хамт хавсаргасан байна.

*Уг товхимол нь ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн талаар товч мэдээлэл авахыг хүссэн бүх хүнд зориулагдсан байна. Хөтөлбөрийн үр шимийг хүртсэн хүмүүсийн сэтгэлийн үгээр хэрэгжилтийг гаргасан нь өвөрмөц баталгаа, баримт болж чаджээ. Гэхдээ энд хөтөлбөрийн алдаа дутагдал, сургамжийг авч үзээгүй байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн төслүүдийн хичнээн нь амжилттай хэрэгжсэн, ямар үр дүнд хүрсэн нь тодорхой бус байна.*

## 117

**Японы олон улсын хамтын ажиллагааны банк (JBIC). (2001). Poverty profile executive summary Mongolia (Монголын ядуурлын дүр төрхийн тойм).**

[http://www.jbic.go.jp/english/oec/ environ/poverty/pdf/mongolia\\_e.pdf](http://www.jbic.go.jp/english/oec/ environ/poverty/pdf/mongolia_e.pdf)

*Судалгааны тайлан, 10 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* ядуурал, хот ба хөдөөгийн ядуурал, ядуурлын түвшин  
*JEL:* I30, I32

Энэхүү ажилд Монгол дахь ядуурлын тухай, Монгол дахь ядуурлын шугам, ядуурал болон тэгш бус байдлын хандлага, бүс нутгууд дахь ядуурал, ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын цар хүрээг авч үзсэн байна. Ядуурлыг бууруулах Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа гэсэн хэсэгт ядуурлыг бууруулах бодлого, хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг авч үзжээ. Мөн эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлснээр ядуурлыг бууруулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн хамгааллын сүлжээ, эмэгтэйчүүд болон хөдөөгийн ядуурлыг бууруулах, ядуурлыг бууруулах хамтын ажиллагаа, доноруудын тусламж зэргийн тухай авч үзжээ.

*Монгол дахь ядуурлыг товч боловч тал бүрээс нь авч үзсэн ажил болжээ. Ядуурлын*

тухай онолын ойлголтууд, ядуурлын асуудал нь Монгол Улсад ямар түвшинд байгааг статистикийн мэдээллүүдэд үндэслэн тайлбарлажээ. Ядуурлыг бууруулах ЗГ-ын бодлого, үйл ажиллагааг 1994-2000 онд (ЯБҮХ), 2001 оноос хойш (ӨАЧДХ) гэсэн цаг хугацааны дарааллаар авч үзсэн. Эцэст нь ядуурлыг бууруулах эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын тусламж, хамтын ажиллагаа чухал гэдгийг тэмдэглэжээ. Монгол дахь ядуурлын асуудлыг сонирхон судалж буй бүх хүмүүс ашиглахад тохиромжтой.

## 118

**East Asia: Mongolia in transition (Зүүн Ази: Шилжилтийн үеийн Монгол Улс). 1-р бүлэг. х 60-64. [http://www.jica.go.jp/english/publication/annual/2001/pdf/059\\_064.pdf](http://www.jica.go.jp/english/publication/annual/2001/pdf/059_064.pdf)**

Номын бүлэг, 5 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, шилжилтийн эдийн засаг

*JEL:* I30, P20

Уг бүтээл нь Монгол Улсын шилжилтийн үеийн нөхцөл байдал, JICA-ийн шугамаар явуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх зорилготой. Байгаль орчиндоо дасан зохицохын тулд монголчууд дээр үеэс нүүдэллэн амьдарч ирсэн. ЭЗХТЗ-д гишүүнээр орсноор Монгол Улс түүхий эд, уул уурхай, мал аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэгч байдлаар үйлчилж эхэлсэн. Зөвлөлт Холбоот Улсын эдийн засгийн тусламжийн ачаар Монгол Улсын амьдралын үндсэн нөхцөл (жишээ нь, эрүүл мэнд, боловсрол) нь хөгжиж буй бусад орнуудынхаас илүү сайн байв. Шилжилтийн үед Монгол оронд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд хөрөнгийн хүндрэл, дутагдал байсныг дурьджээ. Эдгээрээс гадна ядуу, баян хүмүүсийн хоорондох ялгаа улам ихэсч, хөдөөд хүмүүсийн боловсролын түвшин, эрүүл мэнд муудаж байгаа нь өнөөгийн бэрхшээлтэй асуудлууд юм. Цааш нь JICA-ийн шугамаар явуулж байгаа үйл ажиллагааг дурьдаад, анхаарах асуудлууд тухайлбал, эмнэлэг, сургуулиудыг засварлах, хөдөөгийн амьдралын нөхцөлийг сайжруулах, газрыг үр ашигтай ашиглах боломж зэргийг судалж байна гэж дурьджээ.

*Энэхүү ажил нь Монгол Улсын шилжилтийн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлууд, JICA-ийн үйл ажиллагааны талаар товч, тодорхой мэдээлэл өгснөөрөө ач холбогдолтой ажил юм. Уг ажил нь Монголд JICA-ийн шугамаар явуулсан үйл ажиллагааны талаар сонирхсон бүх хүмүүс уншихад тохиромжтой.*

## 119

**Ядуурлыг бууруулахад аж ахуйн нэгж байгууллагын үүрэг оролцоо. (1999.11.24). Өнөөдөр, № 274 (824).**

Нийтлэл, монгол

*Түлхүүр үгс:* ядуурал

*JEL:* I30

Энэ нь НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар, ЭМНХЯ-наас “Ядуурлыг бууруулах, ядуурал шинээр бий болохоос сэрэмжлэхэд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд,

буяны байгууллагын оролцоо, хувь нэмрийг тодорхойлох” зорилгоор явуулсан судалгааны үр дүнг танилцуулахад чиглэгдсэн нийтлэл юм. Энэхүү нийтлэлд ядуурлыг бууруулахад улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлийг 7 үндсэн зүйлээр тодорхойлжээ.

*Ядуурлыг бууруулах нь зөвхөн төр, засгийн цэрэг мэтээр хандах явдал нэлээд тохиолддог. Харин энэ өгцлэл нь ядуурлыг бууруулахад аж ахуйн нэгж ямар цэрэгтэй болохыг тодорхойлж, тэдэнд хандсан санал зөвлөмжийг дэвшицүлснээрээ онцлогтой. Улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдлага, эрдэмтэн судлаачид ашиглахад ач холбогдолтой болно.*

2

НИЙГЭМ

## 120

Аассвэ, А (Aassve. A) Алтанхуяг, Г. (2001). **Changing pattern of fertility behaviour in a time of social and economic change: Evidence from Mongolia (Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үеийн төрөлтийн төлөв байдлын өөрчлөлт: Монголын жишээ). Working Paper 2001-023. MPIDR.**

<http://www.demogr.mpg.de/Papers/Working/wp-2001-023.pdf>

Өгцүлэл, 25 хуудас, англи.

*Түлхүүр үгс:* Төрөлт, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт

*JEL:* J12, I00, P20

Энэхүү ажилд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүд нь сүүлийн үеийн төрөлтийн хандлагад хэрхэн нөлөөлснийг эконометрик үнэлгээний аргаар судалжээ. Судалгаанд 1998 онд хийгдсэн Нөхөн үржихүйн эрүүл мэндийн түүвэр судалгааны тоон өгөгдлүүдийг ашигласан байна. Эдийн засгийн үйл ажиллагаа нь ахимаг насныхныг бодвол залуучуудад илүү хүчтэй нөлөөлж байна гэж дүгнэжээ.

Энэ судалгааны үр дүнд сүүлийн 10 гаруй жилд өрнөсөн Монгол Улсын нийгэм-эдийн засгийн өөрчлөлт нь төрөлтөд нөлөөлж буйг эконометрик үнэлгээний аргаар судалж, сонирхолтой дүгнэлт хийжээ. Эдийн засгийн уналтад хүн амын цэцэглж буй хариу үйлдлүүдийн нэг нь төрөлтийн түвшний бууралт гэж зарим судлаачид үздэг. Энэхүү ажил нь энэ санааг эмпирик судалгаагаар зарим талаар баталснаараа ач холбогдолтой.

## 121

Английн Хүүхдийг Ивээх Сан (Save The Children UK). (2000). **Country Strategic Plan: Mongolia 2000-2004 (Монгол Улсын стратеги төлөвлөгөө: 2000-2004).**

[http://www.opensocietyforum.mn/res\\_mat/Country%20Strategic%20Plan.pdf](http://www.opensocietyforum.mn/res_mat/Country%20Strategic%20Plan.pdf)

Баримт бичиг, 15 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Хүүхэд, ядуурал

*JEL:* I30

Энэхүү баримт бичигт Монголын хүүхдүүдэд тулгардаг бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлж 2000-2004 онд Монголд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ. Ядуурал, боловсрол, эрүүл мэнд, гэмт хэрэг, зөрчил, байгалийн гамшиг зэрэг олон хүчин зүйлс нь хүүхдүүдэд нөлөөлдөг байна.

Энэ баримт бичиг нь гадны донор байгууллагуудаас ядуурлыг бууруулахад чиглэсэн хэрэгжүүлж буй арга хэмжээ, тухайлан Английн хүүхдийг ивээх сангийн шугамаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх ач холбогдолтой.



## 122

Арбаркез, И. Ау, М., Николс, Д (Arbarquez, I. Au, M. & Nichols, D). (2000).  
Mongolia: The Hidden emergency (Монгол Улсад нүүрлэж буй далд аюул)

<http://www.reliefweb.int/library/documents/oxfamrep.pdf>

Судалгааны тайлан, 50 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, нэн ядуу, ужгирсан ядуурал, тогтвортой амьжиргаа, ядуурах эмзэг байдал

*JEL:* I30, I32

Уг судалгааны зорилго нь Монгол Улсын нийгэм эдийн засаг дахь далд нуугдмал бэрхшээлүүдийг тодорхойлон гаргаж, тэдгээрийг шийдвэрлэх талаар бодлогын зөвлөмж санал дэвшүүлэхэд оршино. Шилжилтийн үеийн Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлсон. Нийгэм, эдийн засгийн бэрхшээлүүд нь ядуурал гүнзгийрэхэд нөлөөлж байна гэж дүгнэсэн. Байгалийн гамшиг, сургууль завсардалт, нийгмийн суурь үйлчилгээг төрөөс хангах байдал буурсан зэрэг нь ядуу малчин өрхүүд гамшигт нэрвэгдэхэд нөлөөлж байгааг дурдсан. Oxfam Australia, Oxfam HongKong, Oxfam Great Britain зэрэг байгууллагуудаас гамшигийн эсрэг үзүүлж буй тусламжуудыг үнэлж цаашид үзүүлэх тусламж, үйлчилгээний талаар зөвлөмж гаргасан байна.

*Энэ судалгаа нь ядуу малчин өрхүүдийн гамшигт нэрвэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлсноор ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарвал зохих асуудлуудыг хөндсөн ач холбогдолтой зөвлөмжүүдийг багтаажээ.*

## 123

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (World Health Organization). WHO country co-operation strategy: Mongolia”. (ДЭМБ-ийн улс орны хамтын ажиллагааны стратеги: Монгол Улс). [http://www.who.int/country/en/cooperation\\_strategy\\_mng\\_en.pdf](http://www.who.int/country/en/cooperation_strategy_mng_en.pdf)

Өгцлэл, 34 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, Засгийн газрын зардал, эрүүл мэнд

*JEL:* I30, H51

Энэ өгүүллийн зорилго нь Монгол Улсын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн салбарт оруулж буй зээл тусламжийн хувь нэмэр, ДЭМБ-аас Монголд хийгдсэн гол ажлууд, тэдгээрийн үнэлгээ, дараагийн таван жил ДЭМБ-аас хэрэгжүүлэх бодлого зэргийг тодорхой харуулахыг зорьсон. Эрүүл мэнд ба хөгжлийн асуудлууд гэсэн бүлэгт Монгол Улсын шилжилтийн үеийн эдийн засаг, хүн ам, засгийн газрын үйл ажиллагаа, эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн салбарын хөгжил, яаралтай тусламж үүсч болох нөхцлүүдийг дурьдсан. Дараагийн хэсэгт, Монгол Улсын эрүүл мэндийн салбарт олон улсын байгууллагуудаас үзүүлж байгаа тусламж дэмжлэгийг судалсан байна. Дөрөвдүгээр хэсэгт ДЭМБ-аас онцлон анхаарч буй гол чиглэлүүд, санхүүжилтийн зарцуулалтыг нэр төрлөөр үзүүлж, хүний нөөцийн асуудал, түүний үнэлгээг харуулсан. Тавдугаар хэсэгт ДЭМБ-аас глобал болон бүс нутгийн хүрээнд хэрэгжүүлдэг бодлогыг дэлгэрэнгүй үзүүлжээ. Зургаадугаар хэсэгт Монгол Улсад дараагийн 5 жилд

хэрэгжүүлэх стратегийн зорилго, үйл ажиллагааг авч үзсэн байна. Энд ядуурал нь эрүүл мэндийн байдлыг тодорхойлогч чухал хүчин зүйлүүдийн нэг гэдгийг дурьдсан байна.

*ДЭМБ-аас хэрэгжүүлж байгаа цйл ажиллагаанаас гадна Монгол Улсын эрүүл мэндийн асуудлууд, уг салбарт гадны донор байгууллагуудаас үзүүлж буй тусламжийг дэлгэрэнгүй авч үзжээ. Иймд нэг эх үүсвэрээр эрүүл мэндийн салбарт хийгдэж байгаа цйл ажиллагааны талаар ойлголт авах боломж олгож байна.*

## 124

**Жанес, С. Р (Janes, C. R). (2003). Contextualizing equity in global health reform: The case of post-socialist Mongolia (Глобаль эрүүл мэндийн шинэчлэл дэх тэгш байдал: социализмын дараах үеийн Монгол Улсын жишээ),**

<http://carbon.cudenver.edu/~cjanes/AAA%2003%20paper%2011-9-03.pdf>

*Судалгааны тайлан, 15 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, нийгмийн хангамж, тэгш бус хүртээмж, эмзэг байдал

*JEL:* I30, H55

Уг судалгааны зорилго нь социализмын дараах үеийн Монголд орон нутгийн түвшинд эрүүл мэндийн шинэчлэл өөрчлөлт, тэгш байдал, эдийн засгийн үр ашиг хэрхэн хэрэгжиж байгааг судлах юм. Эрүүл мэндийн салбарт хийгдсэн өөрчлөлт шинэчлэл зайлшгүй байсан, үүний үр дүнд эрүүл мэндийн хүртээмжид үүссэн тэгш бус байдлыг судалсан. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, даатгалын нөхөн төлбөрийн зардал хангалтгүй байдгаас шалтгаалж ядуу өрхүүдийн хувьд тэгш бус хүртээмж, эрүүл мэндийн тэгш бус байдлын асуудлууд гарч ирж байна гэж дүгнэжээ.

*Бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид ашиглахад илүү тохиромжтой. Эрүүл мэндийн салбарын өөрчлөлт шинэчлэл, хувьчлал нь нийгмийн янз бүрийн бүлгүүдэд хэрхэн нөлөөлж байгааг оролцооны аргаар судлан харуулсан. Эрүүл мэндийн тэгш бус байдал хүртээмж бий болж, энэ нь ядууралд нөлөөлснийг судалснаараа их ач холбогдолтой юм.*

## 125

**Кратли, С. (Krdtli, S). (2000). Education provision to nomadic pastoralists-a literature review (Нүүдлийн малчдад зориулсан боловсролын хангамж).**

<http://www.ids.ac.uk/ids/env/PDFs/NomEdu.pdf>

*Судалгааны тайлан, 75 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* малчид, нүүдэлчид, боловсрол, ядуурал

*JEL:* I30, I20

Уг судалгаа нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчдын боловсрол, түүний онцлог, өвөрмөц асуудлыг онол, практикийн талаас иж бүрэн шинжилсэн өргөн хүрээтэй ажил юм. Энэхүү тайлан 2 хэсгээс бүрдэж байна. 1-р хэсэгт нүүдэлчин малчид Ази, Африкийн улс орнуудын хүн амд

өндөр хувь эзэлдгийг тэмдэглэн тэдэнд зориулсан боловсролын нийтлэг асуудал, тулгарч буй бэрхшээлүүдийг дурдсан. Нүүдэлчин малчдыг хөгжүүлэх, тэдний ядуурлыг бууруулахад боловсрол улам бүр ач холбогдолтой болж байгаа боловч нүүдлийн мал аж ахуй зонхилдог бүс нутагт боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд тулгардаг хэд хэдэн өвөрмөц хүчин зүйлүүд байдаг. Нүүдлийн мал аж ахуй давамгайлсан газрууд ихэвчлэн хүн амын нягтрал багатай, хөгжлийн төвүүдээс алслагдсан, дэд бүтэц хөгжөөгүй байдаг нь боловсролыг хөгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Гэтэл Монгол Улсад 1960-1990 онуудад нүүдлийн мал аж ахуй бүхий бүс нутгуудад боловсролыг амжилттай хөгжүүлж чадсан гэж судлаач дүгнэж судалгааны 2-р хэсэгтээ Монгол Улсад малчдад зориулан бий болсон боловсролын тогтолцоог гүнзгийрүүлэн шинжилж, судалгааны тусгай жишээ болгон авч үзсэн байна. Зарим орнууд мал аж ахуйг ирээдүйгүй, аж ахуйн хоцрогдсон арга гэж төсөөлдөг боловч Монгол Улсад нүүдлийн мал аж ахуйг боловсролтой оновчтой холбон хөгжүүлж чадсан гэж дүгнэжээ. Судалгаанд Монгол Улсад социализмын үеийн малчдын хүүхдүүдэд зориулан бий болгосон боловсролын тогтолцоог судалж, 1990 оноос хойших хөдөө орон нутагт тодорхой хугацаанд ажиглагдсан малчдын хүүхдүүдийн сургууль завсардалтыг бас судалж үзсэн байна.

*Уг тайланд урьд нь дорвитой судлагдаж байгаагүй олон асуудлыг хөндөн тавьж, малчдын аж амьдрал, ядуурал, соёл нийгмийн хөгжилд боловсролын цэцэглэх нөлөө, алслагдсан орон нутагт боловсрол тцгээх янз бүрийн арга, нцүдэлчин өрхцүдийн хцүхдцүдэд боловсрол олгох тогтолцоонуудыг харьцуулан судалсан байна. Энэхүц тайлан нь Монгол Улсын туршлага, Монголд 2000 онд хийсэн судалгааны дцнг дэлгэрэнгүц танилцуулснаараа малчдын нийгэм, эдийн засгийн хөгжлийг судалж байгаа эрдэмтэн, судлаач нарт зориулсан онол, практикийн өндөр ач холбогдолтой судалгаа болсон байна.*

## 126

**Монгол Улсын Засгийн Газар (Government of Mongolia). (1994). Report on Mongolia's poverty alleviation meeting and NGO symposium (Ядуурлыг бууруулах тухай чуулган, засгийн газрын бус байгууллагуудын симпозиумын тайлан). Монгол, Улаанбаатар**

*Тайлан, 85 хуудас, англи*

*Түлхүүр цгс:* ядуурал, ядуурлыг бууруулах хөтөлбөр

*JEL:* I30, I38

1994 онд Улаанбаатар хотноо Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран бэлтгэсэн Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг 17 донор улс, 22 олон улсын байгууллагуудын төлөөлөгч нарт танилцуулсан. Энэ үеэр Монгол Улс дах засгийн газрын бус байгууллагуудыг дэмжих, үйл ажиллагааг нь сурталчлах зорилгоор засгийн газрын бус байгууллагуудын форумыг зохион байгуулж, засгийн газрын бус байгууллагууд ба ардчилсан нийгэм, Монгол дахь засгийн газрын бус байгууллагууд, засгийн газрын бус байгууллагуудын хууль зүйн орчин ба санхүүжүүлэлт гэсэн 3 сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэн, засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцсэн. Энэхүү тайланд Ядуурлыг бууруулах үйл ажиллагааны уулзалтын үеэр тавигдсан болон засгийн газрын бус байгууллагуудын хуралд тавигдсан илтгэлүүдийг эмхэтгэжээ. Ядуурлыг бууруулах тухай чуулганы үеэр Монгол

Улс дахь ядуурлын байдал, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зорилго, ач холбогдол, хэрэгжүүлэлтийн байдлыг хэлэлцсэн болно.

*Монгол Улсын ядуурлыг бууруулах хөтөлбөрийн үүсэл, хөгжил, шилжилтийн үеийн нийгэм-эдийн засгийн байдлыг сонирхон судалдаг эрдэмтдэд 1990 оны эхний хагасын байдлыг тоо, баримтаар харуулсан мэдээллээр баялаг тайлан болжээ.*

## 127

**Монгол Улсын Засгийн Газар ба НҮБ-ийн Төрөлжсөн Байгууллагууд. (Government of Mongolia and United Nations System). (1998). Memorandum of Understanding between The Government of Mongolia and the United Nations System on Youth Issues, May 1998-May 2001 (Залуучуудын асуудлаарх Монгол Улсын Засгийн Газар болон НҮБ-ын Төрөлжсөн Байгууллагуудын хоорондох ойлголцлын санамж бичиг 1998.05-2001.05). Монгол, Улаанбаатар. [http://www.un-mongolia.mn/reports/files/mou\\_youth.pdf](http://www.un-mongolia.mn/reports/files/mou_youth.pdf)**

*Баримт бичиг, 36 хуудас, англи, монгол*

*Түлхүүр үгс:* Ядуурал, залуучуудын асуудал, тогтвортой хөгжил

*JEL:* J13, I30

Энэ баримт бичиг нь Монгол улсын Засгийн Газар болон манай улс дахь НҮБ-ийн Төрөлжсөн Байгууллагуудын хамтарсан үйл ажиллагааны хүчин чармайлтын үр дүн юм. Энэ нь засгийн газрын тодорхойлсон “залуучууд” буюу 16-32 насны оршин суугчид, өөрөөр хэлбэл нийт хүн амын гуравны нэгд үйлчлэх бөгөөд тэдгээрийн хүндрэлтэй асуудлууд болох ажилгүйдэл, боловсрол, эрүүл аж төрөх ёс, хүрээлэн буй орчныг шийдвэрлэхэд нэн тэргүүнд бие дааж болон хамтран хийж гүйцэтгэх ажил, судалгаа шинжилгээ, хөтөлбөр төслийг тодорхойлсон албан ёсны баримт бичиг юм. Энэ тохиролцоо нь залуучуудын нэн тэргүүний ашиг сонирхлыг хөндсөн эдгээр асуудлуудыг хамтдаа шийдвэрлэх өргөн агуулгатай таван стратегийн чухал зорилгоос бүрдсэн. Эдгээр зорилтууд нь нийгэм-эдийн засаг, экологи-хүрээлэн буй орчин, тогтвортой хөгжлийн асуудлуудтай бүгд холбогдсон, хөгжлийн үндсэн асуудлууд учраас хоорондоо уялдаа холбоотой, харилцан бие биедээ нөлөөлж байдаг. Монгол Улсын аймагуудын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд залуучуудын ажилгүйдэл болон ядууралтай санхүүгийн үйл ажиллагаа, сургалт болон бусад арга хэрэгслээр тэмцэнэ гэж тодорхойлсон байдаг. Уг баримт бичигт энэ зорилтыг хэрэгжүүлэх дэд ажлуудыг дэлгэрэнгүй тодорхойлсон байна.

*Энэ баримт бичгээс дээр дурдсан хоёр талын тохиролцоо, хамтарч гүйцэтгэх үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олж авах боломжтой. Ялангуяа залуучуудын ажилгүйдэл, ядуурлын тухайн үеийн төлөв байдал, дээрх үйл ажиллагааг явуулах болсон шалтгаанууд, бусад хөгжлийн баримт бичигцд залуучуудын асуудалтай хэрхэн холбогдож байгааг мэдэж авах боломжтой. Мөн Залуучуудад зориулсан Үйл Ажиллагааны Дэлхийн Хөтөлбөрийн ерөнхий агуулга болон залуучуудтай холбоотой төрийн болон төрийн бус, НҮБ-ийн Төрөлжсөн Байгууллагууд, бусад олон улсын тусламжийн байгууллагуудын жагсаалт, холбогдож болох хүмүүсийн хаяг зэргийг агуулжээ. Залуучуудад учирч буй хүндрэлцүд, ялангуяа*

ажилгүйдэл, ядуурлыг авч үзснээрээ энэхүү баримт бичиг нь ач холбогдолтой юм.

## 128

**Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, Очирбат сан. (2000). Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал. Монгол, Улаанбаатар.**

**Government of Mongolia, UNDP, SIDA, Ochirbat Foundation. (2000). Human Security in Globalization. Ulaanbaatar, Mongolia**

*Эмхэтгэл, 295 хуудас, монгол, англи.*

*Түлхүүр үгс:* Глобальчлал, хүний аюулгүй байдал

*JEL:* H59

Энэхүү эмхэтгэл нь 2000 оны 5 сард зохион байгуулсан “Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал” сэдэвт Олон улсын бага хурлын илтгэлүүдийг багтаасан байна. Илтгэлүүд нь глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал, түүнд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйлсийг тодорхойлж, хүний аюулгүй байдлыг хангах тухай авч үзжээ. Энд хүний аюулгүй байдлын эдийн засаг, нийгэм, экологи, мэдээллийн асуудлуудыг судалсан байна. Түүнчлэн хүний болон үндэсний аюулгүй байдлын хамаарлыг авч үзжээ. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, орлогын хэмжээ бол ядууралтай холбоотой бөгөөд хүний аюулгүй байдлын амин чухал асуудал гэж тэмдэглэжээ.

*Эмхэтгэлд глобальчлал, хүний аюулгүй байдлын талаар гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачид, улс төрчдийн сонирхолтой олон илтгэлүүд оржээ. Эдгээр нь судлаачид, оюутнуудад гарын авлага болох төдийгүй олон нийтэд глобальчлал ба хүний аюулгүй байдлын талаар өргөн хүрээтэй ойлголт өгөхөд тус болох юм.*

## 129

**Монгол Улсын Засгийн Газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам. (2003).**

**Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг. Улаанбаатар.**

*Баримт бичиг, 87 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* ядуурал, нийгмийн халамж, нийгмийн даатгал

*JEL:* I30, I38

Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг нь тус салбарын урт хугацааны (10 жилийн) хөгжлийн ерөнхий чиглэл, ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэс болох бөгөөд нийгмийн халамж, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний дэд салбарын өнөөгийн тулгамдсан асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга зам, төсөв санхүүжилтэд үзүүлэх нөлөө, учирч болох эрсдэлүүдийг ерөнхийд нь тодорхойлон тусгасан байна. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегитэй нийцүүлэн боловсруулсан энэхүү баримт бичиг нь тус салбарын шинэчлэл, өөрчлөлтийн үндсэн чиглэл төдийгүй манай улсын хүн амд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байх болно гэж үзжээ.

Энэхүү стратегийн баримт бичиг нь нийгмийн хамгааллын салбарын асуудлыг сонирхогч судлаачид, оюутнууд, бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч болон олон нийтэд зориулагдсан. Түүнчлэн салбарын стратегийн талаар мэдээлэл авах боломжтой. Энд тухайн салбарт эдүгээ тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам, учирч болох бэрхиэлцүүдийг тодорхойлсон байна.

### 130

**Монгол Улсын Засгийн Газар (Government of Mongolia). (2002). National Programme of Action for the Development and Protection of Children 2002-2010 (Хүүхдийн хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр 2002-2010). Монгол, Улаанбаатар.**

<http://www.un-mongolia.mn/publication/files/UNICEFNPAEng.pdf>

Баримт бичиг, 48 хуудас, англи, монгол

*Түлхүүр үгс:* Хүүхдийн нийгмийн асуудлууд

*JEL:* J13

1989 онд НҮБ-аас Хүүхдийн эрхийн Конвенцийг батлан гаргаж, Хүүхдийн асуудлаарх Дэлхийн Чуулга уулзалт 1990 онд зохиогдсон. Энэ хурал нь хүүхдийн асуудлуудыг авч хэлэлцэн Хүүхдийн амьд явах, хамгаалал хөгжлийн дэлхийн Тунхаглалыг сайшаан баталсан. Монгол Улс энэ тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн анхны улсуудын нэг бөгөөд 1990 оноос Монгол Улсын Засгийн Газар Хүүхдийн хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж байгаа ба энэ хүрээнд НҮБ болон бусад доноруудын дэмжлэгтэйгээр хүүхэд, өсвөр насныханд учирч байдаг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулж ирсэн. Энэ баримт бичгийн үндсэн зарчим, зорилтууд, үйл ажиллагаанд хүүхэд, өсвөр насныханд нэн тэргүүнд хамааралтай ядуурлын асуудлуудыг хөндсөн байна. Үндсэн зорилт, хэрэгжүүлэх төсөл, хүлээгдэж буй үр дүнгүүдээр ядуурлын асуудлыг үнэлэн, тодорхойлж гаргасан байна.

*Уг баримт бичиг нь хүүхдийн асуудлаар төр, засгаас төлөвлөж буй ажил, зорилго, зорилт, хөтөлбөр, үйл ажиллагаануудад баримтлах ерөнхий зарчим, хүүхэд, өсвөр үеийнхний нийгмийн асуудлуудын ерөнхий мэдээллээр хангана.*

### 131

**Монгол Улсын Засгийн газар ба НҮБХХ. (2004). Монголын хүний хөгжлийн илтгэл 2003. Монгол, Улаанбаатар: “Мөнхийн үсэг” ХХК.**

**Government of Mongolia, UNDP. (2004). Mongolia Human Development Report 2003. Ulaanbaatar: “Munhiin Useg” Co Ltd.**

Илтгэл, 85 хуудас, монгол, англи.

*Түлхүүр үгс:* Хөгжил, Засаглал

*JEL:* O10, H00

Монголын хүний хөгжлийн илтгэл 2003 нь “Хот, хөдөөгийн ялгаатай байдал” сэдвээр бичигдсэн, 4 бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт, монголын хүний хөгжлийн түүхэн хандлага,

хүний хөгжлийн хэмжигдэхүүнүүдийг авч үзсэн байна. Хоёрдугаар бүлэгт, Монгол Улсад бий болоод буй орон зайн тэгш бус байдлыг хот, хөдөө гэсэн ангиллын хүрээнд судалсан байна. Гуравдугаар бүлэгт, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөд үзүүлж буй хүмүүсийн болоод засгийн газрын бодлогын хариу үйлдлийг авч үзжээ. Дөрөвдүгээр бүлэгт, хот хөдөөгийн ялгаатай байдлыг арилгахад тэргүүлэх ач холбогдол бүхий дөрвөн чиглэлийг тодорхойлжээ. Илтгэлд, сүүлийн жилүүдэд орлогын ядуурлыг бууруулахад дорвитой ахиц гараагүй, орлого хуваарилалт улам бүр тэгш бус болж, ядуурлын гүнзгийрэлт, тархалт буурахгүй байна гэж дүгнэжээ. Хот, хөдөөгийн амьдралын чанар илт ялгаатай болжээ. Хотын хүний хөгжлийн индекс (0.723) хөдөөгийнхөөс (0.636) 14 хувиар өндөр байна. Хот хөдөөгийн хүний хөгжлийн ялгааг бий болгож буй гол үзүүлэлтүүд нь боловсрол, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ юм. Хөдөөгийнхөн боловсрол, эрүүл мэнд, мэдээлэл, ажлын байрны хүртээмж, хүний хөгжлийн бусад боломжоор хотынхоос дутмаг байна. Хөдөө орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалт ч буурсан байна. Өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлыг багасгахдаа ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлтийг дэмжих, тэнцвэртэй хөгжлийг хангах, төвлөрлийг сааруулах, хөгжлийг санхүүжүүлэх гэсэн дөрвөн үндсэн чиглэлд онцгой анхаарах шаардлагатай гэж үзжээ.

*Монголын хүний хөгжлийн илтгэл 2003 нь нэгэнт бодитой болоод буй хот хөдөөгийн ялгааны асуудлыг анх удаа дорвитой хөндөж, шийдвэрлэх асуудал дэвшилцсэнээрээ ач холбогдолтой юм. Хот, хөдөөгийн ангилал нь бусад судалгаануудынхаас өөр байна. Түгнчлэн ядуурал, орлого хуваарилалт, өрхийн амьжиргаатай холбогдсон өргөн баялаг тоон мэдээлэл агуулсан нь судлаачид, оюутнууд цаашидын судалгаандаа хэрэглэх боломжтой юм. Илтгэлд дурьдсанаар, хот хөдөөгийн ялгаатай байдал нь ядуурал, орлогын ялгаатай шууд холбоотой байна. Харин судалгаанд хэрэглэсэн ядуурлын талаарх тоон мэдээлэл нь 1998 оноор хязгаарлагдаж буй нь 2003 онтой харьцуулахад нилээд хуучирсан байна. Нөгөө талаар 1999-2002 онд тохиолдсон ган зуд нь хөдөөгийн малчин өрхийн амьжиргаанд ихээхэн сөрөг нөлөөлж, ядуурлын тархалт 1998 оноос ихээхэн өөрчлөгдсөн байж болзошгүй талаар эрдэмтэд судлаачид ярьж, бичсээр байгаа. Эндээс цэвэр, хөдөөд ядуурал бага байгаа тухай дүгнэлт нь бодит байдалтай зөрчилдөж байж болзошгүй.*

## 132

**Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (Open Society Institute). (2003). Mongolia country gender assessment (Монгол улсын жендэрийн үнэлгээ).**

[http://www.opensocietyforum.mn/res\\_mat/mongolia%20Country%20Gender%20Assessment%20May%20%20Emma%20Hooper%20WB1.pdf](http://www.opensocietyforum.mn/res_mat/mongolia%20Country%20Gender%20Assessment%20May%20%20Emma%20Hooper%20WB1.pdf)

*Тайлан, 23 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* жендэр

*JEL:* J16

Энэ тайланд Монгол Улсын жендэрийн ерөнхий дүр төрхийг авч үзсэн. Монгол Улс нь жендэрийн харьцангуй тэгш, эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгмийн үйлчилгээг хүртэх боломж нь

ижил байдаг. НҮБХХ-ийн Жендэрийн хөгжлийн индексээр Монгол Улс 95-рт байгаа бөгөөд хүний хөгжлийн жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлтээр дундаас доогуур ангилалд ордог. Нийт хүн амын гуравны нэг нь ядуу байгаа бөгөөд эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд илүү эмзэг, илүү ядуу байдалтай байна. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харвал эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн хувьд хотын 47,1%, хөдөөгийн 36,1% нь ядуу байна гэжээ.

*Энэ тайлан нь статистикийн тоо баримтад тулгуурлан, харьцуулан дүгнэлт хийх хэлбэрээр бичигдсэн, Монгол Улсын жендэрийн асуудлыг эмх цэгцтэй олон талаас нь судалсан ач холбогдолтой ажил болжээ. Статистикийн тоо баримтыг олноор агуулсан, жендэрийн асуудлыг сонирхон судалж буй хүмүүс ашиглах боломжтой ажил юм.*

### 133

**МУИС, Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв. (2001). Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000. Монгол, Улаанбаатар. NUM, Population Teaching and Research Center. (2001). A Micro Study of Internal Migration in Mongolia. Mongolia, Ulaanbaatar.**

*Судалгааны тайлан, 119 ба 117 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* Шилжих хөдөлгөөн, хүн ам

*JEL:* O15, J10

Энэ бүтээл нь Монгол Улсын хүн амын байршил, шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн болон хүн ам зүйн хүчин зүйлсийг судалж, хүн ам зүйн ачаалал, нөхөн үржихүйн нөөц, суурьших хэрэгцээг харгалзан хүн амын нутагшлын зохистой бүтцийг бүрдүүлэх, шилжих хөдөлгөөнийг төрөөс зохицуулахад эдийн засаг, нийгэм, эрх зүйн үндсийг боловсруулах суурь судалгааны мэдээлэл цуглуулах зорилгоор 2000 онд хийгдсэн түүвэр судалгааны тайлан юм. Олон шатлал бүхий санамсаргүй түүврийн аргаар судалгааг явуулсан байна. Судалгааны тайлан нь оршил, судалгааны зохион байгуулалт, шилжигчдийн ерөнхий шинж, шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлс, уугуул нутгийн хүн амын шилжилтийн төлөв байдал, шилжин суурьшсан нутгууд дахь шилжих хөдөлгөөний үр дагавар, зохицуулалт, дүгнэлт, зөвлөмж гэсэн 7 бүлгээс бүрдэнэ. Судалгаагаар шилжигчдийн ихэнх хувь нь залуучууд, боловсролын түвшин багатай хүмүүс байна. Шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амтай харьцуулахад шилжин ирэгчдийн өрхийн ахуй нөхцөл муу, ихэвчлэн ажил эрхлэх, зах зээлд ойртох, амьдралын нөхцөл байдлаа сайжруулах, үр хүүхдийнхээ ирээдүйг бодох, төрөл саднаа бараадах, суралцах зэрэг шалтгаанаар шилжих хөдөлгөөнд оролцдог байна. Шилжин ирэгчдийн шилжин ирснээс хойшхи эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал муу байна гэж дүгнэжээ.

*Энэхүү тайланд түүвэр судалгаагаар цуглуулсан мэдээллийг нэгтгэн, монголын дотоод шилжих хөдөлгөөн, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс, тулгарч буй бэрхшээлцүүдийг олон талаас нь шинжилжээ. Судалгаа, судалгааны тайлан нь монголын дотоод шилжих хөдөлгөөний талаар маш нарийн тоон мэдээллийг агуулсан, өрхийн амьжиргаанд гарч буй өөрчлөлт, шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан, монголын*



ядуурлын талаарх цаашдын судалгаа шинжилгээнд ашиглах боломжтой. Тайлан нь цуглуулсан тоон мэдээллийг нарийн шинжилж, түүний үндсэн дээр үнэлэлт дүгнэлт хийжээ. Харин түүврийн төлөөллийн талаар мэдээлэл өгөөгүй байна.

### 134

**Намжим, Т., Итгэл, Н. (2003). Нийгмийн хөгжлийн асуудалд. Монгол, Улаанбаатар**

*Номын бэлэг, 11 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* амжиргааны түвшин, ажилгүйдэл, ядуурал, мөнгөн орлого

*JEL:* I30, I30, E24, D31

Хүн амын амьжиргааны түвшний тухай энгийн ойлголт өгөх, Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшин, түүнийг дээшлүүлэх арга замын талаар мэдээлэл өгөх зорилготой. Асуудлыг бататгах зорилгоор статистикийн тоо, мэдээлэл ашиглаж хүн амын амьжиргааны түвшний өнөөгийн байдлыг харуулсан байна. Хүн амын амьжиргааны түвшинг мөнгөн орлогоор хэмжих, илэрхийлэх арга зүйг танилцуулжээ. Нийгмийн хөгжлийг хүний хөгжлөөр төлөөлүүлэн авч үзсэн байна.

*Хүн амын амьжиргааны түвшний тухай ойлголтыг олон нийтэд зориулан энгийн байдлаар тайлбарласнаараа онцлог болжээ. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж иргэдийн амьжиргааг дээшлүүлэхийн чухлыг товчлолгон харуулснаараа ач холбогдолтой болжээ.*

### 135

**НҮБ-ийн Төлөөлөгчийн Газар (UN Mongolia). (1999). Overview of Relevant United Nations Agencies and Activities for Food Security and Nutrition 1998-1999. (Хүнсний аюулгүй байдал ба хүнс тэжээлийн хангамжид холбоотой НҮБ-ийн Агентлагууд болон тэдгээрийн үйл ажиллагааны тодорхойлолт 1998-1999). Монгол, Улаанбаатар.**

[http://www.un-mongolia.mn/reports/files/mou\\_food\\_annex.pdf](http://www.un-mongolia.mn/reports/files/mou_food_annex.pdf)

*Товхимол, 21 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Хүнсний аюулгүй байдал, ядуурал, ядуурлыг бууруулах стратеги

*JEL:* I12, I30, I38

Энэхүү танилцуулгын зорилго нь Монгол Улсад хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хангамжийг сайжруулах чиглэлээр ажилладаг НҮБ-ийн бие даасан байгууллагуудыг танилцуулан, 1998-1999 оны хооронд хийсэн олон талт үйл ажиллагаа, ялангуяа бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, төсөл, хамтран болон дагалдуулж хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл зэргийг дэлгэрэнгүй танилцуулсан байна. Хүнс, хоол тэжээлийн хангамж, аюулгүй байдал нь нийгмийн хөгжлийн тулгамдсан бөгөөд ядууралтай салшгүй шууд холбогдож байдаг эмзэг, дангаараа бие даан шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлуудын нэг байдаг. Энэ харилцан хамаарал манай улсад ажиглагдаж хүнсний аюулгүй байдлын бодлого ядуурлын бодлоготой холбогдож байна. Энэ ажлаас эдгээр байгууллагуудаас зохион байгуулсан олон улсын Хурал, Чуулган, хүнсний аюулгүй байдлын бодлоготой холбоотой үндэсний төсөл, хөтөлбөрүүд, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг олон

улсын төрөл бүрийн бусад байгууллагуудын гүйцэтгэсэн ажил, төслүүдтэй танилцах боломжтой.

*Уг товхимол нь хүнсний аюулгүй байдлын чиглэлээр манай улсад үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааны талаар өргөн хүрээтэй мэдээлэл, хүнсний аюулгүй байдлын бодлогыг ядуурлын бодлоготой хэрхэн холбож, ямар төсөл, хөтөлбөрөөр хаана хэрэгжүүлснийг олж авах боломжийг өгч байгаагаараа ач холбогдолтой юм.*

### 136

**НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (UNDP Mongolia). (2000). Gender Briefing Kit (Жендерийн товч хэрэглэгдэхүүнүүд). Монгол, Улаанбаатар.**

<http://www.un-mongolia.mn/publication/files/gbk.pdf>

*Товхимол, 43 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Жендер, жендерийн динамик, шинжилгээ, ядуурал

*JEL:* J16, I30

Энэ товхимолын зорилго нь НҮБХХ-ийн албан хаагчид, зөвлөхүүд, Монголын нөхцөл дэх эмэгтэйчүүд, жендерийн талаарх асуудлын хөгжилд оролцож байдаг бусад оролцогчдыг таницуулах явдал юм. Нэгдүгээрт, Монгол дахь эмэгтэйчүүд, жендерийн гол гол асуудлуудыг хууль зүйн орчин, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих засгийн газрын бодлого, улс орны шилжилтийн болон жендерийн динамик гэсэн сэдвүүдээр тодорхойлсон. Хоёрдугаарт, Засгийн Газар, судалгаа, төрийн бус байгууллага, Жендер ба Хөгжил (GAD)/Хөгжил дэх Эмэгтэйчүүд (WID)-ийн чиглэлээр донорын үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудад ажилладаг холбогдох хүмүүсийн нэр, хаягийг тодруулж өгсөн. Эцэст нь, жендерийн шинжилгээг хариуцан хийх мэргэжилтнийг хөгжүүлэхэд туслах хэд хэдэн арга, хэрэгслийг тодорхойлжээ. Уг ажлын Монгол дахь Жендерийн Динамик гэсэн 5-р хэсэгт эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдал, ажилгүйдэл ядуурал, түүний эсрэг үзүүлж буй хариу үйлдлүүд, амьдралын чанарын доройтол, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөв байдал зэргийг авч үзэн, сэдэв тус бүрээр дүгнэлт хийн, харилцаж болох хүмүүс, уншиж, ашиглах нэмэлт материалуудыг зааж өгсөн байна.

*Уг товхимол нь нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлын нэг болох жендер гэсэн ойлголт, бусад асуудлуудтай хэрхэн холбогддогийг онолын талаас нь тодорхойлон, Монгол Улсын өнөөгийн нөхцөл ямар төлөв байдалтай байгааг, тэр дундаа ядуурлын асуудлуудтай хэрхэн холбогдож буйг авч үзснээрээ ач холбогдолтой юм. Мөн манай улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын донор байгууллагуудаас энэ чиглэлээр хийж буй ажил, үзүүлж буй тусламж, үйл ажиллагааг нэгтгэн, эмэгтэйчүүд, жендерийн асуудлуудтай холбогдох албан ёсны тоон мэдээллийг багтааж өгснөөрөө илүү ач холбогдолтой юм. Иймээс энэ танилцуулга нь жендерийн асуудал, жендерийн шинжилгээ, дианамикийг илүү сайн ойлгохыг хүссэн хүн бүрт баялаг мэдээлэлтэй сан болж чадна.*

137

**НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (UNDP Mongolia). (2000). Survey Report on NGO Implemented Assistance in Social Sector of Mongolia, Conducted jointly by Consulting & Business Centre, Academy of Management; Gender Centre for Sustainable Development; Consulting Unit zbn (Монгол Улсын нийгмийн секторт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагуудын түүвэр судалгааны тайлан, Менежментийн академийн зөвлөгөө өгөх бизнес төв, Тогтвортой хөгжлийн жендэр төв, “zbn” зөвлөгөө өгөх нэгжтэй хамтарсан судалгаа). Монгол, Улаанбаатар.**

[http://www.un-mongolia.mn/reports/files/NGO\\_final\\_report\\_english.pdf](http://www.un-mongolia.mn/reports/files/NGO_final_report_english.pdf)

Тайлан, 24 хуудас, англи

*Түлхүүр цгс:* Ядуурлыг бууруулах

*JEL:* I38

Монголд Хандивлагчдын VII Уулзалтанд оролцогчид нийгмийн секторын хөгжилд Төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн оролцооны түвшинг тодорхойлох шаардлагатай юм гэж тохирсон. Энэ тохиролцоо нь уг уулзалтын үеэр Монголын нийгмийн секторт үзүүлэх боломжтой тусламжийн хувьд онцгой чухал хэлэлцүүлэг байсан. Уг түүвэр судалгаа нь дээрх үндэслэлээр хоёр талын болон олон талт хамтын ажиллагаагаар хэрэгжсэн төслүүдийн үр дүнг шинжлэх, адил чиг үүрэг бүхий төслүүдийн цаашдын эрэлтийг үнэлэхэд чиглэгдэж байгаа юм. Энэхүү судалгаанд тодорхой 4 шалгуураар тодруулсан дотоодын 90, донор улсууд, олон улсын байгууллагуудыг төлөөлсөн 10 ТББ-ыг хамруулсан байна. Тухайн судалгаа Ядууралтай асуудалтай холбогдсон асуудлаар ТББ-уудаас хэрэгжүүлсэн төслүүд ихэвчлэн нийгмийн асуудлуудтай, тэр дундаа нийгмийн хүндрэлтэй асуудлууд болох эмзэг бүлгийнхэнд туслах, ядуурал, ажилгүйдлийг бууруулах зэрэгт чиглэгдсэн байдаг. Монгол Улсад байнгын үйл ажиллагаа явуулдаг 8 донор байгууллагын санхүүжилтээр 1996-2000 онуудын хооронд нийт 170 төсөл хэрэгжсэний 14 нь ядуурлыг бууруулах, 77 нь боловсрол, эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн зэрэг үр дүн, дүгнэлт гаргасан байна.

*Уг тайлангаас ТББ-уудын үйл ажиллагаа, тэдгээрийн санхүүжилт, зарлага орлого, хөрөнгийн бааз суурь зэрэг мэдээллээс гадна тэдгээрийн үйл ажиллагаа нь төрийн бодлого, хөтөлбөрцүдтэй хэрхэн уялдаж, хамтран явагддагийг мэдэх боломжтой. 1996-2000 онуудын хооронд ТББ-ын шугамаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрцүдийн төлөвлөлт, хэрэгжилт, цр дүнтэй холбоотой статистик тоон мэдээлэл, цаашид хамтран ажиллах санал, зөвлөмжтэй танилцах ач холбогдолтой. ТББ-ууд ядуурлын асуудал дээр ЗГ болон олон улсын байгууллагуудтай түлхүү хамтран ажилладаг нь энэхүү судалгааны цр дүнгээс тодорхой байна.*

138

**НҮБ-ын Суурин Төлөөлөгчийн Газар (UN Resident Coordinator's Office, Mongolia). (2000). 1999 Annual Report: UN System in Mongolia (1999 оны жилийн тайлан: Монгол Улс дахь НҮБ-ын систем, I хэсэг).**

**<http://www.un-mongolia.mn/reports/files/anrep99.pdf>**

Тайлан, 23 хуудас, англи

*Түлхүүр үгс:* ядуурал, иргэний нийгэм, хувийн сектор

*JEL:* I30

Энэхүү тайлан нь НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргад Монгол Улс дахь Суурин Төлөөлөгчийн газраас тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тухай юм. Энэ тайланг манай улсад ажиллаж байгаа НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын хамтарсан үйл ажиллагааны дүнгээр бэлтгэсэн. Үндэсний хөгжлийн зорилтууд болон нэн тэргүүнд тулгарч буй асуудлуудыг шийдэрлэхэд НҮБ-ын хамтран ажиллах үйл ажиллагаанд ядуурлыг бууруулах, энэ тал дээр олон улсын эдийн засаг, санхүүгийн бусад байгууллагууд, иргэний нийгэм, хувийн сектортой НҮБ хамтран ажилласан болон цаашид ажиллах талаар өгүүлжээ.

*Уг тайлан нь нийгэм-эдийн засгийн янз бүрийн судалгааны цр дүнд үндэслэн бичигджээ. Олон нийтэд зориулагдсан учраас сонирхсон хүн бүр ашиглах боломжтой юм. Ядуурлын асуудалд НҮБ-ын системийн байгууллагууд хэрхэн тусалж байгаа, тэдний үзгээс баримталж буй бодлого, цйл ажиллагааг мэдэх ач холбогдолтой. Үүнээс гадна манай оюутан, эрдэмтэн судлаач нарт судалгааны ажлын тайлан бичихэд нь ямар нэгэн байдлаар цлгэр дуурайл болохуйц, бүтэц, агуулга, үндэслэл сайтай ажил юм.*

139

***НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр ба UNIFEM. Монголын хөдөө дэх жендерийн дүр зураг: Бодлогод тусгах тоо баримт, мэдээллүүд. Монгол, Улаанбаатар.***

Судалгааны тайлан, 158 хуудас, монгол

*Түлхүүр үгс:* жендэр

*JEL:* J16

Уг тайлангийн 6-р бүлэг Хөдөөгийн ядуурал, тэгш бус байдлын жендерийн онцлог гэсэн хэсэгт ядуурал гэж юу болох, ямар төрлийн ядуурлууд байдгийг дурдаад Монгол дахь ядуурлыг тал бүрээс нь тодорхойлох зорилго тавин жендерийн мэдрэмжтэй бодлого боловсруулахад хэрхэн анхаарал хандуулах, юуг гол болгон авч үзэх талаар тодорхой тусгажээ. Олонхи ном хэвлэлүүдэд орлогын ядуурлыг гол болгон авч үздэг бол энэ судалгаанд орлогын ядуурлаас гадна чадавхийн ядуурал, нийгмийн хязгаарлалтын ядуурлыг хөндсөн нь сонирхолтой болжээ. Энэхүү судалгааны онцлог нь ядуурал болон тэгш бус байдалд үзүүлэх жендерийн нөлөөг харуулахыг зорьсон анхны судалгаануудын нэг юм. Энд эрүүл мэнд, боловсролын салбарт анхаарвал зохих асуудлуудыг ядууралтай холбон авч үзэж, хөдөөгийн секторыг жендерийн мэдрэмжтэй бодлогод тусгах чиглэлийг тодорхойлжээ.

Жендерийн мэдрэмжтэй дүн шинжилгээгээр хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн өмнө тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг заажээ. Тухайлбал, ядуурлыг бууруулах зорилгоор эрцл мэнд, боловсролын салбарт хэрэгжүүлэх шаардлагатай ажил үйлчилгээг тодруулж авч үзсэн нь эдгээр салбаруудад ажиллаж байгаа удирдах ажилтан, бодлого боловсруулагчдад чухал мэдээлэл болохоор байна.

#### 140

**Олон Улсын Улаан Загалмайн Нийгэмлэг (International Federation of Red Cross), Улаан Хавирган Сар Нийгэмлэг (Red Crescent Society). (2002). “Mongolia”. (Монгол Улс). [http://www.reliefweb.int/...](http://www.reliefweb.int/)**

Тайлан, 19 хуудас, англи

*Түлхүүр цгс:* Ядуурал, хөдөө аж ахуй

*JEL:* Q10, I30

Монголын шилжилт нь ажилгүйдэл, ядуурлыг өсгөж, баян ядуугийн ялгааг улам нэмэгдүүлсэн. Ядуурлаас гадна гурван жил нүүрлэсэн байгалийн гамшиг, тухайлбал өвөл нь зуд, зун нь ган болсон нь хүмүүст маш эмзэгээр туссан. Байгалийн гамшгаар маш олон малчид амьжиргаагаа залгуулах малгүй болсон. Монголын улаан загалмайн нийгэмлэг олон улсын холбооны дэмжлэгтэйгээр бүх малаа эсвэл ихэнх малаасаа хагацсан өрхүүдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн тухай дурджээ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгсөн байна. Мөн сүүлийн 2-3 жилд Монголын улаан загалмайн нийгэмлэгээс хийж гүйцэтгэсэн ажлуудыг танилцуулж, үйл ажиллагаагаа олон нийтэд мэдээлснээрээ ач холбогдолтой болжээ.

#### 141

**Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (IDA), Дэлхийн банк (World Bank). (1996). Poverty alleviation for vulnerable groups project, IDA review mission (Монгол Улс: эмзэг бүлгийнхний ядуурлыг бууруулах төслийн хэрэгжилтийн үнэлгээ)**

Тайлан, 8 хуудас, англи

*Түлхүүр цгс:* Ядуурал, ядуурлыг бууруулах хөтөлбөр,

*JEL:* I30, I38

Монгол Улсад ядуурлыг бууруулах бодлогыг 1990-ээд оны эхээс явуулж эхэлсэн бөгөөд уг тайлан ядуурлыг бууруулах анхны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, арга барил, үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгасан. Олон Улсын Хөгжлийн Ассоциациас Монголд хэрэгжүүлж байсан эмзэг бүлгийнхний ядуурлыг бууруулах төслийн үйл ажиллагааг үнэлэх, Монгол Улсын ядуурлыг бууруулах үндэсний семинарт оролцох зорилгоор 1996 онд Монгол Улсад ирсэн судалгааны багийн тайлан юм. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 1996 онд 1.3 сая ам долларын хөрөнгийг зарцуулж, орлого нэмэгдүүлэх эмзэг бүлгийн 245 байгууллага, эрүүл мэндийн 18, боловсролын 12 төслийн үйл ажиллагааг санхүүжүүлсэн. Судалгааны багаас

энэ үйл ажиллагааны явц, хөтөлбөрийн үр дүн, өгөөжийг шинжилсэн.

Уг тайланд эмзэг бцлгийнхны орлого нэмэгдүүлэх байгууллагуудын цйл ажиллагааг судалж, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн цйл ажиллагааг боловсронгуй болгох талаар зөвлөгөө өгсөн. Ядуурлыг бууруулах бодлого, түүний хэрэгжилтийг судалдаг судлаач, бодлого боловсруулагчид ашиглах боломжтой, Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн шилжилт, ядуурлыг бууруулах бодлогын тухай мэдээлэл, статистикийн тоо баримт агуулсан судалгааны ажил болсон.

## 142

**Робинзон,Б. Солонго,А. (1999). “Шилжилтийн нөхцөл дэх жендерийн асуудалд”. Монголын эдийн засаг: Шилжилтийн эдийн засгийн гарын авлага. х 326-361.**

*Номын бцлэг, 12 бцлэг, 35 хуудас, монгол*

**Robinson,B. Solongo,A. (2000). “The Gender Dimension of Economic Transition in Mongolia”. The Mongolian Economy: A Manual of Applied Economics for a Country in Transition. Edward Elgar хэвлэлийн газар. 2000. х 231-255.**

*Номын бцлэг, 12 бцлэг, 26 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, хүйсийн тэгш байдал

*JEL:* I30, J16

Энэ бүтээлд хөдөлмөрийн талбарт эрэгтэйчүүд, нөхөн үйлдвэрлэлд эмэгтэйчүүд голлох үүрэг гүйцэтгэж байгаагаас эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн орлогын ялгаа үүсэх, нийгмийн үйлчилгээнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэгш бус хамрагдах нөхцлийг бүрдүүлж байна. Хөдөлмөрийн хуваарилалтыг ингэж зохицуулснаар эмэгтэйчүүдийн үнэгүй ачааллыг нэмэгдүүлж байна гэж үзжээ. Шилжилтийн өмнөх үеийн Монголын эмэгтэйчүүдийн байдлыг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн идэвх, ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзсэн байна. Жижиг, дунд үйлдвэрийн эздийн гуравны нэг нь эмэгтэйчүүд бөгөөд жижиг үйлдвэрүүдийн хувьд эмэгтэй эздийн эзлэх хувийн жин нэмэгдэж, пүүс компани томрох тусам энэ үзүүлэлт буурч байна. Албан бус секторт эмэгтэйчүүд цөөнгүй оролцож байгаа бөгөөд энэ талаарх мэдээлэл хомс юм. Мөн өмч хувьчлалын үр өгөөжийг эмэгтэйчүүдийн зүгээс эрэгтэйчүүдээс бага хүртэж байна гэх мэтчлэн эмэгтэйчүүдийн асуудлыг тал бүрээс нь авч үзжээ. Жендер болон ядуурлын асуудлыг авч үзэхдээ, ядууралд өртөмтгий эмзэг хэсэг нь өнчин хүүхдүүд, эмэгтэй өрхийн тэргүүнтэй гэр бүл, ажилгүйчүүд, хөдөөгийн малгүй өрхүүд гэжээ. Эмэгтэй өрхийн тэргүүнтэй нийт өрхийн тал хувь нь ядуу байна. Үүний нэг шалтгаан нь цомхотголоор ихэвчлэн эмэгтэйчүүд ажилгүй болдог явдал юм. Хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн ажлын ачаалал нэмэгдэж, эмэгтэйчүүд хувиараа аж ахуй эрхлэх, зээл авах боломж хязгаарлагдмал, эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх ядууралд өртөмтгий, шилжилтийн үеийн үнэт зүйлс, боломжийг тэгш бус хүртэж байна гэж дүгнэжээ.

Энэхүү ажилд шилжилтийн цед тулгарч байгаа жендерийн асуудлуудыг ялангуяа эмэгтэйчүүдийн асуудлыг нэлээд өргөн хүрээг хамруулан судалсан байна. Тухайлбал, нийгэмд

эзэлж буй эмэгтэйчүүдийн байр суурь, эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн байдлыг нарийвчлан авч үзжээ. Түгнчлэн судалгаандаа статистикийн баялаг тоо баримтыг хавсаргасан нь судлаачид, оюутнуудад хэрэг болохуйц мэдээллээ авч ашиглах боломж олгосноороо ач холбогдолтой болжээ. Монгол Улсын шилжилтийн үеийн жендерийн асуудлыг сонирхон судалж буй бүх хүмүүст зориулж уг ажлыг бичсэн байна.

#### 143

**Саббаро, К. (Subbarao, K.) & Эземенари, К. (Ezemenari, K.). (1994). Transition, poverty and social assistance in Mongolia (Шилжилт, ядуурал ба Монгол Улс дахь нийгмийн тусламж).**

Өгцлэл, 19 хуудас, англи

*Түлхүүр үгс:* ядуурал, эмзэг бүлэг, шилжилт

*JEL:* I31, I32, P20

Энэхүү өгүүлэл нь 1990 оноос Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг амжилттай хийсэн боловч шилжилтийн үр дүнд ядуу өрхүүд олноор нэмэгдэж, цөөн малтай малчин өрхүүд, ажилгүйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгүүдийг бий болгосон шалтгаануудыг судлах зорилготой. Мөн янз бүрийн эмзэг бүлгүүдэд авч хэрэгжүүлэх төрийн бодлогын нөлөөллийг судалжээ.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт нь ядуу өрх, нийгмийн эмзэг бүлгүүдийг шинээр бий болгосон шалтгаануудыг судалснаараа, цаашид ядуурлыг бууруулахад чухал санал, зөвлөмжийг агуулснаараа ач холбогдолтой ажил болжээ. Монгол Улсын шилжилтийн эдийн засгийн үр нөлөөг сонирхон судалж байгаа хүмүүст тустай байх болно.

#### 144

**Сонин, С. (Sonin, S.). (1999). "Reforming social sectors to alleviate poverty in Mongolia" (Монгол дахь ядуурлыг бууруулахад нийгмийн секторыг шинэчлэх нь).**

[http://www.worldbank.org/eapsocial/library/files/426\\_p8ssonin.pdf](http://www.worldbank.org/eapsocial/library/files/426_p8ssonin.pdf)

Өгцлэл, 9 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, нийгмийн секторын шинэчлэл, эрүүл мэнд

*JEL:* I30, H00, I10

Уг өгүүлэл нь өмнөх үг, нийгмийн секторын стратеги ба үйл ажиллагаа, нийгмийн секторын хөрөнгө оруулалт ба ядуурал, дүгнэлт гэсэн хэсгүүдээс бүрдэж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг хавсаргасан байна. Энэхүү өгүүлэлд нийгмийн секторын гол асуудал болон засгийн газрын оролцооны арга хэлбэрүүдийг харуулах замаар нийгмийн секторт хэрэгжүүлж буй стратегийг дэлгэрэнгүй харуулсан байна. Түүгчлэн нийгмийн секторт хийж байгаа хөрөнгө оруулалт, зардал нэмэгдэж байгаа тухай, ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн хамгаалал, тусламжид чиглэгдсэн хөрөнгө оруулалт нь ихэвчлэн богино хугацааны үйл ажиллагаа байдаг гэж дурьджээ. Ядуурал нь маш чухал асуудал байсан жишээ нь 1992-1997 оны

хооронд ядуурал эрс өссөн, ядуурлын нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөө нь анхаарал татах болсон, иймээс богино хугацааны арга хэмжээ авах шаардлагатай байсныг харуулжээ.

*Ядуурал ба нийгмийн салбарын шинэчлэлийн харилцан хамаарлыг сонирхон судалж байгаа оюутан, судлаачид, бодлого боловсруулагчид шинэ санаа, мэдээлэл авах боломжтой ажил болжээ. Ядуу хүмүүст шууд тусламж үзүүлэх нь урт хугацаанд үр ашиггүй, энэ нь ядуучуудын идэвхгүй байдлыг дэмжих болно гээд ядуурал болон нийгмийн салбарын хоорондох харилцан хамаарлыг аль аль талаас нь авч үзснээрээ ач холбогдолтой юм.*

#### 145

**Стивинсон, С. (Stevenson, S). (2001). "Mongolia". (Монгол Улс). The Indigo Foundation. [http://www.indigofoundation.org/pdfs/newsletters/July2001\\_Newsletter.pdf](http://www.indigofoundation.org/pdfs/newsletters/July2001_Newsletter.pdf)**

*Нийтлэл, 2 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, эрүүл мэнд

*JEL:* I10, I30

Уг нийтлэлд Монгол Улсад тулгарч буй асуудлын нэг болох хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг хөндөхийг зорьжээ. Зохиогч Монголын тухай өөрийн сэтгэгдлийг илэрхийлж, Австрали улстай Монгол Улсын гол гол үзүүлэлтийг харьцуулсан байна. Ядуурал нь Монгол Улсад тулгарч буй үндсэн асуудлуудын нэг гэдгийг тэмдэглээд 1990 оноос хойш ядуу хүмүүсийн тоо өссөөр байгаа, эдийн засгийн өөрчлөлт, аж үйлдвэрийн хувьчлалын үр дүнд ажилгүйдэл нэмэгдэж, хотын ядуучуудын байдлыг эрс муутгасан эдийн засгийн ийм хүндрэлийн улмаас ядуу хүмүүсийн эрүүл мэнд нэн хүнд байгааг дурджээ. Бор хоолонд орж байгаа үеэс 5 нас хүртэлх хүүхдүүдийн 30 хувь нь дутуу өсөлттэй байна гээд хүүхдийн хоол хүнсний илчлэгийн байдал нь эрүүл мэндийн доройтлын үндсэн шалтгаан юм гэжээ. Цаашид Монголын засгийн газар, гадаадын донор байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд Монголын хүүхдийн эрүүл мэнд сайжирч болох юм гэж найдаж байна гэжээ.

*Монгол дахь ядуурлын асуудлыг судлаж буй оюутан, судлаачдад зориулсан. Хүүхдийн эрүүл мэндэд ядуурал сөргөөр нөлөөлж байгааг энгийн үгээр өөрийн санал сэтгэгдэл байдлаар харуулснаараа онцлог болжээ.*

#### 146

**Сундарам, К (Sundaram, K). (2000). Human resource development and training in Mongolia: issues and options (Монгол дахь хүний нөөцийн хөгжил ба сургалт: үзэл бодол ба санал), <http://www.un-mongolia.mn/reports/files/FinalReportbySundaram.pdf>**

*Судалгааны тайлан, 101 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурлын хэмжээс, ажилгүйдэл, нэн ядуу, ядуурлын индекс

*JEL:* I32, E24, I30

Уг тайлан нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн асуудлуудыг судлан НҮБХХ-ийн Үндэсний Ажил Эрхлэлтийн Хуралдаанд материал бэлтгэж танилцуулах зорилготой. Тайлан



нь анхдагч болон хоёрдогч эх үүсвэрийн баримт материалууд, өгөгдлийг ашиглан тухайн үеийн төлөв байдалд дүн шинжилгээ хийсэн. Макро эдийн засгийн үнэлгээгээр 1990 оноос хойшхи Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн шинжилгээг хийсэн, ажил эрхлэлтийн, далд эдийн засгийн болон амьжиргааны түвшний судалгаа, судалгааны бусад материалуудыг ашиглан Монголын ажил эрхлэлт, ядуурал, боловсрол, сургалтын тогтолцоог судалсан байна. Эмзэг бүлэг, жижиг аж ахуйн нэгжүүд, албан бус секторын сургалт, сургалтын хэрэгцээ шаардлагын зөрүүгээр тодорхойлогдсон хөдөлмөрийн зах зээлтэй уялдаатай чадварын нийлүүлэлтийн талаарх чухал саналуудыг дэвшүүлсэн. Ядуурлын хүний нөөцийн хэмжээсийг тодорхойлж Монголын ядуучуудын боловсролын түвшинг судалж Ядуурлыг Бууруулах Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой боловсролын сургалтуудыг санал болгосон.

*Монгол дахь боловсролын тогтолцоог судлан ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад боловсролын оруулах хувь нэмрийг тодорхойлжээ. Албан бус боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, судлаачид ашиглахад тохиромжтой. Санал дэвшилцлэх хэлбэрээр бичигдсэн, Монголын онцлогийг харгалзан хийгдсэн дорвитой ажил болсон байна.*

#### 147

**Томас, Х. (Thomas, H.). (2004). Country gender assessment: Mongolia (Монгол Улсын жендерийн байдлын үнэлгээ), Asian Development Bank and World Bank.**

[http://www.worldbank.org/mn/documents/Mg\\_CGA\\_-\\_draft\\_4.pdf](http://www.worldbank.org/mn/documents/Mg_CGA_-_draft_4.pdf)

*Судалгааны тайлан, 81 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* жендер, ядуурал, эмэгтэйчүүд

*JEL:* J16, I30

Уг судалгааны тайлангийн зорилго нь Монгол Улсын жендерийн өнөөгийн байдалд шинжилгээ хийж, ядуурал, ажил эрхлэлт, өмч хувьчлал, эдийн засгийн өсөлт дэх жендерийн асуудал, нийгмийн тогтвортой хөгжил болон жендерийн байдлын харилцан уялдааг судалж дүгнэлт гаргасны үндсэн дээр Монгол Улсын жендерийн тулгамдсан асуудлуудыг шийдэх талаар зөвлөлгөө өгөхөд оршиж байгаа юм. Уг судалгааг Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банк хоёр хамтран хийжээ. Тус тайлан 7 бүлэгтэй, эхний бүлэгт Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн шилжилтийн ерөнхий байдлыг танилцуулж, дараахи бүлгүүдэд Монгол дахь ядуурлын асуудал, түүний хэмжил зүйн асуудлууд, ядуурлын жендерийн бүтцийн байдлыг судалж харуулсан. Ядуурлыг бууруулахын тулд Монгол Улс хэд хэдэн зорилго бодлогуудыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Мянган хөгжлийн хөтөлбөрийн ядуурлыг бууруулах бодлого нь жендерийн асуудалтай нягт уялдаатай тул тус бодлогын жендерт үзүүлэх нөлөөг шинжилсэн байна. Түүнээс гадна жендерийн хөгжилтэй холбоотой үндэсний бусад хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг танилцуулж, тухайлбал, Жендерийн тэгш байдлын төлөө үндэсний хөтөлбөр, жендерийн асуудлыг шийдэхийн тулд донор улсууд, олон улсын байгууллагуудаас Монголд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн талаар судалгаанд дэлгэрэнгүй тусгажээ. Монгол Улс эдийн засгийн өсөлтийг

нэмэгдүүлж ядуурлыг бууруулах бодлогыг баримталж байгаа учир эдийн засгийн өсөлт жендерийн байдалд үзүүлж байгаа нөлөө, ядуурлыг бууруулахын тулд хэрэгжүүлж байгаа нийгмийн халамжийн хөтөлбөр, бодлогуудын жендерийн талын асуудлыг судалгаанд оруулжээ. Тайланд жендэртэй холбоотой нийгэм, эдийн засгийн бусад асуудлууд, тухайлбал, өрхийн доторхи хүчирхийлэл, биеэ худалдах явдал, газрын хувьчлал ба эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар мөн дурдсан.

*Уг судалгаа Монгол Улсын Засгийн газар, донор байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх бодлогын жендерийн талыг гүнзгийрүүлэн судалж, Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж буй өнөө үеийн эдийн засаг, жендерийн байдлын уялдаа холбоог судалсан ажил юм. Эдийн засгийн бодлогын нөлөөг нийгмийн бүлгүүдээр, түүний дотор хүйсээр нь ялган тусгайлан авч судалсан байна. Уг ажил ядуурал ба эмэгтэйчүүдийн холбоо, эмэгтэйчүүд бодлого боловсруулахад оролцож буй байдлыг судалж, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрт жендерийн талаас шинжилгээ хийж, Монгол Улс дахь жендерийн тэгш эрхийн байдлыг сайжруулах талаар зөвлөлгөө, зөвлөмж өгсөн. Сүүлийн үеийн статистикийн тоо баримт, ядуурлын жендерийн шинжилгээ агуулсан, тэдгээрийн харьцуулсан судалгаатай, бодлого боловсруулагч байгууллагууд, мэргэжилтэн судлаач нар өргөн ашиглах боломж бүхий дэлгэрэнгүй судалгаа болсон.*

## 148

### **Үндэсний Статистикийн газар. (2002). Gender in Mongolia: Analysis based on the 2000 census (Монголын хүйсийн байдал: 2000 оны тооллогод үндэслэсэн судалгаа). Монгол, Улаанбаатар.**

*Тайлан, 107 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* жендэр

*JEL:* J16

Энэхүү тайлан нь 2000 оны Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллогын дүнд үндэслэн хүн ам зүйн хандлага, хэв маягт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг шалгах, нийгэм эдийн засгийн онцлог нөхцөл байдал, хэв маяг дахь хүйсийн ялгаатай байдлыг тайлбарлах зорилготой юм. 2000 оны тооллогод үндэслэн Монгол дахь жендэрийн асуудал, түүнд нөлөөлөгч хүчин зүйл, тулгарч буй бэрхшээлүүдийг олон талаас нь шинжилжээ.

*Статистикийн тоо, харьцуулсан судалгаа сайтай, жендэрийн асуудлыг тал бүрээс нь задлан шинжилсэн тул бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, судлаачид, оюутнууд өргөнөөр ашиглах боломжтой ажил юм. Цаашид уг сэдвээр хийгдэх судалгаануудын цр дүнг харьцуулан дүгнэх цед суурь дэвсгэр болохуйц цр дүнгүүд гаргаж авсан нь уг ажлын ач холбогдлыг тодорхойлж байна.*

149

**Хулдорж, Б (Редактор). (1999). Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Улаанбаатар: Адмон хэвлэл.**

**Khuldorj, B. (Ed.). (1999). Sustainable Development Program. Ulaanbaatar: Admon Press.**

*Баримт бичиг, 330 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* тогтвортой хөгжил, байгаль орчин

*JEL:* O10, Q00

Энэ бүтээл нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг тусгасан баримт бичиг юм. Байгаль орчны даац, цаг уурын өөрчлөлттэй уялдуулан хүн ардынхаа сайн сайхан амьдралыг баталгаажуулахуйц эдийн засгийн хөгжлийг тогтвортой хөгжил хэмээн ойлгоно гэжээ. Хөтөлбөр нь Нийгмийн тогтвортой хөгжил, Эдийн засгийн тогтвортой хөгжил, Байгалийн нөөцийн ашиглалт, Байгаль орчны хамгаалал, Хэрэгжүүлэх арга хэрэгсэл гэсэн үндсэн 4 хэсэг, 26 бүлэгтэй. Уг баримт бичигт Монгол Улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг нийгэм, эдийн засаг, байгаль орчны хүрээнд тодорхойлжээ. Түүнчлэн, Монгол Улсын тогтвортой хөгжлийн стратеги, 21 аймаг, нийслэл хотын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хураангуй зорилт, эдийн засаг, хүн ам, эрчим хүч, хөдөө аж ахуй, цаг уурын өөрчлөлтийн 2020 он хүртэлх хэтийн төсөөлөл зэргийг хавсаргажээ. Бүлэг тус бүр нь нийтлэг үндэслэл, зорилт, үйл ажиллагаа гэсэн дэд хэсгүүдээс бүрдэж байна. Хөтөлбөр нь ядууралтай тэмцэх арга зам гэсэн 3-р бүлэгтээ ядуурлын өнөөгийн байдлын талаар товч дурьдаж, ядууралтай холбоотой зорилтуудыг дэвшүүлэн, тэдгээрийг хэрэгжүүлэхийн тулд хийх үйл ажиллагааг зорилт тус бүрээр дэлгэрэнгүй бичжээ. Тогтвортой хөгжлийн үндэсний стратегид, ядуу буурай байдлыг үндэсний оршихуйн аюул хэмээн үзэж ойрын 10-15 жилд гэтлэн давах болно гэж заажээ.

Энэхүү хөтөлбөр нь түүний хүрээнд тавигдаж буй зорилт, үйл ажиллагаануудыг салбар тус бүрээр гаргаж тавьжээ. Ингэснээр Монгол Улсын болоод аймаг, нийслэлийн өмнө тавигдаж буй зорилт, хэрэгжүүлэх арга механизмын талаар олон нийт, судлаачдад тодорхой ойлголт төсөөлөл өгч, түүнийг өөрийн үйл ажиллагаа, судалгаанд ашиглах боломжоор хангаж байна. Гэвч салбар бус бүрийн өмнө тавигдаж буй зорилтууд нь өөр хоорондоо хэрхэн уялдаж, улмаар тогтвортой хөгжлийн нөхцлийг хэрхэн хангаж буй нь тодорхойгүй юм. Нөгөө талаар, хөтөлбөрийн хүрээнд тавигдаж буй зорилтууд нь голдуу чанарын зорилтууд байгаа бөгөөд тэр нь тооны хэлээр илэрхийлэгдээгүй байна. Хавсралтаар орсон 2000-2020 оны эдийн засгийн өсөлтийн тухай төсөөлөлд ашиглагдаж буй хувилбарууд нь байгалийн нөөц баялагийн ашиглалт, түүний экспортод түлхүү ач холбогдол өгсөн байна. Бусад хүчин зүйлс, тухайлбал, хувийн секторын хөгжил, мэдээллийн технологийн хөгжил, хөдөлмөрийн нөөцийн чанар, тоо хэмжээ хэрхэн нөлөөлөх талаар загварт тусгаагүй байна.

## 150

**Эрүүл Мэндийн Яам ба Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (Ministry of Health & World Health Organization), (2003). Contributing to Poverty Reduction through Improved Health Care (Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах замаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах нь). Монгол, Улаанбаатар.**

*Илтгэл, 31 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Эрүүл мэнд, ядуурал

*JEL:* I30, I10

Энэхүү илтгэл нь 2003 оны Доноруудын зөвлөлдөх уулзалтад зориулагдсан байна. Илтгэлд салбарын өнөөгийн байдал, гол тулгарч буй бэрхшээлүүд, эрүүл мэндийн бодлого, стратеги, тэдгээрийн үр дүн, цаашид анхаарвал зохих чиглэлүүдийг танилцуулжээ. Эхийн эндэгдэл сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа боловч малчин өрх, ядуу өрх болон ажилгүйчүүдийн дунд өндөр хэвээр байгаа болон нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний өнөөгийн байдал, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүд болон доноруудын зөвлөлдөх уулзалтад санал болгож буй төслүүдийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргажээ.

*Энэ нь судлаачид, оюутнуудад хэрэгтэй өргөн баялаг тоон мэдээлэл төдийгүй эрцэл мэндийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүд, тэдгээрийн үр дүнг агуулснаараа ач холбогдолтой.*

## 151

**Энхсайхан, М., нар. (1997). Нийгмийн хамгаалал. Монгол, Улаанбаатар.**

*Номын бэлэг, 8 хуудас, монгол*

*Түлхүүр үгс:* Нийгмийн хамгаалал, эмзэг бүлэг, нийгмийн даатгал, нийгмийн халамж

*JEL:* H55, I38, I30

Монгол улсын Засгийн Газраас баримталж байгаа эдийн засаг, нийгмийн бодлого, нэг жилийн хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагаа, цаашдын чиг хандлагатай олон нийтийг танилцуулах зорилготой. Ядуурал түүний үр дагаврыг арилгах талаар төрөөс баримталж байгаа бодлого, үйл ажиллагааг авч үзжээ.

*Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр гэж юу болох, түүний хэрэгжилтийг 1996 оны байдлаар харуулсан нь ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн биелэлтийг олон нийтэд танилцуулахад ач холбогдолтой болжээ.*

## 152

**Rashaant Bag, Bulgan, Gobi-Altai and Uburkhangai: Mongolia. (Монгол Улс: Рашаант баг, Булган, Говь-Алтай, Өвөрхангай). Part II : Review of Good Practices from the Asia-Pacific Region. (Ази-Номхон далайн бүс нутгийн практикуудын тойм).**

[http://www.unescobkk.org/ips/ebooks/documents/clcgender/gender\\_pt2mongolia.pdf](http://www.unescobkk.org/ips/ebooks/documents/clcgender/gender_pt2mongolia.pdf)

*Номын бэлэг, 5 хуудас англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, хүйсийн тэгш байдал

*JEL:* J16, I30

Энэхүү ажил нь хэд хэдэн орон нутагт эмэгтэйчүүдийн ядуурлын шалтгааныг тодорхойлж, ядуурлыг шийдвэрлэсэн туршлагын үр дүнг танилцуулах зорилготой. Монголын эмэгтэйчүүд хүйсийн ялгаварлалд харьцангуй өртөөгүй мэт анх харагддаг боловч эмэгтэйчүүдийн хувьд зарим нэг хүндрэлтэй асуудлууд байдгийг хөнджээ. Жишээ нь, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн ядуурал, төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага, үр хөндөлт өндөр зэрэг асуудлууд байна. Хэдийгээр суурь боловсрол үнэ төлбөргүй боловч ядуурал өсч байгаа нь ядуу хүүхдүүдийн хувьд сургуульд суралцахад тэгш бус байдлыг улам нэмэгдүүлж байна. Судлаачид Завханы Рашаант баг, Булган, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн эмэгтэйчүүдийн дунд судалгаа явуулсан байна. Судалгааны дүнд эмэгтэйчүүдээс нийгмийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх, хүйсийн мэдрэмжтэй сургалтыг эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алинд адил тэгш явуулах нь чухал гэсэн зөвлөмжийг өгсөн байна.

*Уг ажлыг жендэр, ядуурлын асуудлыг сонирхож буй оюутнууд, судлаачид, бодлого боловсруулагчид уншиж шинэлэг санаа, мэдээлэл авах боломжтой юм. Эмэгтэйчүүдийн ядуурлын шалтгаан нь тухайн орон нутаг бүрт харилцан адилгүй, уг шалтгаанаас нь хамааран эмэгтэйчүүдийн ядуурлыг бууруулахад тохирох бодлогыг орон нутаг тус бүрт туршишлын байдлаар хэрэгжүүлсэн нь сонирхолтой, цр өгөөжтэй болжээ.*

## 153

**Report on situation analysis study of Mongolia`s reproductive health services conducted by staff of the Ministry of Health and social welfare (Монгол Улсын НХХЯ, ЭМЯ-наас хийсэн ажилчдын нөхөн үйлдвэрлэлийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдсон судалгааны нөхцөл байдлын илтгэл). (2000)..**

[http://www.un-mongolia.mn/reports/files/rh\\_needs\\_eng.pdf](http://www.un-mongolia.mn/reports/files/rh_needs_eng.pdf)

*Илтгэл, 74 хуудас, англи, монгол*

*Түлхүүр үгс:* нөхөн үржихүйн эрүүл мэнд

*JEL:* J13, I11

Судалгааны зорилго нь Нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой Монгол Улсын Засгийн газрын стратегийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай мэдээллээр хангах явдал болно. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа нь Нөхөн үржихүйн эрүүл мэндээр Монголд хийгдэж буй анхны судалгаа юм. Энд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдсон олон чухал

асуудлуудыг хөндөж тавьсан байна. Энэхүү судалгаа нь НҮБХАС-ийн Монголд туслах хоёрдогч орнуудын хөтөлбөрийн хүрээн дэх үйл ажиллагааны нэг юм. Ядуу өрхүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ, тэр дундаа, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжид эдийн засгийн нөхцөл байдал нөлөөлдгийг онцлон тэмдэглэсэн байна. Монголын ард түмэн нөхөн үржихүйн чанартай үйлчилгээ, мэдээллээр хангагдахын тулд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талбарт их хэмжээний өөрчлөлт хийх шаардлагатай байгааг судалгааны дүн харуулж байна.

*Судалгаанаас гарсан цр дүнгүүд нь Эрцүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд гарын авлага болохуйц санал, дүгнэлтийг агуулсан, бодлогын цаашдын хэрэгжилтэд анхааралтай хандахад ач холбогдолтой ажил болжээ. Нөхөн үржихүйн эрцүл мэндийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг судалж буй бүх хүн ашиглахад тохиромжтой.*

## 154

**Орон нутагт ядуурал, ажилгүйдэл буурч, сургууль завсардалт нэмэгджээ. (2000.04.20). Зууны мэдээ, № 92 (359).**

*Нийтлэл, монгол*

*Түлхүүр үгс:* орон нутгийн ядуурал, ажилгүйдэл

*JEL:* I30, E24

Орон нутагт ядуурал, ажилгүйдэл буурсан нь засаг дарга нарын ажилд гарсан ахиц гэж засгийн газар үнэлжээ. Энэ байдлыг аймгуудаар тодорхойлж, цаашид анхаарах асуудлуудыг хөндсөнөөрөө ач холбогдолтой болжээ.

*Энэ нийтлэлээс тухайн үеийн орон нутгийн үйл ажиллагаа, тухайлбал ядуурал, ажилгүйдлийг бууруулах талаар хийсэн ажлууд, авч буй арга хэмжээний тухай мэдээлэл авч болно. Мөн зарим аймагт сургууль завсардалт нэмэгдсэнийг тоо баримтаар харуулжээ.*

3

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

155

**Хүний Эрхийн Үндэсний Комисс. (2002). Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай Илтгэл-2002. Монгол, Улаанбаатар.**

**National Human Rights Commission. (2002). Report on Human Rights and Freedoms in Mongolia 2002, Mongolia, Ulaanbaatar.**

*Илтгэл, 59 ба 63 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* нийгэм-эдийн засгийн эрх, эрх чөлөө

*JEL:* H80

Уг илтгэлийг Хүний Эрхийн Үндэсний Комиссоос байгуулагдан ажилласан нэг жил гаруйн хугацаанд явуулж ирсэн үйл ажиллагаа, бие даан болон бусадтай хамтарч хийсэн судалгаа, төрийн болон төрийн бус байгууллагуудын сэдэвчилсэн, хэсэгчилсэн зарим судалгаа, тайлан, хяналт, шалгалтын ажилдаа тулгуурлан Хувийн эрх, эрх чөлөө, Улс төрийн эрх, эрх чөлөө, Эдийн засгийн эрх, эрх чөлөө, Нийтийн эрх, эрх чөлөө гэсэн үндсэн 4 бүлгээр гаргасан байна. Илтгэлд дунд, түүнээс доош амьжиргаатай өрхүүдийн хувийн өмчийн эрхийг илтэд зөрчиж байгаа, хөдөлмөрөө хангалттай үнэлүүлж чадахгүй эрхээ зөрчүүлж байгаа, нийгмийн халамжийн тогтолцоо хангалтгүй, халамжийн мөнгийг буруу тооцож дутуу баталдаг, албан тушаалтнууд дураараа хасаж багасгадаг, өөрөөр хэлбэл хуулиуд нь өөр хоорондоо зөрчилтэй, нийгэмд ядуучууд улам бүр нэмэгдэн, ядуурлын сөрөг үр дагаварууд хүний зайлшгүй эдлэх эрх, үйл ажиллагаанд муугаар нөлөөлж байгааг дурджээ.

*Уг илтгэлийг олон нийтэд зориулан гаргасан учир хэн ч ашиглах боломжтой юм. Ядуурал, ядууралтай холбоотой асуудлууд, хүний эрх, эрх чөлөө гэсэн ойлголтууд бие биедээ хэрхэн нөлөөлж байгаа, эдгээрийн зөрчлийн талаар илтгэлээс мэдэх боломжтой. Ер нь хууль эрх зүйн орчин, тцүнийг бүрдүцүлж буй хуулиуд нь амьдралд нийцсэн байдал, төрөөс хэрэгжүцүлж буй цүйл ажиллагаатай дээрх зарчмаар холбоотой байна гэж дүгнэжээ.*

156

**Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. (2003). Нийгмийн эмзэг бүлгийн эрхийн төлөв байдал, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2003.**

**Монгол, Улаанбаатар: Хаан Принтинг ХХК.**

**National Human Rights Commission. (2003). Report on Human Rights and Freedoms in Mongolia 2003. Report on Human Rights and Freedoms of Mongolia. Ulaanbaatar: Khaan Printing Co. Ltd.**

*Илтгэл, 28 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* хуулийн орчин, хүүхдийн эрх, нэн ядуу иргэд

*JEL:* I30, K00

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэлийн нэгдүгээр бүлэг нь нийгмийн эмзэг бүлэгт багтдаг хүүхэд, тахир дутуу хүмүүс, нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлыг хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийн хүрээнд авч үзсэн байна. Бүлгийн нэгдүгээр хэсэгт, хүүхдийн эрхийн төлөв байдлыг судалжээ. Монголд хүүхдийн эрх зарим тохиолдолд хуулийн орчинд зөрчилтэй



байгаа талаар тэмдэглэсэн байна. Хоёрдугаар хэсэгт, тахир дутуу иргэдийн эрхийн хуулийн орчин, түүний хэрэгжилтийн төлөв байдлыг судалжээ. Бүлгийн гуравдугаар хэсэгт, нэн ядуу иргэдийн эрхийн төлөв байдлыг судалжээ. Илтгэлээс үзвэл нэн ядуу иргэдэд дэмжлэг үзүүлдэг гол суваг механизм нь нийгмийн халамжийн үйлчилгээ боловч жигд, хүртээмжтэй байж чадахгүй байна.

*Энэхүү илтгэл нь нэн ядуу иргэдийг хамарсан анхны дорвитой судалгаа юм. Судалгаанд хоёрдогч эх үүсвэр материалууд, холбогдох байгууллагуудаас авсан сүцлийн үеийн тоо, баримт ашиглаад зогсохгүй орон нутагт тандалтын судалгаа хийж түүнийг үр дүнгээр баяжуулжээ. Хуулийн орчныг танилцуулж, хэрэгжилтийг түүнтэй харьцуулсан нь судалгааг логик дэс дараалалтай, ойлгомжтой болгосон байна. Ялангуяа, тахир дутуу иргэд, нэн ядуу иргэдийн талаар баялаг тоон мэдээлэл ашигласан нь судлаачид, оюутнууд ядууралтай холбоотой асуудлаар цаашдын судалгаандаа ашиглах боломжтой болгожээ.*

## 157

**НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. (2003). National action programme on strengthening human rights in Mongolia (Монгол дахь хүний эрхийг бэхжүүлэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр). [http://www.un-mongolia.mn/news/NHRAP\\_5-11-2002.pdf](http://www.un-mongolia.mn/news/NHRAP_5-11-2002.pdf)**

*Тайлан, 8 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны нөхцөл, нийгмийн сайн сайхан байдал  
*JEL:* I30, H00

Уг хөтөлбөрийн зорилго нь социалист системийн үед тогтож бий болсон уламжлалт харилцааг арилгах, нийгэмд шинэ оюун санааг төлөвшүүлэх, хуулийн ухамсарыг дээшлүүлэх, хүний эрхийг хангах, хамгаалах, урамшуулах үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах явдал юм. Хүний эрхийн хамгаалал нь хүн амын амьжиргааны түвшний сайжралт, үндэсний чадавхийн хүчтэй байдлаас хамаарал багатай байдаг. Өмчийн эрхийн хамгаалал, ялгаварлалгүй хандах зэрэг нь эдийн засгийн илүү эрчтэй хөгжлийг урамшуулах, ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэх таатай орчинг бүрдүүлдэг. Хөтөлбөрийн хүрээнд хүний үндсэн эрхийг хангах хэмжүүрүүдийг тодорхойлж, хүний эрхийг хэрэгжүүлэх, хянах олон улсын гэрээ хэлэлцээр, хандлагуудыг дурьдсан.

*Хүний эрхийн асуудлыг сонирхон судлаачид болон бодлого боловсруулагч нар ашиглахад тохиромжтой. Нийгмийн хамгаалал, эрцл мэнд, боловсролын эрхүүдийг тусгайлан авч үзсний зэрэгцээ олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг тусгасан нь ач холбогдолтой болжээ.*

## 158

**Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль**

*Түлхүүр үгс:* Амьжиргааны доод түвшин, хэрэглээний доод хэмжээ  
*JEL:* I30, I32, I31

**Хуулийн зорилт:**

Энэ хуулийн зорилт нь хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлохтой холбогдсон

харилцааг зохицуулахад оршино.

**Хуулийн тухай товчхон:**

Энэ хууль нь 7 зүйлтэй, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Хуулийн 3.1.1-д зааснаар “ амьжиргааны доод түвшин ” гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлнэ. Энэхүү хуулинд хэрэглээний доод хэмжээг тогтоох, хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох, хэрэглэх болон хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтын талаар тодорхой заажээ.

**159**

**Нийгмийн даатгалын тухай хууль**

*Түлхүүр цгс:* Нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл  
*JEL:* H55

**Хуулийн зорилт:**

Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоож, нийгмийн даатгалд даатгуулж шимтгэл төлөх, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, зарцуулах болон нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хуулийн тухай товчхон:**

Энэ хууль нь 6 бүлэг, 33 зүйлтэй, 1994 оны 5-р сарын 31 өдрөөс эхлэн мөрдөгдөж байна. Хуулийн 3-р зүйлд зааснаар “Нийгмийн даатгал” гэдэг нь иргэн болгон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээг хэлнэ. Энэ нь тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний болон ажилгүйдлийн даатгалын төрлүүдээс бүрдэнэ. Энэ утгаараа нийгмийн эмзэг бүлэг, өндөр настан, ажилгүйчүүд, тодорхой хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдагсдын амьдралыг дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг багтаасан байна.

**160**

**Боловсролын тухай хууль**

*Түлхүүр цгс:* боловсрол, магадлан итгэмжлэл, багш, сурган хүмүүжүүлэгч  
*JEL:* I20

**Хуулийн зорилт:**

Энэ хуулийн зорилт нь боловсролын тогтолцоо, үндсэн зарчим, агуулга, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэдийн сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

**Хуулийн тухай товчхон:**

Энэ хууль нь 7 бүлэг, 42 зүйлтэй, 1995 оны 8 сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байна. Хуулийн 3-р зүйлд зааснаар боловсролын зорилго нь иргэнд эрүүл чийрэг бие бялдар, оюуны зохих чадавхитай, хуулийг дээдлэн сахидаг, хүмүүнлиг, ёс суртахуун, гоо зүйн мэдрэмж, таашаал олж, бие даан сурч амьдрах чадвартай болоход нь үйлчлэхэд оршино. Энэ хуулиар боловсролын байгууллагын тогтолцоо, боловсролын мэргэжлийн хяналт, төрөөс боловсролын байгууллагыг санхүүжүүлэх зэрэг асуудлыг тодотгон зааж өгчээ.

**161****Эрүүл мэндийн тухай хууль**

*Түлхүүр цгс:* эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмчлэх сувилах

*JEL:* I10

**Хуулийн зорилт:**

Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хангахад байгууллага, аж ахуйн нэгж, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хуулийн тухай товчхон:**

Энэ хууль нь 7 бүлэг, 52 зүйлтэй, 1998 оны 7 сарын 1-нээс хэрэгжиж эхлэн мөрдөгдөж байна. Энэ хуулийн 3.1.3-т зааснаар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэг нь хүн амын эрүүл мэндийн байдлыг тандах, хянах, хамгаалах бэхжүүлэх, өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, анагаах ухааны сургалт, эрдэм шинжилгээний ажил явуулах, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хүчин зүйлийг судлах тэдгээрийг арилгахад чиглэгдсэн эрүүл мэндийн байгууллагын бие даасан болон төр, олон нийт, байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран явуулах үйл ажиллагааг хэлнэ. Энэ хууль нь иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулахад чиглэгджээ.

**162****Нийгмийн халамжийн тухай хууль**

*Түлхүүр цгс:* эмзэг бүлэг, нийгмийн халамж.

*JEL:* H55, I38

**Хуулийн зорилт:**

Энэ хуулийн зорилт нь нийгмийн халамжийн төрөл, хамрах хүрээг тогтоож, нийгмийн халамжийн санг бүрдүүлэх, зарцуулах эрх зүйн үндэс, нийгмийн халамжийн үйл ажиллагааг эрхлэх байгууллага, албан тушаалтны чиг үүргийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**НОМ ЗҮЙ****Хуулийн тухай товчхон:**

Энэ хууль нь 7 бүлэг, 37 зүйлтэй, 1999 оны 1 сарын 1-ээс эхлэн мөрдөгдөж байна. Хуулийн 3.1.1-д зааснаар “Нийгмийн халамж” гэж хүн амын эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх, хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эх /эцэг/ болон ихэр хүүхдэд тэтгэмж олгох агуулга бүхий нийгмийн хамгааллын арга хэмжээг хэлнэ. Энэ нь нийгмийн эмзэг бүлэг, ялангуяа нэн ядуу амьдралтай иргэдийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн нийгмийн халамжийн арга хэмжээнүүдийг багтаасан байна.

**163****Хөдөлмөрийн тухай хууль**

*Түлхүүр цгс:* ажил олгогч, ажилтан, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн маргаан

*JEL:* J50, K41

**Хуулийн зорилт:**

Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.

**Хуулийн тухай товчхон:**

Энэ хууль нь 15 бүлэг, 142 зүйлтэй, 1999 оны 7 сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Энэ хуулиар хөдөлмөрийн гэрээний болон түүнээс уламжилсан хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулна.

**164****Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль**

*Түлхүүр цгс:* эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж, даатгалын сан

*JEL:* H55, I10

**Хуулийн зорилт:**

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэнд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг тогтоох, эрүүл мэндийн даатгалыг бий болгох, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, даатгалын болон эрүүл мэндийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**Хуулийн тухай товчхон:**

Энэ хууль нь 4 бүлэг, 15 зүйлтэй, 2002 оны 4 сарын 25 өдрөөс хэрэгжиж эхлэн мөрдөгдөж байна. Хуулийн 4-р зүйлд зааснаар “Эрүүл мэндийн даатгал” гэдэг нь иргэн болон төр, аж

ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу даатгалын хураамж төлж, даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, даатгуулагчийг хэвтэн эмчлүүлэхэд гарах эмчилгээ, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээг хэлнэ. Энэ хууль нь Монгол Улсын бүх иргэдэд түүний дотор 16 нас хүртэлх хүүхэд, тэтгэврээс өөр орлогогүй иргэн, тахир дутуу хүмүүс, нийгмийн халамжид хамрагдсан иргэд зэрэгт үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний арга хэмжээг тодорхойлон зохицуулж байгаагаараа онцлог юм.

## 165

### **(2001). Country strategy for development co-operation with Mongolia, 2002-2006 (Монголтой хийх хөгжлийн хамтын ажиллагааны стратеги, 2002-2006).**

*Баримт бичиг, 13 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны түвшин, ажилгүйдэл, орлогын ялгаа  
*JEL:* I30, I31, E24, D31

Уг баримт бичгийн зорилго нь Монгол Улс ба Шведийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиг хандлагыг тодорхойлох юм. Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хөгжлийн бодлогыг авч үзсэн. Хамтын ажиллагаа хэрэгжүүлж байсан туршлагыг танилцуулж, хамтын ажиллагаанд чухалчлан авч үзэх асуудал бол ядууралтай тэмцэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх гэж онцгойлон дурьдсан. Хамтын ажиллагааны хөгжлийн цаашдын зорилгыг шинэчлэлийн үйл явцыг дэмжих, нийгмийн ардчилсан хөгжил болон хүний эрхийг урамшуулснаар ядуурлыг арилгахад хувь нэмрээ оруулах явдал гэж тодорхойлсон байна.

Хамтын ажиллагааг сонирхогчид, бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид ашиглах боломжтой баримт бичиг болсон байна. Монгол-Шведийн хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх чиглэл, хэлбэр, хамрах хүрээг тодорхойлон гаргасан нь чухал ач холбогдолтой болсон байна.

**4**

**ΥΛΟΤΗΡ**

## 166

**Батбаяр, Ц. (2002). Монгол Улсын дотоод бодлогод хандивлагчдын хамтын нийгэмлэгийн нөлөөлөл. Зүүн хойд Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлс (х 51-58). Монгол, Улаанбаатар.**

**Batbayar, Ts. (2002). Donor community as a factor in domestic politics of Mongolia. Political, security, economic and infrastructure factors of economic cooperation in the northeast Asia (x 48-55). Mongolia, Ulaanbaatar.**

*Судалгааны тайлан, 8 хуудас, монгол, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурлыг бууруулах стратеги, хүний хөгжил

*JEL:* I38, O10

Уг судалгааны зорилго нь Монгол Улсын бодлогод хандивлагчдын үзүүлж буй нөлөөг гол хандивлагч байгууллагуудын үйл ажиллагаагаар төлөөлүүлж тодорхой харуулсан. Олон улсын байгууллагуудтай Монгол Улсын хамтарсан үйл ажиллагаа, сэдэвчилсэн бүлгийн хуралдаануудыг он дарааллаар авч үзсэн. Эдгээр хуралдаануудаас голлон анхаарсан чиглэлүүд нь засаглал, хувийн хэвшил, ядуурал, хувьчлал, эдийн засгийн өсөлт зэрэг болно. Монголд туслах бүлгийн жилийн хуралдаанууд нь олон улсын болон үндэсний өрсөлдөөний зорилго, хэтийн төлөвтэй холбогдсон нөлөөлөл, зөрчлийн талаар нээлттэй хэлэлцүүлэг болж чадаагүй байна гэж дүгнэжээ.

*Монгол Улсаас олон улсын хандивлагч байгууллагуудтай харилцаж буй талаар баялаг мэдээлэл агуулсан байна. Судлаач, оюутнууд хэрэглэхэд тохиромжтой. Хамтын ажиллагааны ололт ба дутагдалтай тал, цаашид анхаарах асуудлуудыг авч үзсэнээрээ ач холбогдолтой болжээ.*

## 167

**Блаксал, Ж. (Blaxall, J.). (2000). “Governance and Poverty”. (Засаглал ба ядуурал).**

**Ядуурлыг бууруулах стратегийн талаарх хамтарсан семинар. Монгол.**

**<http://www.worldbank.org/poverty/strategies/events/mongolia/gov.pdf>**

*Илтгэл, 4 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, засаглал ба ядуурал

*JEL:* I38, H00, I30

Энэ илтгэлийн зорилго нь ядуурал ба засаглалын хамаарлыг Монголын жишээн дээр авч үзэх явдал юм. Сайн засаглал нь ядуурлыг бууруулдаг бол муу засаглал нь ядуурлыг нэмэгдүүлдэг. Сайн засаглал нь ядуурлыг бууруулах аливаа стратегийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. 2000 онд “Монголын амьжиргааны түшний оролцооны аргын судалгаа”-ны анхны хувилбар гарсан. Энэ судалгаанд хамрагдсан ядуучуудтай хийсэн ярилцлагаас үндэслэн засаглалын үндсэн асуудлуудыг ядуучууд хэрхэн үзэж байгааг харуулсан байна.

*Судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан. Ядуурлыг бууруулахад засаглал нэн чухал хүчин зүйл гэдгийг хөндсөн сонирхолтой илтгэл болсон байна.*

168

**Дэлгэрцогт, Д. “Good governance and its effect on poverty: public sector reforms in Mongolia”. (Сайн засаглал, түүний ядууралд үзүүлж буй нөлөө: Монгол дахь нийгмийн секторын шинэчлэл). [www.worldbank.org/eapsocial/library/files/373\\_p9ddelgert.pdf](http://www.worldbank.org/eapsocial/library/files/373_p9ddelgert.pdf)**

Өгцүлэл, 10 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, засаглал

*JEL:* I30, H00

Уг өгүүлэл нь Монгол Улсад хийгдэж байгаа нийгмийн секторын шинэчлэл, нийгэм, эдийн засагт үзүүлэх түүний нөлөөг тусгажээ. Монгол дахь бүтээлч удирдлага, төрийн санхүүгийн шинэчлэл нь засгийн газрын зардлын хуваарилалт болон оновчтой байдлыг сайжруулах болно. Засгийн газрын зардлын зарцуулалтын менежмент сайжирснаас дэд бүтэц, эдийн засагт нөөцийг илүү сайн хуваарилж, энэ нь нийгмийн сектороор дамжин эдийн засгийн өсөлт бий болох нөхцлийг бүрдүүлдэг гэж дүгнэжээ.

*Засаглал нь нийгэм, эдийн засгийн хөгжилд маш чухал нөлөөтэй гэдгийг онцолсноороо ач холбогдолтой. Засаглал ядууралд нөлөөлдөг талаар сонирхон судлаж байгаа эрдэмтэн судлаачид, оюутнууд, бодлого боловсруулагчид ашиглахад тохиромжтой.*

169

**Османи, С.Р (Osmani, S.R). Participatory Governance and Poverty Reduction (Засаглалын оролцоо ба ядуурлыг бууруулах).**

<http://www.undp.org/dpa/publications/choicesforpoor/ENGLISH/CHAP05.PDF>

Өгцүлэл, 23 хуудас, англи

*Түлхүүр үгс:* сайн засаглал, төвлөрлийг сааруулах, ядуурлыг бууруулах

*JEL:* I38, H00

Судлаач уг ажилдаа сүүлийн үед НҮБХХ, Дэлхийн Банк, олон улсын бусад байгууллагуудаас сайн засаглал, ядуурлын бууралт хоёрын хооронд маш олон шууд хамаарлууд байдгийг өөрсдийн судалгаа, илтгэл, тайландаа тэмдэглэн, тодруулах болсныг авч үзээд НҮБХХ-өөс санхүүжүүлэн 1997-1999 онуудын хооронд ядуурлыг бууруулах үйл ажиллагааны хүрээнд хэд хэдэн оронд хийсэн судалгаанаас дээрх хамаарлыг тодорхойлох зорилго тавьсан. Энэ нь засаглалын нэг бүрдэл болох орон нутгийн түвшин дэх засаглал дээр төвлөрчээ. Энэ чиглэл төвлөрлийг багасгах, хүмүүсийн засаглах эрх, орон нутгийн байгууллагуудын оролцоо зэргийг сайжруулах асуудлуудтай холбоотой бөгөөд энд хийгдэх ямар ч шинэчлэл нь ядуурлыг бууруулахтай мөн холбогдож байдгийг дурдсан байна. Судлаач дээрх хүчин зүйлүүдийг улс орнуудын жишээн дээр үндэслэн шинжилж, үр дүн гаргаж, улмаар засаглал, ядуурлын бууралт хоёрын харилцан хамаарлын талаар зарчмын хэд хэдэн санал, зөвлөмжийг гаргажээ.

*Энэхүү судалгаанд Монгол Улсын засаглалын өнөөгийн байдал, ололт амжилт, алдаа дутагдал, сул талууд байгаа тухай ч судлаач дүгнэжээ. Энэ нь ядуурлыг бууруулах бодлогын сүүлийн үеийн нэг үзэл, хандлага бөгөөд цүннийг сонирхсон оюутан, судлаач*



эрдэмтэд судалгаа, шинжилгээгээ хандуулах нэг сэдэв болгон авч хөгжүүлэх боломжтой юм. Энэ утгаараа тухайн ажил нь онолын болон практикын ач холбогдолтой болжээ.

## 170

**Помфрет, Р (Pomfret, R). (1999). Transition and democracy in Mongolia (Монголын шилжилт ба ардчилал),**

**<http://www.economics.adelaide.edu.au/staff/pomfret/mongolia99.pdf>**

*Судалгааны тайлан, 18 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, хот, хөдөөгийн шилжилт

*JEL:* I30, O15

Судалгааны тайлангийн зорилго нь шилжилтийн үед ардчиллын гүйцэтгэх үүрэг, 1990-ээд оны үеийн Монголын төрийн бодлого, бодлогын хэрэгжилтэнд шинжилгээ хийх юм. Өнөөг хүртэл шийдэгдээгүй хуримтлагдсан олон асуудлууд байгаа хэдий ч Монголын нөхцөл байдал нь эдийн засгийн шинэчлэл, эдийн засгийн хөгжил буюу шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогуудад ардчиллын үзүүлэх нөлөөг харуулах тодорхой жишээ болж чадах юм. Ардчилсан тогтолцоо нь эдийн засгийн либерализмд улс төрийн эерэг элемент болж чадсан байна гэж дүгнэжээ.

*Монгол Улсын шилжилтийн үеийн болон ядууралтай холбоотой асуудлуудын талаар ойлголт авахад тохиромжтой. Оюутан сурагчид, эрдэмтэн судлаачид ашиглах боломжтой.*



# 5

## БАЙГАЛЬ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН



171

**Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank). (2002). Mongolia's environment: Implications for ADB's operations (Монгол Улсын байгаль орчин: Азийн Хөгжлийн Банкны үйл ажиллагааны оролцоо),**  
[www.adb.org/Documents/Studies/Mongolia\\_Environment/MON\\_Environment\\_Study.pdf](http://www.adb.org/Documents/Studies/Mongolia_Environment/MON_Environment_Study.pdf)

Тайлан, 79 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, амьжиргааны түвшин, орлого

*JEL:* I30, D31

Энэхүү тайлан нь Монголын байгаль орчны өнөөгийн төлөв байдлыг судлах, байгаль орчны салбарт Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банкны цаашдын хамтын ажиллагааны талаар зөвлөмж боловсруулах зорилготой. Монгол орны хувьд байгаль орчны нөхцөл байдал, ядуурал нь өөр хоорондоо салшгүй холбоотой. Азийн Хөгжлийн Банк өсөлтийг дэмжих бодлогод чиглэхээсээ ядуурлыг бууруулахад илүү анхаарлаа хандуулж, ядуурлыг арилгах зорилтыг байгаль орчны асуудалтай холбож үзэх болжээ. АХБ болон Монгол Улсын хамтын ажиллагаа, түүний үр нөлөөг тайлангийн хүрээнд судалсан.

*Сүүлийн үед ихээхэн анхаарал татаж буй байгаль орчны асуудал, ядуурлын харилцан хамаарлыг тодорхойлсон. Судлаачид, бодлого хэрэгжүүлэгч нар ашиглахад тохиромжтой. Монгол Улсын хувьд энэ харилцан хамаарал нь анхаарах асуудлуудын нэг болоод байгааг цохон дурьдсан байна.*

172

**Мөнхцэрэн, С (Munkhtseren, S)., Гэрэлчимэг, Ч (Gerelchimeg, Ch). (2001). Disaster Mitigation Financial Resources and Their Allocation in Mongolia (Монгол дахь гамшгийн хохирлыг бууруулах санхүүгийн нөөц ба түүний хуваарилалт). Монгол, Улаанбаатар.**  
<http://www.un-mongolia.mn/.../disaster/reference/vangelder/conference%20papers/munkhtseren%20and%20gerelchimeg.pdf>

Өгцүлэл, 19 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Гамшиг, гамшгийн удирдлага

*JEL:* H56

Сүүлийн үед манай улсад тохиолдож буй байгалийн гамшиг ган, зудны үзүүлж буй хор хохирол, нөлөөлөл, үлдэж буй сургамж зэргээс гамшгийн талаарх уламжлалт ойлголт, мэдлэгийг шинээр дахин тодорхойлох шаардлагатай байгааг харуулжээ. Гамшгийн талаарх малчдын мэдлэг, туршлага хангалтгүй, үргэлжилсэн ган, зуд нь малын тоо толгойг 33 саяас 26 сая хүртэл үлэмж хэмжээгээр хорогдуулснаар олон малчин өрхийн амьжиргаанд ноцтой хохирол учруулж, ул орны ядуурлын өсөлтөнд хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн. Нөгөө талаас гамшгийн цар хүрээ, хүчтэй байдал нь урьдчилсан бэлтгэлгүй байснаас шалтгаалж байгаа нь гамшгийн удирдлагын бодлого чухал юм гэдгийг илтгэж байна гээд ийм нөхцөл байдалд энэ ажил нь гамшгийн удирдлагын тогтолцоон дахь улсын төсөв, санхүү, банк, даатгалын нөхцөл байдалд өөрийн

санал бодлоо илэрхийлэх, Гамшгийн Удирдлага, түүний санхүүгийн чиглэлээрх ЗГ-ын бодлогыг үнэлэх зорилгоор хийгджээ. Ядууралтай холбоотой үр дүнгээс нь дурдвал, ... малын гаралтай түүхий эдийн экспортын хандлага нь малын чанарыг бус тоо толгойг нэмэгдүүлж байна. Малчдын эмзэг байдал нь богино настай нөөц, малын үр ашгийн талаарх сайн дадлага туршлага, мэдлэг мэдээллийн хангалтгүй байдлаас болж улам нэмэгдэж байгаа ба эдгээр дарамт нь тэдгээрийн эмзэг байдлын түвшин болон олон малчдыг ядууралд оруулж байна... гэж дүгнэжээ.

*Уг өгцлэл нь гамшиг ядуурал, эмзэг байдалтай хэрхэн холбогддогийг авч үзсэнээрээ ач холбогдолтой. Судлаачдын дэвшилцсэн гамшигийн цр дагавар буюу эмзэг байдал, ядуурлыг бууруулахад чиглэсэн санхүүгийн олон янзын арга хэмжээ, төсөл хөтөлбөрцүд, хууль ямар байх талаарх санаа бодол, цаашид анхаарах санал, зөвлөмжцүдийг олж авах боломжтой.*

### 173

**Начин, Д. Small-Scale Energy Development in Northeast Asia: Experience, Prospects and Social Implications of Solar PV in Mongolia (Зүүн Хойд Ази дахь бага оврын эрчим хүчний хөгжил: Монголын нарны эрчим хүч ашиглалтын туршлага, хэтийн төлөв, нийгмийн ач холбогдол).**

<http://www.erina.or.jp/En/Research/db/rep14/RS-LE/02160e.pdf>

*Судалгааны тайлан, 16 хуудас, англи*

*Түлхүүр үгс:* Ядуурал, эрчим хүч

*JEL:* Q20, Q32

Энэхүү тайлан нь бага оврын эрчим хүчний үүсгүүрийн ач холбогдлыг танин мэдүүлэхийг зорьсон байна. Бага оврын эрчим хүчний үүсгүүрийн ач холбогдол нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулахад оршдог. Бага оврын эрчим хүчний хөгжил нь хүмүүсийн амьжиргаа, нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ, мэдээллийн болон орчин үеийн холбоо харилцааны хүртээмж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулахад гол үүрэг гүйцэтгэж болох юм. Нөгөө талаас сэргээгдэх эрчим хүчийг ашиглахад бага оврын эрчим хүчний үүсгүүр зайлшгүй чухал гэж үзжээ.

*Энэ судалгааны тайлан нь бага оврын эрчим хүчний хөгжил, нийгэм эдийн засагт тцүний цзүцлэх нөлөөний талаар сонирхон мэдээлэл авахыг хцсч буй бцх хцмцүст зориулагдсан. Бага оврын эрчим хүчний хөгжил нь хцмцүсийн амьжиргаанд туслахын зэрэгцээ нийгмийн салбарын хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулах болно гэж үзжээ. Энэ судалгаа нь ядуурлын асуудлыг орлогын талаас нь төдийгүй, нийгмийн талаас нь хөндсөнөөрөө онцлогтой юм.*

## 174

**НҮБ-ын Гамшгийн Удирдлагын Баг, Улсын Иргэний Хамгаалалтын Газар, Онц Байдлын Улсын Комисс (UN Disaster Management Team /UNDMT/, National Civil Defence and State Emergency Commission). (2000). Dzud 2000: An Evolving Ecological, Social and Economic Disaster. A Rapid Needs Assessment Report (Зуд 2000: Учирч буй экологи, нийгэм, эдийн засгийн гамшиг. Яаралтай шаардагдах зүйлсийг үнэлсэн илтгэл).** <http://www.un-mongolia.mn/...>

Тайлан, англи хэлээр, 40 хуудас.

*Түлхүүр үгс:* Экологи, нийгэм-эдийн засгийн гамшиг, ядуурал  
*JEL:* I30, Z00

Энэхүү тайлангийн зорилго нь 1999-2000 онд тохиосон зуны ган, өвлийн зудны хамарсан аймаг, сум, үүссэн шалтгаан, нөхцөл байдал, үр дагавар зэргийг судалж Засгийн Газар, НҮБ болон олон улсын бусад байгууллагуудын шугамаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үзүүлсэн тусламж зэргийг тодорхойлж, танилцуулахад чиглэсэн байна. Ядуурлын асуудал нь гамшгийн үр дагавартай холбогдож малчин олон өрхүүдийг ядуурал, эмзэг байдал уруу хөтлөн оруулсан гэсэн дүгнэлт гаргасан байна. Бусад үр дагаварууд, хүнс тэжээлийн аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол зэрэгт үзүүлсэн гамшгийн нөлөөллийг бас тодорхойлсон. Эдгээрт малчин өрхийн амьжиргааны түвшний доройтол, ядуурал сөргөөр нөлөөлж, өөрөөр хэлбэл, гамшиг давхар нөлөөлж байгааг харуулжээ.

*Уг тайлангаас дотоод, гадаадын дээрх байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн бодлого, гамшигийн хохирлыг бууруулах, арилгах, цаашид урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цйл ажиллагаа, бодлого, шийдвэрийг мэдэж авах, уг гамшигийн учруулсан хохирол, ялангуяа ядуурал, эмзэг байдлыг тухайн бус нутгуудад нэмэгдүүлсэн талаарх статистик тоон мэдээллийг олж авах боломжтойгоороо ач холбогдолтой юм. Уг тайлан нь ядуурах эмзэг байдлыг хөндөн, дүгнэлтэндээ оруулж тусгайлан илэрхийлсэн нь ядуурлын асуудлуудыг илцү өргөн хүрээнд ойлгох улмаар оюутан, судлаач эрдэмтдэд тус дөхөм үзүүлж болох юм.*

## 175

**Шагдар, Э. The Mongolian Livestock Sector: Vital for the Economy and People, but Vulnerable to Natural Phenomena (Монголын мал аж ахуйн салбар нь эдийн засаг болон хүмүүст чухал ач холбогдолтой боловч байгалийн үзэгдэлд эмзэг).**

<http://www.erina.or.jp/En/Research/db/rep14/RS-LE/02160e.pdf>

Судалгааны тайлан, 14 хуудас, англи

*Түлхүүр үгс:* Ядуурал, мал аж ахуй  
*JEL:* I30, Q10

Монголын мал аж ахуй нь байгаль цаг уураас хэрхэн хамаардгийг судлах, байгалийн гамшгаас мал аж ахуйг хэрхэн хамгаалах талаар зөвлөмж гаргахад энэхүү судалгааны ажил

чиглэгджээ. Мал аж ахуй нь Монголын хүнсний болон хэрэглээний бүтээгдэхүүний нөхөн сэргээгддэг нөөцийг хангадаг чухал ач холбогдолтой салбар бөгөөд хүн амын талаас илүү хувь нь уг салбарт амьжиргаагаа залгуулдаг байна гэжээ. Үүнээс гадна, Монголын мал аж ахуйн хөгжлийн товч түүхийг авч үзэн, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулдаг монголын үйлдвэр, малын гаралтай бүтээгдэхүүнүүдийн тухай дэлгэрэнгүй тайлбарлажээ. Мал аж ахуйг монголын цаг уур, байгаль орчинтой холбож авч үзсэн байна. Хоёр жил дараалан ган зуд болсон нь хөдөө ядуурал өсөх шалтгаан болсныг дурдаад, эцэст нь зуд болон байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг санал болгосон байна.

*Судлаачид, бодлого боловсруулагчдад Монголын мал аж ахуйн талаар мэдээлэл, зөвлөмж өгөхцүйц тустай ажил болжээ. Мал аж ахуйн салбар, малын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийн үйлдвэрлэлийг нэлээд өргөн хүрээнд авч үзэж, хөдөө аж ахуйг эрсдэл, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх бодлогын зөвлөмж гаргаснаараа ач холбогдолтой юм. Энэхүү тайлан нь хөдөөгийн ядуурлыг бууруулахад байгалийн гамшгаас сэргийлэх арга хэмжээ нэн чухал гэдгийг хөндөж, тухайн асуудлыг бодлого боловсруулагчдын анхааралд хандуулан тавьж өгснөөрөө чухал юм.*



**XABCPAAT**

## ЗОХИОГЧДЫН НЭРСИЙГ ҮСГИЙН ДАРААЛААР, ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

